

ИРГЭДИЙН ОРОЛЦОО-АРДЧИЛАЛ  
ТӨСӨЛ

**ПАРЛАМЕНТЫН ЁС  
ЗҮЙ, ДЭГ**

**ОЛОН УЛСЫН БАГА ХУРАЛ**

**1998 ОНЫ 5 САРЫН 12,13**

## ИРГЭДИЙН ОРОЛЦОО - АРДЧИЛАЛ ТӨСӨЛ

Нийгмийн Дэвшил Эмэгтэйчүүд хөдөлгөөн нь иргэдийн улс төрийн мэдлэгийг дээшлүүлж, идэвхи, оролцоог нь нэмэгдүүлэх, УИХ-ыг илүү нээлттэй болгох, гишүүдийн эргэж хариуцлага тооцох ёс болон ёс зүйн хэм хэмжээг дээшлүүлэх, иргэд тэднийг төлөөлж буй төрийн түшээ нарын хоорондын харилцааг улсын болон орон нутгийн түвшинд бэхжүүлэх зорилгоор "Иргэдийн Оролцоо-Ардчилал" нэртэй хоёр жилийн төслийг Улс төрийн боловсролын академитай хамтран Европын Холбооны Ардчилал хөтөлбөр болон ХБНГУ-ын Конрад Аденауэрын сангийн санхүүжилтээр хэрэгжүүлж байна.

### Төслийн хүрээнд:

- Дундговь, Хөвсгөл, Ховд, Өвөрхангай, Дорнод, Дархан-Уул аймагт Иргэний Мэдээллийн бүсийн төвийг байгуулсан. Эдгээр төв нь Улаанбаатар хот дахь Үндэсний төвтэйгээ цахилгаан шуудангийн сүлжээгээр холбогдоод байна. Үндэсний төв нь УИХ-ын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг орон нутагт дамжуулж, эргээд тодорхой асуудлаар иргэдийн санал бодол, байр суурийг хууль тогтоогчдод уламжлах ажлыг хийж байна. Ингэснээр энэ сүлжээ нь мэдээллийн хоёр урсгалтай болж байгаа юм.
- Төслийн сургагч багшийг бүх аймгаас бэлтгэсэн бөгөөд тэд 21 аймгийн 220 орчим суманд иргэний боловсрол, идэвхийг дээшлүүлэх сургалт, семинар хийгээд байна. Энэ бүхний үр дүнд мэдээллээр нэн хомс байгаа орон нутагт амьдарч буй иргэдийг хэрэгцээтэй мэдлэг, мэдээллээр хангаж, тэдний улс төрийн оролцоог нэмэгдүүлснээр аймаг, сумын түвшинд иргэний идэвхтэй хамтлаг төлөвшүүлэхэд нөлөөлөх, орон нутгийн засаг захиргаанд иргэдээс тавих хяналтыг дээшлүүлэх юм.
- Сонгогч-сонгогдогчийн харилцааг сайжруулах үүднээс УИХ-ын гишүүд оролцсон уулзалт ярилцлагыг иргэдийн дунд УИХ-ын Тамгын газартай хамтран тогтмол зохион байгуулж байна.
- Дунд сургуулийн хүүхдүүдэд зориулсан хөтөлбөр, тухайлбал, Мини Парламент, Улс төрийн дугуйлан, УИХ-ын гаднах Мэтгэлцээн, Сурагчийн зөвлөл зэрэг үйл ажиллагааг зохион байгуулж байна. Эдгээр нь залуу үеийнхэнд ардчиллын үйл явцыг ажиглах боломж олгох, төрийн түшээ нартайгаа уулзах, хууль эрх зүй, иргэний боловсролын мэдлэгээ дээшлүүлэх, мэдээлэл авахад нь туслахад оршиж байгаа юм. Мини парламентыг улсын түвшинд хоёр, орон нутагт долоон удаа зохион байгууллаа.
- УИХ-ын үйл ажиллагааг иргэдэд илүү нээлттэй болгох чиглэлээр иргэний мэдээллийн сүлжээг бий болгосноор ардчилсан парламентын тухай сонгогчдын ойлготыг дээшүүлж байна. Ингэснээр ард олноос хууль тогтоох дээд байгууллагад хандах нь илүү болж, төрийн түшээдээ тавих хяналт, шаардлага нь өндөржих юм.
- Парламентын үйл ажиллагаа, ёс зүйн асуудлаар бусад орны туршилагыг харьцуулсан саналын үндсэн дээр УИХ-ын дэгийг илүү боловсронгуй болгох санал боловсруулж, хууль санаачлагчдад толилууна. Санал боловсруулах бэлтгэл ажлыг хүрээнд 1998 оны 5 сарын 12, 13-нд зохион байгуулсан олон улсын бага хуралд гадаадын зовлох, мэргэжилтнүүд оролцсон бөгөөд Монгол Улсын Их Хурал болон судалгаа, эрдэм шинжилгээний байгууллагаас илтгэл оруулж хэлэлцүүлэв. Уг илтгэлүүдийн эмхтгэлийг хэвлэж гаргалаа.
- Улс төр, эдийн засаг, иргэдийн дунд сургалт зохион байгуулах арга зүй, илтгэх урлаг, нутгийн удирдлага гэх мэт өргөн сэдвээр зохион байгуулсан таван удаагийн сургалтал төслийн нийт сургагч багшийг хамруулсан болно.

ЭНЭХҮҮЛЭЛ  
НЭЭЛТТЭЙНИЙ  
ФОРУМААС

ХАНДУУЛВСАА

VX32689 TEE/

НЭЭЛТТЭЙНИЙ  
ФОРУМААС

"Парламентын ёс зүй, дэг" - Олон улсын бага хурал

Агуулга

**Улс төр, ёс зүй**

Х. Шрайнэр, ХБНГУ-ын Бүндэстагын парламентын  
эрх зүйн хэлтсийн дарга

Монголын парламент дахь улс төрчдийн ёс зүйн  
асуудалд. /Илтгэл/

Б. Дэлгэрмаа, УИХ-ын гишүүн, Хүний эрхийн дэд  
хорооны дарга

Ес зүй: уламжлал ба шинэчлэл.

Р. Вандангомбо, ТЗУХИ-ын эрдэмтэн нарийн  
бичгийн дарга, дэд доктор, дэд  
профессор

Парламентын дэг, нээлттэй байдал.

Ё. Нотт, Зөвлөх, ХБНГУ-ын Конрад-Аденауэрын сан

Монголын парламентын хуралдааны дэг ба нээлттэй  
байдлын асуудал.

Ч. Сайханбилэг, УИХ-ын гишүүн

Франц Улс, Парламентын гишүүнд хүлээлгэх ёс зүйн  
болон хууль зүйн  
хариуцлага.

Ж. Бямбалорж, УИХ-ын гишүүн

Парламентын хуралдааны дэг ба нээлттэй байдал.

\ХБНГУ, Монгол Улсын

жишээн дээр харьцуулж\

Б. Энэбиш, УИХ-ын ТГ-ын ерөнхий нарийн бичгийн  
даргын нэгдүгээр орлогч

Болгар Улс, парламентын ўйл ажиллагаан дахь ёс зүй,  
дэгийн асуудал.

Р. Бурмаа, "Иргэдийн оролцоо-ардчилал" төслийн  
удирдагч, НДЭХ-ний тэргүүн

Тангарагийн бичгийн тухайд

Г. Чулуун, Улсын Их Хурлын Тамгын газар

Оролцогчдын санал сэтгэгдлээс

## Улс төрийн үйл ажиллагааг ил тод байлагах ба улс төрд ёс зүйн зарчмыг хэвшүүлэх тухай

### **Х.Шрайнэр**

**ХБНГУ-ын Бундестагийн парламентын  
эрх зүйн хэлтсийн дарга**

"Улс төрийн үйл ажиллагааг ил тод байлагах явдлыг сайжруулах, улс төрд ёс зүйн зарчмыг баталгаажуулхатай холбогдсон асуудал"-аар зарим мэдээлэл хийж, санаа онолоо Та бүхэнтэй хуваалцах боломж олгосонд талархал илэрхийлье.

Юуны өмнө оршил болгож хэдэн тайлбар хэлэхийг зөвшөөрнө үү.

**Нэг.** Сэдэв маань доорхи хоёр угтвар ойлголтыг шаардаж байна.

- Улс төрийн ёс зүйн зарчмуудыг эрх зүйн зохицуулалтаар баталгаажуулах боломжтой гэдгийг

- Улс төрийн үйл ажиллагааг илүү ил тод болгох нь бусад функцийн хажуугаар мөн ёс зүйн зарчмуудыг хангахад тус дөхөм болж чадна гэдэг дээрх ойлголтыг хүлээн зөвшөөрдөг юм.

Гэвч эрх зүйн зохицуулалт нь түүнчлэн ил тод шинж чанарын нөлөөлөл нь хязгаарлагдмал байдгийг бид эхнээсээ ухамсарлах нь зүйтэй.

Эрх зүй, ёс зүй бол хоёр өөр ойлголт юм. Эрх зүй бол ёс зүйн минимум, эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдаж буй ёс суртахууны нэг хэсэг. Ийм учраас эрх зүйн зохицуулалт журам нь зөвхөн ёс зүйн минимумыг л баталгаажуулж чадна. Улс төрийн үйл ажиллагааны ил тод шинж чанарын хувьд мөн адил зарчим үйлчилнэ. Ил тод байдлыг үнэнд хүрэх арга, үнэний болон үр дүн зөв зүйтэй байх, ёс зүйн хэм хэмжээний баталгаа мен хэмээн итгэх нь сэргэн мандалтын үзэс, өөреөр хэлбэл хүний оюун ухааны нийгмийн тусын тулд ашигласнаар хүний үйл ажиллагааны бүхий л салбарт, түүний дотор эрх зүй, ёс суртахуун, улс төрд ч хөгжил дэвшлийг авчирч чадна гэдэг итгэл ноёрхж байсан одоогоос 200 жилийн тэртээх үеийн Европын соён гэгээрүүлэх түүхээс улбаатай юм.

"Бусдын эрх ашгийг хөндсөн аливаа үйлдэл нь ил тод байх зарчмтай зөрчилдөж байвал, тэр нь шударга бус үйлдэл мөн" гэж Германы гүн ухаантан Иммануэль Кант тэр үед ноёрхж байсан итгэл үнэмшлийг тодорхойлсон байдал. Дарангуйллын дэглэмээс ил тод байдлын

зарчмыг гүйвуулсан туршлага (Германы хувьд национал-социализмын үед), түүнчлэн бүх дэлхий ертенцийг бүрхсэн мэдээллийн сүлжээг бий болгосны нааштай ба сөрөг нөлөөний уршгаар бидний итгэл зарим талаар суларсан билээ. Тэгсэн хэдий ч ил тод байдалд итгэх итгэлийн үндэс суурийг баталгаажуулах нь улам чухал болж байна. Ил тод байдал бол үнэн ба үйлдэл нь ёс зүйн зарчмын дагуу байх явдлыг баталгаажуулдаг ид шидтэй зүйл биш боловч тэр нь зарчимгүй явдал, буруу замнал хийгээд мөн зарим улс төрчид ба албан тушаалтны алдаа дутагдлыг илчлэх, засаж залруулах буюу тийм явдлаас урьдчилан сэргийлэхэд зайлшгүй байх шаардлагатай юм. Өөреөр хэлбэл, ил тод байдал нь ёс зүйн ба улс төрийн ёс горимын нийтээр хүлээн зөвшөөрсөн хамгийн бага хэмжээний стандартыг хөхүүлэн дэмжих ба баталгаажуулах хэрэгсэл юм.

Миний дээр хэлсэн зүйлүүд маань үл итгэх яястай байгаа боловч улс төрийн ёс зүйг ханган баталгаажуулахад эрх зүйн зохицуулалт, журам ба ил тод байх зарчмын ач холбогдлын талаар эргэлзээ төрүүлэх зорилгыг миний бие тавиагүй гэдгийг хэлмээр байна. Харин эрх зүйн зохицуулалт, журам ба ил тод байх зарчмаас гадна зайлшгүй шаардлагатай шинж чанарууд байх ёстойд би итгэдэг. Үүнд улс төрийн хариуцлага нэгзэнт хүлээсэн хүн бүр өөрийгөө бүрэн дайчлах, хариуцлага хүлээх чадвар хамаарна. Эцсийн ба шийдвэрлэх үе шат бол хувь хүний итгэл үнэмшил юм. Гэвч тодорхой зорилго ба үр нөлөө бүхий эрх зүйн зохицуулалт, журмыг тогтоож, ил тод байх зарчмыг хэрэгжүүлжсэнээр улс төрийн ёс зүйн зарчмыг ханган баталгаажуулах зайлшгүй шаардлагатай угтвар нехцлийг бий болгож болно. Эдгээр угтвар нехцлээс илүү зүйлийг баталгаажуулах боломж төрд байдаггүй.

**Хоёр.** Миний илтгэл хоёр хэсгээс бүрдэнэ.

- Эхний хэсэгт Iнэгдүгээр бүлэгт би тэр - улс төрийн үйл ажиллагааны ойлгомжтой, ил тод байх явдлыг ханган сайжруулахад чиглэсэн зохицуулалт, журмын тухай ярина. Энэ хэсэгт ихэнхдээ институтын тухай, өөреөр хэлбэл, төрийн үйл ажиллагаа, байгууллагуудын, нэн ялангуяа парламентын ил тод байдлын хэлбэр, хэрэгслийн тухай сэдвүүд байх болно.

- Хоёр дахь хэсэгт I хоёрдугаар бүлэгт тодорхой зарим албан тушаалтанд хамаарах зохицуулалт,

журмын тухай өгүүлнэ. Өөрөөр хэлбэл, энэ хэсэгт хувь хүнд, тухайлбал, парламентын гишүүд болон бусад албаны хүмүүст хамаарах хууль тогтоомж, журмын тухай ярих болно.

Эцэст нь бас нэг тайлбар хэлэхийг хүсч байна. Би илтгэлдээ ихэнхдээ ХБНГУ-ын нөхцөл байдалд тулгуурласан байгаа. Энэ нь би энэ орныг болон түүний улс төрийн системийг илүү сайн мэддэгтэй холбоотой юм. Харин манай систем, бидний шийдлүүд нь бусадад үлгэр дууриал болох ёстой гэж үздэггүйг хэлмээр байна. Хэдийгээр тийм боловч бидний туршлага танай улсад зарим асуудлыг шийдвэрлэхэд хэрэг болж магадгүй юм.

Нэгдүгээр бүлэг: Төр - улс төрийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байх явдлыг үүсгэн бий болгож, гүнзгийрүүлэхэд чиглэсэн зохицуулалт, журам

#### Нэг. Нээлттэй байх зарчим

1) Олон нийтэд, өөрөөр хэлбэл, бүх хүмүүст хамаарах хэрэг явдал нь ил тод, олон нийтэд нээлттэй байх ёстой юм. Ил тод байх явдлын энэхүү зарчим нь ХБНГУ-ын болон, биэндүүрээгүй бол, бусад ямар ч орны үндсэн хуулинд энэхүү ерөнхий хэлбэрээр тодорхой тусгагдаагүй байгаа юм. Гэхдээ энэ зарчим нь орчин үеийн ихэнх үндсэн хуулиудын тулгуур зарчмуудаас урган гарч байдаг. Үүнд ардчилал, эрх зүйт төр, бүгд найрамдах улс хэмээх ухагдахуун хамаарна. Танай улсын Үндсэн хуульд ч эдгээр зарчмуудыг 1 дүгээр зүйлдээ тунхагласан билээ. ХБНГУ-ын Үндсэн хууль 12 дугаар зүйл болон мөн танай улсын Үндсэн хуульд 13-р зүйлийн 1-р хэсэг засгийн бүх эрх ард түмний мэдэлд байх нь ардчиллын шинж чанар мөн хэмээн тодорхойлсон учир ил тод байх зарчим нь "Засгийн эрх мэдэл ард түмнээс үүдэн гарад хаашаа одон явдаг юм бол?" хэмээн Германы нэрт зохиолч Бертольд Брехтийн хошигнон тавьсан асуултанд хариу болж чадах болов уу гэж асуусан юм.

2) Үндсэн хууль, бусад хуулиудад ил тод байх зарчмыг гүйцэтгэх засаглал, хууль тогтоох засаглал, шүүх засаглалын хувьд өөр өөр хэлбэрээр тусгаж, тодотгосны зэрэгцээ хүний үндсэн эрхийн баталгаа болох үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдээлэл чөлөөтэй авах, хэвлэн нийтлэх, звлэлдэн нэгдэх, жагсаал цуглана хийх зэрэг эрх чөлөөгөөр тэр зарчмыг баяжуулсан байдаг.

Үүнд мөн улс төрийн нам байгуулах ХБНГУ-ын ҮХ-ийн 21, МУ-ын ҮХ-ийн 16-р зүйлийн 10-р хэсэг, сонгуульд нэр дэвшүүлэх сонгуулийн кампанийн оролцох эрх хамаарна.

3) Одоо би шүүх ба гүйцэтгэх засаглалд ил тод байх зарчмыг хэрэгжүүлэх асуудлаар товчхон хэдэн зүйл ярья.

Шүүх ажиллагааны ил тод байх зарчим нь хүссэн хүн бүр шүүх хуралдаан болж буй байранд нэвтрэх эрхтэй байдгаар илэрхийлэгдэнэ 1энэхүү эрх нь зөвхөн хурал болж буй тасалгааны багтаамжаар хязгаарлагдана. Энэ нь эрх зүйт төрийн зарчмын нэгэн сонгомол бүрэлдэхүүн хэсэг мен бөгөөд эцсийн эцэст шүүхийн шийдвэр шударга байх магадлалыг нэмэгдүүлж, шударга бус шүүгчдээс шүүгдэгчийг хамгаалах ач холбогдолтой юм.

Гүйцэтгэх засаглалын хувьд өөрөөр хэлбэл, засаг захирагааны байгууллага, засгийн газрын хувьд асуудал өөрөөр тавигдана. Ил тод байх зарчим нь энд албаны өрөө тасалгаанд саадгүй нэвтрэх хэлбэрээр илэрхийлэгдэхгүй. АНУ, Швед болон бусад орноос ялгаатай нэг зүйл бол ХБНГУ-д хүн бүр хүссэн баримт материалтай танилцаж, ямар ч асуултанд хариу авах эрхтэй байдаггүй. Ийм эрхийг зөвхөн тодорхой асуудалд холбогдох хүмүүс л эдэнэ. Харин хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөгчид төрийн байгууллагуудаас мэдээлэл, лавламж авах эрхтэй боловч мөн энэ талаар зарим хязгаарлалт байдаг. Жишээ нь Нордрейн-Вестфален муж улсын хэвлэлийн тухай хууль байна. Иймэрхүү тусгай хууль тогтоомжийг үл тооцвол гүйцэтгэх засаглалын ил тод байх зарчмыг өөр замаар хэрэгжүүлэх боломжтой. Үүнийг парламент ба түүний ил тод байх зарчмын дагуу засгийн газар улс төрийн хариуцлага хүлээх ёстой учир түүний мэдлийн байгууллагууд мөн энэ зарчимд захирагдах ёстой гэж тайлбарлаж болох юм. Энэ талаар би дахиж ярих болно. Парламентын ил тод байх зарчим нь манай Үндсэн хуулийн тогтолцоонд улс төрийн ил тод байх зарчмын цем нь юм. Танай Үндсэн хуулийн системд ч мөн адил байгаа байх.

#### Хоёр. Парламентын нээлттэй байх зарчим, түүний хэлбэр, үүрэг журам

1) Хэлбэрүүд: Нээлттэй байх нь аливаа ардчилсан парламентын үндсэн шинж чанар мөн. ХБНГУ-д парламентын нээлттэй байх зарчим нь Үндсэн хуулийн зарчим юм. Үндсэн хуулийн 42-р зүйлийн 1 дүгээр хэсэгт "Бундестаг үйл ажиллагаагаа нээлттэй явуулна" гэж заасан байдаг. Зөвхөн Бундестагийн бүх гишүүдийн аравны нэг хувь буюу Засгийн газрын гишүүдийн гуравны хоёрын саналаар олон нийтийг Бундестагийн хуралдаанд оролцуулахгүй байж болно. Гэвч Бундестаг 50 орчим жилийн түүхэндээ энэ боломжийг ганц ч удаа ашиглаагүй юм.

а) Үндсэн хуульд тусгагдсан нээлттэй байх зарчим нь манайд зөвхөн Бундестагийн нэгдсэн хуралдаанд хэрэглэгдэнэ. Байнгын хорооны хуралдаанд энэ зарчим үйлчилдэггүй. Нээлттэй байх гэдэг нь хүссэн хүн бүр байрны багтаамжийн

хүрээнд хуралдаанд нэвтрэн орох эрхтэй гэсэн үг юм. Үүнийг хуралдааны нээлттэй байх зарчим гэж нэрлэдэг.

Германы Бундестагийн хуралдааныг ажиглах хүснэгтэй хүмүүст зориулж 300 орчим судалтай тусгай индэр зассан юм. Энэхүү индэрийн суудалд суухын тулд тусгай зөвшөөрөл авах шаардлагагүй боловч сонирхогчдын тоо байнга их байдгийг бодолцон урьдчилж захиалга өгөх, эсвэл Бундестагийн аль нэг гишүүнээс урилга авах юм уу, эсвэл албан ёсны зочдын бүрэлдэхүүнд багтан орох нь илүү зохимжтой байдаг. 1949 оноос хойших хугацаанд Бундестагийн хуралдаанд 11 сая орчим хүн ажиглагчаар оролцсон байна.

Парламентын тухай мэдээллийг сонин хэвлэл, телевизээр хүлээн авахаас гадна аль болох олон иргэд тэнд веердээ очиж байдалтай танилцах нь маш чухал гэж би хувьдаа үздэг. Үүнд нэн ялангуяа залуучуудыг хамруулах нь чухал. Ялангуяа чөлөөт ардчилсан сонгуулиар бүрэлдсэн парламентын олон жилийн туршилага байхгүй танай орны хувьд энэ асуудал онцгой ач холбогдолтой байж болох юм. Парламентын хуралдаанд иргэдийг ажиглагчаар оролцуулахын зэрэгцээ мэн сонин хэвлэл, радио, телевизийн төлөөлөгчдийг оролцуулснаар парламентын хуралдааныг ирж үзэх боломжгүй хүмүүст энэ тухай мэдээлэл боломжтой болж байгаа юм. Энэ нь мэдээлэл чөлөөтэй олж авах, мэдээлэх эрх чөлөөний нэгэн илрэл юм. Германы Бундестагт хэвлэл мэдээллийн байгууллагуудын төлөөлөгчдөд зориулсан тусгай суудал байдаг. Телевизийн байгууллагууд эндээс зураг авах бүрэн боломжтой бөгөөд хуралдааны ажиллагааг ямар хугацаагаар шууд дамжуулах, эсвэл бичлэг хийхээ веердээ шийддэг.

Үүний зэрэгцээ Бундестаг веерөө телевизийн студитэй. Энэ студи нь Бундестагийн хуралдааны зургийг авахдаа нэвтрүүлгийг мэн парламентын гишүүдийн ба засгийн газрын холбогдох албан тушаалтны албан тасалгаанд дамжуулж, хийсэн бичлэгээ мэн телевизийн байгууллагуудад санал болгодог. Телевизийн байгууллагууд энэ бичлэгийг ашиглах эсвэл биеz дааж нэвтрүүлэг хийхээ веердээ шийднэ. Харин Германы Бундестаг нь телевизийн байгууллага шиг эрхтэй байх, веерөөр хэлбэл биеz дааж нэвтрүүлэг явуулах нь зөв эсэх нь эргэлзээтай юм.

Радио, телевизийн мэдээг хүлээж авах эрхийг ХБНГУ-д хүний үндсэн эрхэд хамааруулдаг. Өөрөөр хэлбэл, энэ нь зөвхөн хувь хүний эдлэх, харин төр буюу териин байгууллага, тухайлбал парламентад үл хамаарах эрх юм. Германы Бундестагийн ажиллагаа нээлттэй байх зарчмытай мэн Үндсэн хуулиар баталгаажуулсан

парламентын тухай мэдээллийг нэвтрүүлсний төлөө хариуцлага үл хүлээх эрх чөлөө холбоотой. Парламент буюу түүний байнгын хороодын үйл ажиллагааг үнэн зөв мэдээлсний төлөө хэнд ч хуулийн буюу бусад хариуцлага ногдуулахгүй энэхүү эрх чөлөөний утга учир байгаа юм. Мен парламентын хуралдааны бичмэл мэдээллийг албан ёсны нэвтрүүлэгт ашиглах явдал мөн л хариуцлага ногдуулахгүй байх эрх чөлөөнд хамаарна. Парламентын тухай үнэн зөв мэдээлсний төлөө хариуцлага хүлээхгүй эрх чөлөө нь ямар ч хязгаарлалт байхгүй бөгөөд холбогдох бүх этгээд түүнийг адил тэгш эрхтэйгээр эдэлнэ. Хэрэв бидэнд цаг хугацаа байгаа хийгээд энэ сэдвийг та бүхэн сонирхож байвал би энэ тухай илүү дэлгэрэнгүй ярьж болж байна.

Парламентын ажиллагааг үнэн зөв мэдээлсний төлөө хариуцлагаас бүрэн чөлөөлөгдхөд эрх чөлөө нь практикийн ач холбогдолтой юм. Жишээлбэл: парламентын нэг гишүүн хуралдааны үеэр гурав дахь этгээдийн нэр хүндийг нь гутаасан гүтгэлэг хийсэн, веерөөр хэлбэл, санаатайгаар түүний нэр сүрийг гутаасан худал мэдүүлэг өгсөн тохиолдол гарч гэж бодъё. Манай Үндсэн хуулиар Бундестагийн гишүүн халдашгүй эрх, мөн хуралдааны үеэр саналаа өгсөн буюу хэлсэн зүйлийнхээ төлөө хариуцлагаас чөлөөлөгдхөд эрх эдэлнэ. Энэ нь парламентын гишүүн санал өгснийхөө буюу парламентын хуралдааны үеэр хэлсэн зүйлийнхээ төлөө ямар ч тохиолдолд шүүхийн болон шүүхийн бус хариуцлага хүлээхгүй гэсэн үг юм. Гэхдээ тэрбээр хүний нэр хүндийг гутааж гүтгэсэн нөхцөлд энэ эрхийг эдлэхгүй. 1949-ийн 46-р зүйлийн 1-р хэсэгт.

Халдашгүй байдал гэдэг нь парламентын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тохиолдолд зөвхөн парламентын зөвшөөрсөн нөхцөлд түүнийг эрүүгийн хариуцлагад татах болно гэсэн үг. Бусдын нэр хүндийг гутааж гүтгэлэг үйлдсэн бол халдашгүй бүрэн эрхийг нь үзүүлж Бундестаг цуцалсан тохиолдолд түүнийг эрүүгийн хариуцлагад татах боломжтой юм. Индемнитет нь хүний нэр хүндийг гутаасан гүтгэлгийн хувьд үйлчилдэггүй учир түүний халдашгүй бүрэн эрхийг хамгаалах үндэслэл болохгүй. Харин хүний нэр хүндийг гутаасан гүтгэлэг үйлдсэн тухай үнэнд нийцсэн мэдээлэл нь, тухайлбал албан ёсны протокол буюу хэвлэлийн мэдээ нь хариуцлага хүлээлгэх үндэслэл болохгүй. Бундестагийн хуралдааны албан ёсны тэмдэглэлийг 4000 орчим хувиар хэвлэдэг бөгөөд хэвлэлийн мэдээ түүнээс ч олон хувиар гардаг гэж бодоход ямар их хэмжээний материал энэхүү хамгаалалтанд хамаардаг нь ойлгомжтой болно. Тийм учраас парламентын аливаа гишүүн гурав дахь этгээдийн нэр хүндтэй холбогдсон баримт гаргаж тавихдаа хувийн өндөр хариуцлага

хүлээдэг юм. Хуралдааныг удирдаж байгаа хүн уг хэлж байгаа хүнийг үгээ хэлснийх нь төлөө журамлах арга хэмжээ авах, тухайлбал сануулах боломжтой бөгөөд хэлэгдсэн зүйл бодитой эсэхийг шалгах боломж түүнд тэр болгон байдаггүй.

б) Манай Үндсэн хуульд парламентын байнгын хороодын үйл ажиллагаа нээлттэй байх ёстой гэсэн заалт байдаггүй. Бундестагийн дотоод зохион байгуулалт, ажлын журмыг зохицуулдаг Германы Бундестагийн дотоод ажлын журамд байнгын хороодын хуралдаан нээлттэй бус байхаар заасан байдаг юм. Харин байнгын хороод өөрсдөө хуралдаанаа нээлттэй явуулах тухай шийдвэр гаргаж болно.

Нээлттэй бус гэдэг нь нууц гэсэн үг биш юм. Харин уг хуралдаанд хүссэн хүн бүр оролцох боломжгүй гэсэн үг. Нээлттэй бус хуралдаанаар хэлэлцсэн асуудлын тухай уг хуралдаанд оролцсон хүн гурав дахь этгээдэд, тухайлбал, хэвлэл мэдээллийн байгууллагуудын төлөөлөгчид болон холбогдох хүрээний хүмүүст мэдээлэхийг хориглохгүй. Энэ утгаараа байнгын хороодын нээлттэй бус хуралдаанд олон нийтийн шууд бус хяналт тавьдаг гэж хэлж болно. Байнгын хорооны нээлттэй бус хуралдаанд уг хорооны гишүүн бус парламентын гишүүн үг хэлэх эрхгүйгээр оролцох боломжтой. Түүнээс гадна зөвхөн өөрсдийн гишүүд болон тэдний орлогчдын бүрэлдэхүүнтэй хуралддаг, хаалттай байнгын хороод байдаг. Жишээ нь Батлан хамгаалахын байнгын хороо юм. Жирийн нээлттэй бус хуралдааны зэрэгцээ тодорхой шалтгаан байгаа нехцелд нууцын зэрэглэлтэй хуралдаан явуулах тохиолдол гардаг.

Дээр хэлсэнчлэн байнгын хороод нээлттэй хуралдаан явуулахаар шийдвэрлэж болно. Гэвч практикт тэд энэ эрхээ цөөн хэрэгжүүлдэг учир шүүмжлэлд өртөх явдал гардаг. Хуралдааныг нээлттэй буюу нээлттэй бус хийхийн төлөө саналын цаадах шалтгаан нь тодорхой. Энэ тухай маргаан одоо ч үргэлжилсээр байгаа.

Хуралдааныг нээлттэй бус явуулах нь мэтгэлцээнийг чөлөөтэй өрнүүлж, үүний үр дүнд нэг саналд хүрэх илүү боломжтой гэж зарим хүмүүс үздэг. Эсрэг санал нь гэвэл байнгын хороод бүх асуудлыг нууц байдалтай, ямар ч хяналтгүй хэлэлцэж шийдвэрлэх боломжтой байна гэдэг.

Эцэст нь заавал нээлттэй хуралддаг байнгын хорооны хуралдааны тухай дурддяа. Үүнд юуны өмне нээлттэй сонголыг дурьдах нь зүйтэй. Уг сонголд шинжээч, холбогдох бусад хүмүүсийг урьж оролцуулна. Парламентад суудалтай намын бүлэг тухайн байнгын хороонд байгаа

төлөөллийн харьцаанаас хамааран сонсох хүмүүсийн тоог тогтооно.

Тодорхой асуудлыг мөрдөн шалгахаар томилогдсон комиссууд нь хуралдаанаа нээлттэй явуулна. Германы Бундестаг нь өөрийн санаачилгаар буюу гишүүдийн деревний нэг шаардсан тохиолдолд мөрдөн шалгах комисс нь нотлох баримт цуглуулахдаа Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн заалтуудыг удирдлага болгоно. Үүний дагуу тус комисс гэрчүүдийг зарлан дуудах, тэднийг байцаах, тангараг өргүүлж мэдүүлэг авах эрхтэйгээс гадна бусад байгууллагын материалтай танилцах эрхийг эдэлнэ. Мөрдөн шалгах комиссууд нь юуны өмне гүйцэтгэх засаглалын салбарт гарсан буюу гарч болзошгүй зөрчлүүдийг илрүүлэн шалгах үүрэгтэй байдаг.

Германы Бундестагийн бүх гишүүдийн деревний нэгийн шаардлагаар мөрдөн шалгах комиссыг томилох ёстой байдаг тул энэ нь цеенхийн ашиг сонирхлыг илэрхийлэх боломж олгодог бөгөөд энэ эрхийг нэн ялангуяа серег хүчин эдлэх дуртай байдаг юм. Мөрдөн шалгах комисс нь хийсэн ажлынхаа тухай тайланг Бундестагийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлнэ. Мөрдөн шалгах комисс нь шүүх биш учир шийдвэр гаргах эрх эдлдэггүй.

Германы Бундестаг хэдэн жилийн өмне байнгын хороо өргөтгесэн нээлттэй хуралдаан хийж байхаар шийдвэрлэсэн бөгөөд энэ нь дараахь зорилготой юм. Хэд хэдэн байнгын хороо нэг асуудал, тухайлбал, нэг хуулийн төслийг хэлэлцэж байгаа тохиолдолд, өөрийнхөө байнгын хорооны хүрээнд тухайн асуудлыг хэлэлцэж дууссаны дараа хамтран хуралдаж Бундестагийн нэгдсэн хуралдаанд оруулах шийдвэрийн төслийг хэлэлцэж шийдвэр гаргахыг хэлдэг юм.

Энэ хэрэгслийг бий болгосны учир нь гэвэл зөвхөн тодорхой мэргэжлийн хэсэг хүмүүсийн сонирхлыг татсан, нийт хүмүүст төдийлен сонирхолтой бус зарим асуудлын талаар Бундестагт маргаан өрнүүлэхээс зайлсхийх, нэг ёсондоо Бундестагийн ачааллыг хөнгөлөхөд оршиж байгаа юм. Энэ сэдэв нь мөн "хоосон танхимиын" асуудалтай холбоотой бөгөөд энэ тухай би өөр газар ярих болно.

2) Үүрэг: Дээр дурдсан парламентын нээлттэй байх зарчмын хэлбэр, хэрэгслийн учир юунд байна вэ? Ил тод байдал нь улс төрийн ёс зүйн зарчмыг баталгаажуулах асуудалтай ямар холбоотой байдаг юм бэ? Ил тод байдал нь үнэн зөвийн шууд баталгаа мөн хэмээн үздэг байсан урьд цагийн үзэл бодлыг бид хуваалцдаггүй гэж би дээр хэлж байсан. Хэдэн ухаантан хуран цуглараад ил тод байдалд мэтгэлцээний үр дүнд сайн хууль гаргаж чадна, эцэстээ бүр туйлын

Үнэнд хүрч чадна гэсэн ойлголт нь миний үзэж байгаагаар бодит байдалд үлнийцэх бөгөөд хэзээ ч нийцэж байгаагүй болов уу.

Улс төрийн шийдвэр гаргах үйл явц нь өнөө үед маш олон хэсгээс бүрддэг учир уг шийдвэрийг зөвхөн аливаа нэг нээлттэй хурлын хүрээнд гаргах боломжгүй юм. Улс төрийн шийдвэр гаргах үйл явц нь олон үе шаттай байдаг. Хуулийн төслийн хувьд гэвэл энэ ажил нь засгийн газраас хуулийн нэгэн төсөл боловсруулахаас эхэлдэг. Дараа нь тухайн орны хууль тогтоох журмын дагуу төслийг парламентад анхны хэлэлцүүлэгт оруулаад, дараа нь түүнийг байнгын хороод болон намын бүлгүүд дээр холбогдох хүмүүс, байгууллагыг г. м. оруулан хэлэлцсний эцэст магадгүй нэгдсэн хуралдаанд оруулж санал хураалт явуулдаг билээ. Улс төрийн шийдвэр гаргах үйл явцын олон талт шинж чанар, түүнд оролцож буй этгээдүүдийн үүрэг хариуцлагын хуваарийг авч үзэхэд ХБНГУҮН улс төрийн тогтолцооны нөхцөлд парламентын нээлттэй хуралдааны хэлэлцүүлэг нь зөвхөн шийдвэрийг боловсруулан гаргах зорилгыг агуулдаггүй.

Парламентын нээлттэй хуралдаан нь үнэн хэрэгтээ парламентад суудалтай улс төрийн хүчинүүдэд намын булгэ болон байнгын хороод дээр тэртээ тэргүй шийдсэн зүйлүүдээ олон нийтийн өмнө хамгаалах, үндэслэх, яагаад сруулсан төслийг дэмжих эсвэл түүний эсрэг санал өгөхөө тайлбарлах боломж олгодог юм. Шалгааныг тоочиж зөвтгөх гэдэг бол эцсийн эцэст улс төрийн ноёрхлыг рационализацийн үндсэн дээр хууль ёсны болгох гэсэн үг бөгөөд энэ нь парламентын нээлттэй байх зарчмын нэг чухал үүрэг юм. Мөн парламентын нээлттэй байдал нь улс төрийн мэдээллийн ба гэгээрүүлэх чухал үүрэг гүйцэтгэдэг. Парламентаризмын онолын ангийн сонгодог төлөөлөг В.Бэлжүүт бүр 19-р зуунд парламентын гэгээрүүлэх үргийн тухай дурдаж байв. Ил тод байдал нь цаашилбал иргэдийн улс төрийн оролцоог идэвхжүүлж, парламентад хэлэлцэж буй асуудалд тэдний анхаарлыг хандуулснаар дэмжлэгийг нь авах буюу шүүмжлэлийг өрнүүлэх ач холбогдолтой. Ингэснээр парламентын ил тод байдлын шүүмжлэх ба хянах үргийн асуудал хөндөгдэж байна. Парламентын нээлттэй байх зарчим нь үүнээс өөр үүрэг гүйцэтгэдэг эсвэл дээр дурдсан үргийг өөреөр тодорхойлох буюу тайлбарлах байсан эсэх талаар шинжлэх ухааны мэтгэлцээн өрнүүлэхийг би хүсэхгүй байна. Ямар ч эргэлзээгүй зүйл бол, парламентын нээлттэй байдлын шүүмжлэлийн ба хяналтын үүрэг, түүнчлэн улс төрийн шийдвэрийг рационализацижуулах үүрэг нь улс төрийн ёс зүйн зарчмуудыг мөрдүүлэх баталгаа болж чадахгүй боловч тэдгээрийг мөрдөхөд тус дехем болох нь дамжигүй. Төрийнхөө гаргасан улс төрийн

шийдвэр, байр суурийнхаа шалгааныг олон нийтэд ил тодор тайлбарлах үүрэг хүлээж, өөрийнх нь улс төрийн үйл ажиллагаанд олон нийт дүгнэлт хийнэ гэдгийг ойлгосон хэн нэгнээс парламентын хүрээнд буюу парламентаас гадна гаргасан шийдвэр, хийсэн үйлдлийг бусад хүмүүс өөр хэмжүүрээр, түүний дотор ёс зүйн хэмжүүрээр дүгнэнэ гэдгийг мартаж болохгүй. Хяналт гэдэг нь нийтээр хүлээн зөвшөөрсөн хэмжүүрээр дүгнэхийг хэлдэг бол шүүмжлэл гэдэг нь мөн нийтээр хүлээн зөвшөөрөгдөөгүй хэмжүүрээр дүгнэх боломж олгодог.

**3) Журам, оролцогод:** Бид хэнийг хянах гээд байгаа юм бэ? Хэний шийдвэр, үйл ажиллагааг олон нийтийн, парламентын нээлттэй байх зарчмын дагуу болон ёс зүйн зарчмуудын дагуу хянах ёстой юм бэ? Парламент гэдэг маань нэг маягийн материалаас бүрдсэн биет зүйл бус, тэр нь олон гишүүдээс бүрддэг бөгөөд тэдээр нь олонхи ба серег хүчин болж зохион байгуулгдана. Үндсэн хуульд заасанчлан парламентад гүйцэтгэх засаглалд тавих хяналтын янз бүрийн үүрэг ногддог бөгөөд үйл ажиллагаагаа дотоод журмын эсвэл танай орны хувьд холбогдох хуулийн дагуу явуулна. Танай парламентын талаарх миний мэдлэг нимгэн учир Германд чухал гэж үздэг зарим сэдэв ба асуудлын талаар яръя. Энэ нь та нөхдөд ч сонирхолтой байж магадгүй юм.

Герман Улсад парламентын ёс зүйн асуудлыг юуны өмнө парламентын нээлттэй ба ил тод байдалтай холбогдох сэдэвтэй хамтад нь авч үздэг юм. Үүнд нэн түрүүнд парламентын гишүүдээс өөр ажил эрхлэх асуудал 1энэ талаар би илтгэлийнхээ 2 дахь хэсэгт дэлгэрэнгүй ярих болно, дараа нь "хуралдааны хоосон танхим" хэмээх сэдэв, түүнчлэн парламентын хуралдаан дээр улс төрийн маргааныг явуулах арга хэлбэр 1стиль, парламент дахь намын бүлгийн зүгээс үзүүлэх дарамт, бүлгийн дотоод сахилга батын асуудал хамаарна.

#### "Хурлын хоосон танхим":

Манай парламентын дотоод ажлын журмын дагуу Бундестагийн гишүүд нь "Бундестагийн үйл ажиллагаанд сролцох үүрэгтэй" 1журмын 13-ын 2 дахь хэсэг<sup>1</sup>. Бундестагийн гишүүний тухай хуульд 114 үүнээс гадна санхүүгийн арга хэмжээ авахаар, тодруулж хэлбэрэл, гишүүний зардлын төсвээс хасахаар заасан байдаг юм. Энэхүү мөнгөн торгуулийг парламентын гишүүн нь хүндэтгэн үзэх шалгаангүйгээр ирцийн бүртгэлд гарын үсэг зураагүй буюу нэр зааж санал өгөхөд оролцоогүй тохиолдолд ногдуулна. Хүндэтгэн үзэх шалгаан гэдэг нь зарим талаар хэлбэр төдий зүйл болохоос гадна Германы Бундестагт хурал хүчинтэйд тооцох ирцийн хувийг ихэнх тохиолдолд тогтоодоггүй учир парламентын нэгдсэн хуралдааны танхимд цөөн тооны, заримдаа бүр

20-30 нийт гишүүдийн тоо 6721 гишүүн сууж байх явдал цөөнгүй гардаг. Үүнтэй холбогдож олон нийтийн зүгээс парламентын гишүүдийг "хөдөлмөрийн ёс суртахууны дөгөлдөр гаргадаг хэмээн шүүмжлэх явдал гардаг. Нэгдсэн хуралдаанд оролцоогүй шалтгаан, түүний дотор үндэслэлтэй шалтгааны талаар дэлгэрэнгүй ярихыг би хүсэхгүй байна. Үүнд: парламентын бусад байгууллагын ўйл ажиллагаанд оролцох, илтгэл бэлтгэх, иргэдийг хүлээж авах, шинжээчид болон засгийн газрын албан тушаалтантай уулзах ажил хамаарна.

Хуульзүйн үүднээс авч үзвэл шийдвэрлэх ач холбогдол бүхий дараахи үндэслэл бий. Үндсэн хуулиар баталгаажуулсан чөлөөт мандат нь парламентын гишүүн бүрт парламентын нэгдсэн хуралдаанд оролцох эсвэл өөрийнхеэ мандатын дагуу өөр ажил үүргийг гүйцэтгэх асуудлыг шийдэх эрхийг тухайн гишүүнд олгож байгаа юм.

Үндсэн хуульд чөлөөт мандатын баталгааг тунхаглахдаа: Бундестагийн гишүүд нь "бүх ард түмний төлөөлөгчид мөн богоод аливаа даалгавар, удирдамж биелүүлэх үүрэггүй, зөвхөн өөрийн дотоод итгэл үнэмшилд захирагдана гэсэн байдаг, 19X-ийн 38-р зүйлийн 1-р хэсэг".

Парламентын нэгдсэн хуралдааны нээлттэй байдал нь уг хуралдаанд хэн оролцож, хэн оролцохгүй байгааг илтгэн харуулах боломж олгож байгаа боловч энэ нь гишүүдийг нэгдсэн хуралдаанд заавал суухад хүргэх хүчин зүйл болж хараахан чадахгүй байгаа нь илт байна.

Харин нэрээр санал өгөх асуудалд өөр байдалтай байдаг юм. Санал хураалтанд оролцсон парламентын гишүүдийн нээсийг хуралдааны протоколд тэмдэглэдэг. Энэ протоколд нэр нь гараагүй гишүүд өөрийн намын бүлгээс гадна мөн сонгогчид, намын жирийн гишүүдийн шүүмжлэлд өртдэг. Нэгдсэн хуралдааны протоколыг олон нийтэд нээлттэй байлгах нь нэрээр саналаа өгөхөд заавал оролцох эрмэлзлэлийг парламентын гишүүдэд төрүүлж байна.

Нэгдсэн хуралдаан дээр улс төрийн маргаан явуулах арга хэлбэр: Германы Бундестагт бусад орны парламентын адил сэтгэл хөдлөлийн байдалтай маргаан явагддаг бөгөөд энэ үеэр улс төрийн серег хүчний төлөөлөгчдийг дайрч давшлах, тэр ч байтугай хэл амаар доромжлох явдал заримдаа гардаг. Олон нийтийн өөр арга хэмжээнд таашаал үл хүлээх байдал ч гаргах явдал байдаг. Жишээлбэл, зориуд сонсоогүй дүр үзүүлэх, холбогдолгүй материал буюу сонин унших, хүн ярьж байхад байранаасаа хашгирах, серег хүчний төлөөлөгчийг үг хэлж байхад зориуд хурал хаяж гарах г.м. Парламент нь улс төрийн маргааны соёлын үлгэр жишээ байхыг олон нийт

шаарддаг. Үүнийг шаардах нь зөв ч үр дүн нь харин ямар байна вэ? Парламентын өдер тутмын ажилд гардаг байранаасаа хашгирах, илтгэгчийг зориуд сонсоогүй дүр үзүүлж, өөр холбогдолгүй зүйл унших гэх мэт зүйлийн тухай ярихаа больё. Эдгээр үйлдлийг манай парламентад тэвчдэг уламжлалтай. Харин хуралдаан даргалж буй хүнийг шүүмжлэх, зурагт хуудас гаргах, бусдыг доромжлох зэрэг үйлдэл нь хориотой байдаг.

Парламентын нэгдсэн хуралдааны нээлттэй байх зарчим нь түүнд оролцож байгаа гишүүдэд хэрхэн нэлэөлдөгийг дүгнэхэд хүндрэлтэй юм. Үүнд тухайн гишүүний зан араншин мөн нэлэөлнэ. Миний ойлгосноор бол парламентын гишүүд маань олон нийтийн зүгээс нэгдсэн хуралдааны үеэр тэдний биээ авч явж байгаа байдлын талаар гарч байгаа шүүмжлэлд ач холбогдол өгдөг эсвэл гарч болзошгүй шүүмжлэлийг урьдчилан тооцоолж чаддаг мэт. Тэдний хувьд дахин сонгогдох эсэх асуудал чухал бөгөөд түүнээс гадна "сахилга алдсан" гишүүнд тухайн намын бүлэг нь нэлэөлөх боломжтой билээ.

Үүнтэй холбогдуулан нэг санаа хэлэхийг зөвшөөрнө үү. Улс төрийн маргааныг явуулахдаа ёс зүйн үндэслэл хэрэглэх тохиолдол олонтаа гардаг. Улс төрийн хувьд зөвшөөрөхгүй зүйлээ хүмүүс буруутгах дуртай байдаг. Энэ асуудалд болгоомжтой хандах нь зүйтэй гэж би хувьдаа боддог. Ёс зүйн зарчимгүй улс төр байж болохгүй гэдэг нь ойлгомжтой. Гэвч улс төрийн хувьд буруу гэж үзэж байгаа зүйлээ мөн ёс зүйн хувьд буруу байх ёстой гэж болохгүй. Үүнээс гадна анхаарч үзэх бас нэг зүйл байна. Манай орныг жишээ болгоход, нийгэмд аль хэдийнээ ёс зүйн үнэлээмжийн плюрализм бий болсон бөгөөд энэ нь мөн улс төрийн шийдвэр гаргахад ч нэлэөлж байна. Би жишээ болгож үр хендех асуудлыг дурдья. Манай парламент энэ асуудал дээр ч нийгэмд бий болсон ёс зүйн олон ургальч үзэл бодлыг илэрхийлж байгаа бөгөөд эдгээр үзэл бодлын аль нэг нь ил тод байх зарчимд тулгуурлан парламентад давамгайлна гэдэг нь эргэлзээтэй.

#### Намын бүлгийн дарамт, бүлгийн сахилга:

Намын бүлгийн шахалтын тухай ярихад парламентын ажиллагаа ил тод байх зарчим нь улс төрийн зарчимтай зөрчилдөж буй мэт байдаг. Намынхаа бүлгийн шахалтанд автагдана гэдэг нь тухайн гишүүн өөрийнхөө итгэл үнэмшилийн эсрэг ярих, саналаа өгөх гэсэн ойлголтыг агуулж байдаг. Тийм учраас олон нийтийн зүгээс мөн чухал асуудлаар санал хураахын ёмне парламентад ч намын бүлгийн зүгээс гишүүддээ дарамт үзүүлэхгүй байх, саналаа чөлөөтэй өгөх боломж олгохыг шаардах явдал гардаг.

Харин ойроос ажиглахад байдал арай өөрөөр сийлгогддог. Намын бүлгийн шахалт гэдэг нь тухайн

бүлгээс парламентын гишүүд үйл ажиллагаа явуулахад нь, нэн ялангуяа санал өгөхөд тодорхой үүрэг ногдуулахыг хэлнэ. Намын бүлгийн шахалт нь чөлөөт мандатын зарчимтай үл нийцэх тул хууль зүйн талаас зөвшөөрч үл болох зүйл юм. Манай нөхцөлд намын бүлгийн шахалтыг хэрэгжүүлэх боломжгүй бөгөөд үүний практикт хэрэглэх оролдлого ч гардаггүй. Харин намын бүлгийн эв нэгдэл буюу сахилга гэдэг маань өөр асуудал юм. Энэ нь намын бүлгээс бүлэг дотроо нэг хүсэл зоригт хүрэхийн тулд бэлтгэл ажил явуулсны дунд парламентад нэгдмэл байр суурьтай байхыг эрмэлзэх явдал юм. Ийнхүү бүлэг дотор бий болсон нэгдмэл хүсэл зоригийн хүрээнд чөлөөт мандатын баталгаанд тулгуурлан өөрийнхөө байр суурийн төлөө тэмцэх боломж парламентын гишүүнд байдаг.

Ялагдсан тохиолдолд тэрбээр нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэг, санал хураалтын үеэр өөрийнхөө намын бүлгийг дэмжих үү, эсвэл өөрийнхөө байр суурь дээрээ байх уу гэдгийг шийдэх ёстой. Аль ч хувилбарыг сонгосон гэсэн ёс зүйн талаасаа ч, тухайн гишүүний итгэл үнэмшилийн хувьд ч түүнийг буруутгах аргагүй гэж хэлмээр байна. Парламентын гишүүн тэртээ тэргүй улстөрийнх нь хетөлбөрийг дэмжиж байгаа эвслийнхээ саналыг унагаахгүйн тулд зарим нэг зарчмын бус асуудлаар өөрийн баримталж буй онцгой байр суурийг хойш нь тавьж эвслийнхээ төлөө санал өгөх нь утгаа ёс зүйд үл нийцнэ гэж үзэх нь зөв үү?

Намын бүлгээс бүлгийн сахилгыг баримтлахыг шаардаж байгаа нөхцөлд ил тод байх зарчим нь тодорхой парламентын гишүүний санааг амраах зүйл тэр болгон биш байдаг. Ил тод байх зарчим нь мэн түүнд итгэл үнэмшилийнхээ дагуу үйлдэл хийхэд саад болох учиргүй. Намын бүлэгтэйгээ санал зөрүүтэй тохиолдолд тухайн парламентын гишүүн парламентын нэгдсэн хуралдаан дээр өөрийнхөө байр суурийг тайлбарлаж, түүнийхээ дагуу саналаа өгөх буюу саналаа тутгэлзүүлэх боломжтой. Германы Бундестагт иймэрхүү асуудлыг хууль зүйн зүгээс зохицуулсан бөгөөд энэ боломжийг парламентын гишүүд маань байнга ашигладаг. Бас нэг дурдууштай зүйл гэвэл, парламентын гишүүдэд өөрийн итгэл үнэмшилийн дагуу саналаа өгөхөд нь дэм болохын үүднээс зарчмын чухал асуудлаар санал хураалт явуулахын өмнө санал хураалтыг нууцаар явуулахыг шаардах явдал гардаг. Энэ тохиолдолд ёс зүйн болон итгэл үнэмшилийнхээ дагуу саналаа өгөх зарчмыг мөрдүүлэхийн тулд ил тод байх зарчмыг удирдлага болгохгүй, харин нууцлалд шүтэж байгаа нь тодорхой. Үүнтэй холбогдуулан би ганцхан тайлбар хэлмээр байна.

Үндсэн хуулийн дагуу боловсруулж баталсан манай парламентын дотоод ажлын журамд

сонгуулийг нууцаар явуулахыг тулгаснаас биш харин тодорхой асуудлаар нууц санал хураалтын тухай зүйл анги байдаггүй юм. Гэвч дотоод ажлын журамд нууц санал хураалтын асуудлыг оруулбал энэ нь Үндсэн хуулийг зөрчсөн зүйл болохгүй байх.

#### **6) Парламентын зүгээс гүйцэтгэх засаглалд тавих хяналт:**

Парламентын зүгээс гүйцэтгэх засаглалд тавих хяналтын асуудал нь олон нийтээс их анхаардаг асуудлын нэг мэн бөгөөд үүнийг хэрэгжүүлэхдээ хууль ёсыг хийгээд хуульчилсан, улмаар хууль зүйн хүрээнээс давж хальсан ёс зүйн зарчмуудыг мөрдөх шаардлага гардаг юм. Парламентын хяналтыг хэрэгжүүлэх боломж, арга хэрэгслүүд Үндсэн хуулиудад өөр өөрөөр тусгагдаж ирснийг Та нехөд мэдэж байгаа. ХБНГУ-ын хувьд бол үндсэн асуудал нь парламентын засаглалын системдээ байгаа юм.

Үүний гол утга учир нь засгийн газрын тэргүүн буюу Холбооны канцлерийг парламент сонгодог ба огцруулдаг, засгийн газар нь үйл ажиллагаагаа явуулахын тулд парламентын олонхийн байнгын дэмжлэгт тулгуурлах шаардлагатай байдагт оршиж байгаа юм.

Парламентын хяналт гэдэг нь засгийн газар нь парламентын өмнө улстөрийн хариуцлага хүлээнээгээсэн үг. Манай засгийн газрын мэдлийн байгууллагууд нь парламентын шууд хяналтанд байдаггүй, тэдэнд тавих хяналтыг парламентын өмнө хариуцлага хүлээнээс засгийн газраар дамжуулан хэрэгжүүлдэг. ХБНГУ-ын Үндсэн хууль, Бундестагийн дотоод ажлын журамд зааснаар парламентын хяналтын арга хэрэгсэлд юуны өмнө дараах зүйлүүд хамаарна. Үүнд:

- Бундестагийн тодорхой гишүүний тавьсан асуулгад засгийн газар Бундестагийн нээлттэй хуралдааны үеэр хариулах
- Намын бүлгээс буюу 5-аас доошгүй парламентын гишүүдээс засгийн газарт тавьсан жижиг том асуулга. Том асуулга тавьсан тохиолдолд асуудлын хариу ирсэн, эсвэл хариуг заасан хугацаанд ирүүлээгүй тохиолдолд тухайн асуудлыг парламентын хуралдаанаар хэлэлцэхийг шаардаж болно.
- Бундестаг буюу байнгын хорооны олонхийн саналаар засгийн газрын гишүүнийг дуудаж асуулт тавих
- Намын бүлгээс, нэн ялангуяа серег хүчинээс шаардсан тохиолдолд тодорхой асуудлаар баримталах байгаа бодлогоо тайлбарлахыг засгийн газраас хүсэх. Үүнд: тухайлбал "Aktuelle Stunde" гэж нэрлэдэг ганцхан цаг үргэлжилдэг богино хугацааны хэлэлцүүлгийг дурьдаж болно. (106)
- Мордон шалгах комисс томилох. Эдгээр комиссыг гүйцэтгэх засаглалд оршиж буй алдаа дутагдлыг олж илрүүлэх зорилгоор ажиллуулна.

Мөрдөн шалгах комиссыг Бундестагийн гишүүдийн дөрөвний нэг шаардсан тохиолдолд байгуулна. Энэ тухай би дээр өөр сэдэвтэй холбогдуулж дурьдсан

- Эцэст нь хяналтын хамгийн хурц зэвсэг бол Холбооны канцлерийг огцуулахын зэрэгцээшинэ канцлерийг томилох асуудал юм үйтгэл үл хүлээлгэх.

Дээр дурьдсан хяналтын арга хэрэгслийг ихэнхдээ серөг хүчний намын бүлэг, парламентын гишүүд хэрэглэдэг. Серөг хүчний хяналт нь ил тод байдаг бол засгийн газрыг бүрдүүлсэн парламентын олонхиос засгийн газарт үзүүлж буй нелөө нь ихэнхдээ ил тод бус бөгөөд албан бус байдаг ч гэсэн нелеөлөл нь хүчтэй байдаг. Яагаад гэвэл засгийн газар нь парламентын олонхийн дэмжлэгээс хараат байдаг.

Парламентын хяналтын албан ёсны арга хэрэгслийг ашигласны үр дүнд парламентын ил тод байх зарчим нь мөн засгийн газар ба засаг захиргааны бусад байгууллагын үйл ажиллагааг ил тод байхад нелеөлнө. Тухайлбал, парламентын гишүүд болон нэгжүүдээс тавьсан асуулгад засгийн газар хариулах үед засгийн газар болон түүний мэдэлд байгаа байгууллагуудын нехцөл байдал, үйл ажиллагаатай холбогдсон дэлгэрэнгүй мэдээлэл өгөхийг шаардаж, авч болно.

Парламентын мөрдөн шалгах комиссуудыг томилон ажиллуулахдаа пүүс, компаниудаас улс төрийн намуудад мөнгө хандивлахдаа гүйцэтгэх засаглалд нелеөлөх оролдлого байсан эсэх, эсвэл албан тушаалтанд шууд мөнгө өгч, өөреөр хэлбэл хээл хахууль өгч, төрөөс гаргах шийдвэрт налөөлөхийг оролдож байсан эсэх асуудлыг нэг бус удаа шалгуулж байв.

Парламентын хэлэлцүүлгийн үед серөг хүчин засгийн газрын гишүүд болон засаг захиргааны бусад байгууллагын албан тушаалтаас гаргасан алдаа дутагдлыг ил тод хэлэх, шүүмжлэх, улмаар арга хэмжээ авахыг, түүний дотор албан тушаалаас нь огцуулахыг шаардах эрхтэй. Олонхи болоогүй нехцөлд тэд шаардлагаа хэрэгжүүлэх боломжгүй боловч олон нийтийн үзэл бодлын шахалтаар засгийн газар нь хүмүүсийг халж солих арга хэмжээ авахаас өөр аргагүй байдалд хүрч болох юм.

Дээр хэлсэнчлэн, парламентын хяналт нь улс төрийн хяналт юм. Өөреөр хэлбэл зарим талаар эргэлзээтэй шалгуураар улс төрийн үнэн зөв хяналт тавина гэсэн үг. Парламентын хяналтанд хууль зүйн хяналт, тухайлбал, гүйцэтгэх засаглалын үйл ажиллагаа хуулийн дагуу явагдаж байгаа эсэхэд тавих хяналт багтана. Энэхүү хяналтанд хуульчлагдсан болон хуульчлагдаагүй

ёс зүйн зарчмыг мөрдөж байгаа эсэхэд тавих хяналт бас хамаарна. Жишээлбэл: парламентаас явуулсан хяналтын үр дүнд төрийн сайд буюу өөр ямар нэгэн өндөр хэмжээний албан тушаалтан хууль зөрчөөгүй ч гэсэн улс төрийн болон ёс зүйн алдаа дутагдал гаргасан байвал тэр нь түүний ажлаас нь өөрчлөх шалтгаан болж болох юм.

Алдаа дутагдлыг парламентын хяналтаар бус харин хэвлэл мэдээллийн шугамаар илрүүлсэн тохиолдолд түүний үр дагавар мөн адил байж болно. Ийм явдал ХБНГУ-д нэг биш удаа гардаг. Нийгмийн болон нийгмийн санаа бодлыг хянах функц нь ялангуяа чөлөөт ардчиллын нохцолд зайлшгүй шаардлагатай.

**Хоёрдугаар бүлэг:** Мандат эзэмшигч ба албан тушаал эрхлэгчээс ёс зүйн зарчмыг сахиулаад чиглэсэн зохицуулалт ба журам

1) Мандат эзэмшигчид ба албан тушаал эрхлэгчдийн хоорондын ялгаа: Германы хуулийн дагуу мандат эзэмшиж буй парламентын гишүүд, албан тушаалтны хооронд зарчмын ялгаа байдаг юм. Албан тушаал эрхэлж буй хүмүүсийн хүрээнд засгийн газрын гишүүд, түшмэд, шүүгчид, цэргийн албан хаагчид ордог. Энгийн албан хаагчид ба улсын байгууллагад ажиллагсад нь хууль зүйн талаас ерөнхийдөө түшмэдтэй адил төстэй түвшинд байдаг боловч бас ялгаа бий. Жишээлбэл, тэд ажил хаях эрхтэй.

Албан хаагчид, түшмэд, шүүгчид, цэргийн албан хаагчдын нийлбэрийг улсын алба гэж нэрлэнэ. Мандат эзэмшигч ба албан тушаал эрхлэгчдийн хоорондын ялгаа нь мөн эдгээр 2 группэд холбогдох хууль тогтоомж нь өөр өөр байдаар илэрнэ. Энэ нь ялангуяа миний жишээ болгож ярих гэж байгаа салбарт бүр ч тодорхой байдаг юм.

Намайг зөв ойлгохыг хүсье. Парламентын гишүүний ч, албан тушаалтны ч хувьд адил үйлчилдэг бөгөөд янз бүрийн хууль тогтоомжид тусгагдсан ёс зүйн хэм хэмжээнүүд байдаг. Жишээлбэл, хээл хахууль авах нь хэний ч хувьд хориотой зүйл. Энэ тухай би дараа ярих болно. Тэгэвч зохицуулах хэм хэмжээний хууль зүйн үндэс нь өөр өөр юм. Нэг талд сонгуулиар олж авсан парламентын гишүүний мандат, негee талд нь албан тушаалтай холбогдох үүрэг байна.

2) Албан тушаал эрхпэгчдэд хамаарах хэм хэмжээ: Эхлээд албан тушаал эрхлэгчид, түүний дотор улсын байгууллагын албан хаагчид, ажиллагсадын тухай яръя. Би зарим асуудлыг товч товч дурьдах болно.

1. Ул зохицох, тодорхой ажил эрхлэхийг хориглох, туслах ач холбогдолтой ажил эрхлэлтийг хориглох, зөвшөөрөх

Манай төрийн тэргүүн - Холбооны ерөнхийлөгч нь засгийн газрын болон парламентын гишүүн байх ёсгүй. Тэрбээр цалинтай бусад албыг хা�ших, орлого олох зорилго бүхий аливаа аж ахуйн нэгжийн удирдах болон хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүнд байх эрхгүй 19X-ийн 55-р зүйл.

Энэхүү шийдвэрийн утга учир нь хэд хэдэн албан тушаал эрхэлсний улмаас Үндсэн хуулийн эрх зүйн зөрчилдөөн гарахаас урьдчилан сэргийлэхэд оршино. Хувийн секторт ажил эрхлэхийг хориглосон нь ерөнхийлөгч хувийн ашиг сонирхлын үүднээс хандаж байна гэсэн сэтгэгдэл төрүүлэх ёсгүй гэдэг үүднээс хандсан учиртай. Дээр дурьдсан хуулийн хэм хэмжээг зөрчсөн ерөнхийлөгчийн талаар Үндсэн хуулийн шүүхэд гомдол гаргаснаар хориотой үйлдлийг зориуд санаатайгаар хийсэн нь нотлогдвол түүнийг албан тушаалаас огцруулах боломжтой.

Манай парламентын засаглалын системд Холбооны засгийн газрын гишүүд-Холбооны канцлер, Холбооны сайд нарыг парламентын гишүүн байхыг зөвшөөрдөг. Манайд засгийн газрын бараг бүх гишүүд парламентын гишүүний мандаттай байгаа. Холбооны канцлер болон Холбооны сайд нар Ерөнхийлөгчийн адил өөр ажил, мэргжил эрхлэх, мөн ашиг орлогын зорилго бүхий аливаа пүүс, кампанийн удирдлага, хяналтын зөвлөлийн гишүүн байх эрхгүй. Гэхдээ Бундестаг зөвшөөрсөн нехцелд тэд пүүс, кампанийн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд сорлцож болно.

Парламентын төрийн нарийн бичгийн дарга хэмээх албан тушаалтны хувьд мөн адил хууль тогтоомж үйлчилдэг боловч онцгой зөвшөөрлийг тэдний хувьд Холбооны засгийн газар цөөн өгдөг юм.

Эдгээр хууль тогтоомжийн учир шалтгаан нь олон янзын ажил, албан тушаал эрхэлсний улмаас гарч болзошгүй зөрчилдөөнеөс урьдчилан сэргийлэхэд оршино.

Манай практикт цөөн хэдэн тохиолдолд зарим сайд, төрийн нарийн бичгийн дарга наарт төрийн бүрэн буюу хагас эзэмшилд байгаа аж ахуйн нэгжийн удирдлага буюу хяналтын зөвлөлийн гишүүн байхыг зөвшөөрсөн юм.

ХБНГУ-д төрийн сайд, парламентын төрийн нарийн бичгийн дарга нарын талаар Үндсэн хуулийн шүүхэд гомдол гаргах журам байдаггүй. Дээр дурьдсан үүргээ зөрчсөн тохиолдолд тэдэнд эрүүгийн хариуцлага ч хүлээлгэдэггүй. Эдгээр үүргээ зөрчсөн эсэхийг дээр дурьдсан парламентын хяналтын шугамаар шалгаж болох юм. Өөртөө ногдсон үүргийг зөрчсөн нь тогтоогдвол холбогдох сайд, төрийн нарийн бичгийн дарга албан тушаалаасаа огцрох нь дамжигүй.

Түшмэд, шүүгч, цэргийн болон бусад албан хаагчдын хувьд гол ажил үүргийнхээ хажуугаар өөр ажил эрхлэхийг нь зарчмын хувьд хориглогоогүй боловч зөвшөөрлийг холбогдох удирдах албан тушаалтан олгодог юм. Албан үүргээ гүйцэтгэхэд саад болохгүй нехцелд өөр ажил эрхлэх зөвшөөрлийг олгодог. Энд ч мөн янз бүрийн ажил үүрэг хоёр хоорондоо зөрчилдехеес урьдчилан сэргийлэх зорилго тавигдана. Тухайлбал, өөр ажил эрхлэх нь тухайн албан тушаалтан үндсэн ажлаа хийхэд нь саад болох эсэх, тухайлбал цаг хугацааны дарамтанд орох эсэхийг шалгасан байх ёстой. Түшмэд, шүүгч, цэргийн албан хаагчид өөр ажил эрхлэхтэй холбогдсон хууль тогтоомжийг зөрчвэл тэдэнд сахилгын арга хэмжээ авна. Мөн улсын байгууллагын албан хаагчид, ажиллагсдын хувьд мөн адил төстэй журам үйлчилнэ.

Дүгнэж хэлэхэд, хоорондоо үл зохилдох алба хা�ших, ашгийн телее байгууллагад ажиллахыг хориглох, мөн өөр ажил эрхлэхийг хязгаарласан хууль тогтоомжийн нэгдмэл утга санаа нь ажлын үндсэн үүрэг ба өөр алба хашсаны улмаас зөрчилдөөн гарахаас урьдчилан сэргийлэхэд оршиж байгаа юм.

## 2) Авилгалын хэрэг үйлдэх, авилгалд автах:

Өөртөө ногдсон үндсэн үүргийг журам ёсоор биелүүлэхэд саад болдог шалтгаан нь зөвхөн өөр ажил мэргжил эрхлэх явдал биш юм. Өөр төрлийн нэгэн аюул бол тодорхой алба хашиж буй этгээд өөрийнхөө ажил үүрэгтэй холбогдуулж менгэ буюу бусад зүйлийг гурав дахь этгээдээс авах явдал юм. Товчоор хэлэхэд энэ нь авилгал юм.

Германд сайдас авхуулаад төрийн байгууллагын ажиллагсдыг хүртэл бүх албан тушаал эрхлэгчдэд адил хэмжээгээр авч үздэг хоёр янзын гэмт хэрэг байдаг. Үүнд:

- Өөрийнхөө гүйцэтгэж буй албан үүрэгтэй холбоотой албан үүрэг нь харш бус үйлдлийн телее менгэ буюу түүнтэй адилтгах зүйл авсан, өгөхийг шаардсан буюу өгөхөөр ам авсан этгээдийг Германы Эрүүгийн хуулийн 19X-ийн 331-ийн дагуу торгох буюу 2 жил хүртэл хорих ялаар шийтгэдэг юм.

- Харин тодорхой албан тушаал эрхэлж буй этгээд нь өөрийнхөө үндсэн үүрэгтэй харш үйлдлийг хийхийн телее менгэ, бусад үнэт зүйл авсан, өгөхийг нэхсэн буюу өгөхөөр ам авсан бол түүнийг ЭХ-ийн 332-р зүйл ёсоор хээл хахууль авсных нь хувьд 6 сараас 5 жил хүртэл хорих ялаар шийтгэнэ.

Үүний зэрэгцээ холбогдох сахилгын арга хэмжээ авахаас гадна тэрбээр мэдээж мөн учруулсан хохирлыг хариуцах үүрэгтэй. Албан тушаал эрхэлж буй хүнд хээл хахууль өгсөн этгээдийг мөн эрүүгийн хариуцлагад татна. Ийм тохиолдолд

тэдний хувьд ЭХ-ийн 333, 334-т заасан шийтгэлийг хүлээлгэнэ.

Авилгалтай тэмцэх ба авилгалаас урьдчилан сэргийлэх зорилгоор Германд саивтар хэд хэдэн шинэ хууль тогтоомж гарсан. Эдгээр хуулийн дагуу хээл хахууль авах, өгөх гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хүлээлгэх шийтгэлийг чангатгасны зэрэгцээ авилгалаас урьдчилан сэргийлэх, түүнийг илрүүлэхэд чиглэсэн албаны ба сахилга хууль зүйн арга хэрэгслийг илүү үр дүнтэй болгосон юм.

Одоогоор Холбооны засаг захирагааны байгууллагуудад авилгалаас урьдчилан сэргийлэх тухай Холбооны засгийн газрын тогтоолыг боловсруулж байгаа бөгөөд түүний заалт нь мөн л дээр дурьдсан утга агуулгатай байх болно. Энэ талаар тодорхой ярих шаардлагагүй гэж үзэж байна.

### 3) Парламентын гишүүд, мандат эзэмшигчдэд хамаарах хууль тогтоомжууд:

#### 1. Чөлөөт мандат. Албан тушаал эрхлэгчдэд хамаарах хууль тогтоомж үйлчлэхгүй байх:

Германы парламентын гишүүний эрх зүйн статус нь өөрийн онцлогтой. Тэдний гүйцэтгэх үүргийг хуулиар тогтоогоогүй бөгөөд үүгээрээ тэд түшмэд ба улсын байгууллагын бусад албан тушаалтнаас ялгаатай.

Чөлөөт мандат эзэмшигчийн хувьд парламентын гишүүн нь аливаа даалгавар, удирдамжаас чөлөөтэй байх бөгөөд түүнд дарга байхгүй. Түүний цалин ч, түүний хийсэн ажил үүргийн хэлс биш, харин түүний хараат бус байдлыг хангаж 19X-ийн 48-р зүйлийн 3-р хэсэгт, төрд гүйцэтгэж байгаа үүрэгт нь таарч тохирсон амьдралын түвшинг хангах зорилготой юм. Тийм учраас Холбооны Үндсэн хуулийн шүүх парламентын гишүүний цалинг түшмэлийн цалинтай адилтгаж үзэхийг хориглосон юм.

Үүний зэрэгцээ парламентын гишүүн нь манай Үндсэн хуульд тунхагласан хүний үндсэн эрх, тухайлбал, ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох эрхийт эдэлнэ. Үүнийг болон мөн парламентын гишүүний мандат нь тодорхой ажил албыг тодорхой цаг хугацаанд гүйцэтгэх үүрэг ногдуулдаггүй харгалzan парламентын гишүүн нь мандатаар олгогдсон үүргээ гүйцэтгэхийн хажуугаар өөр ажил мэргэжил эрхлэх эрхтэй байдаг юм. Түшмэдээс ялгаатай нь өөр ажил мэргэжил хийхийн тулд парламентын гишүүн тусгай зөвшөөрөл авах шаардлагагүй байдаг юм. Харин парламентын гишүүн гүйцэтгэх болон шүүхийн засаглалын харьяаллын ажил алба хашихыг хориглодог юм. Энэхүү хоорондоо үл зохицолдох ажил үүргийн тухай заалтуудыг

Үндсэн хууль (137-р зүйл), Бундестагийн гишүүний тухай хууль болон мөн түшмэлийн хууль, улсын байгууллагын албаны тухай бусад хуульд тусгасан байдаг.

Түшмэл хүн Бундестагт сонгогдвол тэрбээр парламентын гишүүний мандатыг хүлээж авах эсэхээ шийдэх ёстой болно. Парламентын гишүүн болсон нехцэлд тэрбээр түшмэлийн албан тушаалаас гишүүн байх хугацаандаа түтгэлзэх хэрэгтэй болно. Парламентын гишүүн хүн гүйцэтгэх засаглалын байгууллагад алба хаших буюу шүүгчээр ажиллах болбол түүний парламентын гишүүний бүрэн эрх нь дуусгавар болно. Харин дээр хэлсэнчлэн манай парламентын засаглалын тогтолцоонд парламентын гишүүний мандат болон гүйцэтгэх засаглалын албаны хоорондын үл зохицолдох зарчим засгийн газрын гишүүдийн хувьд, өөрөөр хэлбэл, Холбооны канцлер ба сайд нарын хувьд үйлчилдэггүй юм. Цашилбал, Парламентын гишүүний хувьд хуулиар тодорхойлсон албан үүрэг байдаггүй учир тэдэнд албан тушаалтнаас үйлдсэн авилгальны гэмт хэргийн тухай хуулийн заалтуудыг хэрэглэх боломжгүй. Парламентын гишүүнээс үйлдсэн авилгальны гэмт хэргийн бүрэлдэхүүн нь өөрөөр тодорхойлогоно.

#### 2. Парламентын гишүүнд холбогдох авилгальны хэрэг; Парламентад явагдах сонгууль, санал хураалтад оролцох парламентын гишүүний саналыг "худалдаж авсан" эсвэл "худалдсан" этгээдийг парламентын гишүүнд хээл хахууль өгсөн гэж үзнэ. Энэхүү эрүүгийн хариуцлага бүх түвшингийн парламентад үйлчилнэ: Бундестаг-муж улсын парламент-хот, тосгоны хурал.

Буруутай этгээдэд мөнгөн торгууль ногдуулах буюу 5 хүртэл жилээр хорих ялаар шийтгэнэ. Саналыг "худалдаж авах" болон "худалдах" гэдэг нь хээл хахууль өгсөн болон парламентад явагдсан санал хураалтын хооронд холбоо байна гэсэн үг бөгөөд авилгальны хэрэгт оропцогсад, өөрөөр хэлбэл хээл хахууль өгсөн этгээд ба парламентын гишүүн ийм зорилготой байсан байх ёстой. Ийм тохиолдолд санал худалдаж авсан этгээд, өөрөөр хэлбэл хээл хахууль өгөгч, мөн саналаа худалдсан парламентын гишүүн хоёр этгээд хоёулаа гэм буруутай болно.

Парламентын гишүүнтэй холбогдсон авилгальны хэрэгт Германд хэдхэн жилийн өмнөөс эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг болсон нь Та нөхдийн гайхшлыг төрүүлж болох юм. Үүний хүртэл 40 жилийн турш эрүүгийн хариуцлагад татдаггүй байв. Энэ нь парламентын гишүүнтэй холбогдсон авилгальны хэргийг зөвтгэж байсан хэрэг огтхон ч биш. Үүний шалтгаан нь өөр юм. 50-иад оны эхэн хүртэл парламентын гишүүд хээл хахууль өгөх явдлыг гэмт хэрэгт тооцдог байсан. 50-иад оны

эхээр Эрүүгийн хууль шинэчлэгдсэн боловч тэр үедээ парламентын гишүүдтэй холбоотой авилгалын хэргийн бүрэлдэхүүний талаар нэг саналд хүрч чадаагүй учир энэ тухай заалт тэр үед эрүүгийн хуульд орж чадаагүй юм.

Асуудал хойшлогдоор байгаад 1994 он хүрсэн юм. Тэр онд парламентын гишүүнтэй холбогдох авилгалын хэргийн бүрэлдэхүүний тухай хуулийн заалтын төслийг парламентын олонхи гишүүд зөвшөөрснөөр энэ заалт хүчин төгөлдер болсон. Дээрх заалтыг батлах болсон шалтгаан нь парламентын гишүүд авилгалын хэрэгт холбогдсон юм уу эсвэл бүр тийм хэрэг олширсонд биш юм. Парламентын гишүүд нь түшмэд ба бусад албан тушаалтнаас илүү эрх дарх эдэлж байгаад дургүйцэх явдал нийгэмд бий болсон бөгөөд тэр нь есөх хандлагатай байв.

Дашрамд хэлэхэд манайд аль хэдийнээс сонгогчдод хээл хахууль өгвэл эрүүгийн хариуцлага хүлээлгэж ирсэн түүхтэй. Хуулийн энэ заалтын дагуу сонгочийн саналаа өгүүлэхгүй байх буюу тодорхой зорилготойгоор саналыг нь өгүүлэхийн тулд түүнд менгэ буюу бусад давуу талыг олгосон, өөрөөр хэлбэл санал худалдан авагч этгээдэд эрүүгийн хариуцлага ногдуулдаг юм. Үүнийн нэгэн адил мөн саналаа худалдсан этгээдэд хариуцлага хүлээлгэнэ.

**3. Парламентын гишүүний биез авч явах дүрэм:**  
Манай илтгэлийн төгсгөлийн бүлгийн сэдэв нь Та бүхний сонирхлыг илүү их татах байж магадгүй.  
**а) Зөв ойлгохын тулд:** "Германы Бундестагийн гишүүдийн биез авч явах дүрэм" гэсэн гарчиг нь хүмүүст буруу ойлголт төрүүлж болох юм. Гарчгаас хараад парламентын гишүүд парламентын дотор, гадна биез яаж авч явах ёстой юм бэ гэснийг заасан, парламентын гишүүний мэргэжлийн ёс зүйн тухай дүрмийн бүхэл бүтэн эмхэтгэл байдаг мэт сэтгэгдэл төрмөөр. Гэхдээ энэ тийм биш юм. Манай энэ дүрэм маань хүнд хэцүү асуудлыг шийдвэрлэхийг хичээсэн нэгэн оролдлого төдий зүйл юм. Нэг талаас парламентын гишүүний төлөөлөх ёстой нийгмийн ашиг сонирхол, негee талаас парламентын гишүүний гурав дахь этгээдийн эдийн засгийн ба санхүүгийн хувийн ашиг сонирхлын хоорондын зөрчилдөөний асуудал байдаг.

Германд бол нэн ялангуяа парламентын гишүүдийн хувьд энэ асуудлыг зохицуулах чухал шаардлагатай байдаг. Яагаад гэвэл, миний дээр хэлсэнчлэн, парламентын гишүүн нь мандатаар олгогдсон үүргийнхээ хажуугаар ерөнхийдөө бусад ямар ч ажил мэргэжил эзэмших эрхтэй байдаг юм.

**б) Түүхийг эргэн сөхвөл:** Бидний өгүүлж буй

янз бүрийн ашиг сонирхлын хоорондын зөрчилдөөний асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн анхны оролдлогыг Германанд дэлхийн 1-р дайны дараа Ваймарын бүгд найрамдах улсын үед хийсэн юм. Гэвч нэг саналд хүрч чадаагүй учир энэ оролдлого амжилтгүй болов.

1949 онд ХБНГУ-ыг байгуулсны дараа Германы Бундестагийн гишүүдийн нэр сүрийн дүрэм хэмээх баримт бичгийг баталж гаргахыг ордсон юм. Тэр үеэс хойш 20 гаруй жил өнгөрсний дараа дөнгөж 1972 онд парламентын гишүүний биез авч явах дүрмийг батлав.

Энэ нь сониноос улс төрийн нэгэн хэрэг явдлын дараа болсон үйл явдал юм. Бундестагийн нэг гишүүнийг өөр намд гишүүнээр элсүүлэхийн тулд түүнд зөвлөхийн ажил амласан, өөрөөр хэлбэл, түүнд санхүүгийн давуу тал бий болгох санал гаргасан явдал гарсан гэдэг. Түүнээс хойш манай парламентын гишүүдийн биез авч явах дүрэмд удаа дараа нэмэлт өөрчлөлт оруулж байв. Үүний шалтгаан нь мөн л энгийн улс төрийн хэрэг явдал \Фликийн хэрэг\ байснаас гадна Холбооны Үндсэн хуулийн шүүхээс парламентын гишүүний эрх зүйн тухай шийдвэрийн талаар өгсөн тайлбар байсан юм.

**в) Бундестагийн гишүүний биез авч явах дүрмийн зорилго, агуулга:** Дүрэмд хорио цээр тавих явдал давамгайлдаггүй. Түүний "философи" нь юуны өмнө мэдээлэл өгөх ба мэдээлэн нийтлэхийн хүчээр бодитой буюу гарч болзошгүй ашиг сонирхлын зөрчилдөөнөөс урьдчилан сэргийлэхэд оршино. Гэвч энэ дүрэм маань парламентын гишүүнийг нэвт харагдуулах боломж олгодог ид шидтэй зүйл бас биш юм.

Манай дүрэмд еронхийдөө З зүйлийг багтаасан юм. Үүнд:

**Нэгдүгээрт:** парламентын гишүүнийхээ үүргийн хажуугаар өөр ямар ажил мэргэжил эрхэлж буй тухайгаа Германы Бундестагийн ерөнхийлөгчид мэдээлэх үүрэг үүсэн бий болох шалтгааны дэлгэрэнгүй жагсаалт, түүнээс гадна эдгээр мэдээллийг нийтлэх шалтгааны товч жагсаалт

**Хоёрдугаарт:** шалтгааны товч жагсаалт Дүрэм зөрчсөн тохиолдолд авах арга хэмжээний тухай заалтууд. Дүрмийн цөм нь Бундестагийн гишүүнээс Германы Бундестагийн ерөнхийлөгчид мэдээлэх ёстой ажил мэргэжлийн дэлгэрэнгүй жагсаалт юм. Үүнд хамаарах зүйл:

- Парламентын гишүүн болохын өмнө эрхэлж байсан ба одоогоор мандатынхаа хажуугаар эрхэлж буй ажил мэргэжил
- Аж ахуйн нэгжийн буюу пүүс, компаний тэргүүлэгчид, хяналтын зөвлөл болон тэдгээртэй адилтгах нэгжийн гишүүн
- Эвсэл, холбооны сонгуультан
- Гэрээгээр зөвлөхийн ажил эрхэлдэг

- Магадлал гаргадаг болон лекц унших ажил эрхэлдэг
- Аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд нөлөө үзүүлэхүйц хэмжээний хувь хөрөнгө эзэмшидэг гэх зэрэг болно.

Мэдээлэх ёстой ажил мэргжилд парламентын гишүүн байхдаа эрхэлж буй ажил мэргэжлээс гадна мөн түүнээс өмнөх ажил мэргэжил хамаарна.

Парламентын гишүүн байх үедээ веर ажил эрхэлж байгаа бол түүнийгээ мэдээлэх үүрэгтэйгээс гадна Германы Бундестагийн ерөнхийлөгчид мөн веर ажил эрхэлснээс олж буй орлогыг мэдүүлэх ёстой. Шүүх ажиллагааны хүрээнд буюу шүүхээс гадуур ХБНГУ-ын төлөө буюу эсрэг өмгөөлөгчөөр ажиллахдаа хөлс авч буй парламентын гишүүний хувьд мэдээллийн онцгой үүрэг байдаг.

Мэдээлэх үүргийн тухай дэлгэрэнгүй ярьж Та нарын цагийг барахыг би хүсэхгүй байна. Үүн дээр нэмж нэг л зүйл хэльв. Мэдээлэх үүрэг нь зөвхөн парламентын гишүүдэд хамаарахаас биш тэдний гэр булийн гишүүд ба бусад гурав дахь этгээдэд үл хамаарна.

**Нийтлэлүүд:** Бундестагийн гишүүдээс Германы Бундестагийн ерөнхийлөгчид гаргаж өгх ёстой мэдээллийн дийлэнхийг Германы Бундестагийн албан ёсны гарын авлагад нийтэлдэг. Харин веер ажил эрхэлснээс олсон орлогын тухай мэдээг нийтэлдэггүй. Үүн дээр хүмүүс их маргадаг. Хэдхэн сарын өмнө үндсэн үүргийнхээ хажуугаар веер ажил мэргэжил эрхэлсний үр дүнд олсон орлогын тухай мэдээг нийтэлж байх тухай саналыг Бундестагт оруулсан боловч түүнийг хүлээж аваагүй юм. Энэ асуудал цаашдаа яаж шийдэгдэх нь одоогоор тодорхойгүй байна.

Мэдээлэх ёстой бас нэг зүйл байдаг. Хэрэв парламентын гишүүд мэргэжлийнхээ дагуу буюу хөлсөөр Бундестагийн аль нэг байнгын хороонд хэлэлцэгдэх асуудал дээр ажиллаж байгаа бол энэ тухайгаа байнгын хороонд мэдэгдэх ёстой.

**Хороо:** Дүрмээр хориглосон хэдэн зүйлийн талаар яръя. Парламентын гишүүд веерсийнхөө үйл ажиллагааг явуулахын төлөө бүх төрлийн хандив, тэр тусмаа мөнгөн хандив хүлээж аваагыг зөвшөөрдөг юм. Хандив аваагыг тодорхой тохиолдолд, жишээлбэл, гадаад ороос хандив аваагыг хориглодог. Германад парламентын гишүүнд хандив өргөх нь олон жилийн уламжлалтай. Хандив өгөхийг хээл хахууль өгч байна гэж үздэггүй. Яагаад гэвэл энэ тохиолдолд түүний саналыг худалдаж авах асуудал гардаггүй, харин хандивын зорилго нь түүний улстериийн үйл ажиллагааг дэмжихэд оршдог юм.

Дүрэмд зааснаар парламентын гишүүд хүлээж

авсан хандивын бүртгэл хетлэх ёстой бөгөөд хандивын тодорхой хэмжээ 1жилд 10000 ДМ-аас хэтэрсэн нехцэлд хандив ба хандивлагчийн нэрийг Бундестагийн ерөнхийлөгчид мэдээлэх үүрэгтэй. Хандивын хэмжээ жилд 20000 ДМ-аас хэтэрвэл ерөнхийлөгч энэ тухай мэдээг нийтлэх ёстой.

Парламентын гишүүд маань "нууц ноёнтон" биш. Тэгэвч Бундестагийн гишүүн болохoo илтээр тодорхойлсон зүйлийг хувийн, мэргэжлийн болон бизнесийн зорилгоор хэрэглэхийг, тухайлбал гишүүн гэсэн албан бланк хэрэглэхийг дүрмээр хориглодог.

Дүрмээр эцэст нь "сонирхогчдоос төлөх хөлс" хэмээх зүйлийг хүлээж аваагыг хориглодог. Энэ нь ийм учиртай юм. Парламентын гишүүнтэй аливаа нэгэн ажил олгогч байгууллага, жишээлбэл, нэг компани хуурамчаар хөдөлмерийн гэрээ байгуулаад түүнд хийгээгүй ажлын төлөө хөлс олгохыг хориглодог юм. Ийнхүү хөлс төлөхдөө тухайн пүүс, компани парламентад өөрийнхөө ашиг сонирхлыг хамгаалуулах зорилго тавьдаг юм.

Дүрмийн заалтыг зөрчсөн тухай баримт илэрвэл үүнийг Бундестагийн ерөнхийлөгч шалгах үүрэгтэй. Эхлээд Бундестагийн холбогдох гишүүнтэй ярилцана. Дүрэм зөрчсөн байна гэж ерөнхийлөгч үзвэл тэрбээр энэ тухайгаа Бундестагийн ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгчээс бүрддэг. Бундестагийн тэргүүлэгчдэд болон намын бүлгүүдийн дарга нарт хаалттай хуралдээр мэдээлнэ. Энэ хурал дээр ерөнхийлөгчийн саналыг эсэргүүцэх явдал гарч болох бөгөөд ийм тохиолдолд тэрбээр асуудлыг үргэлжлүүлэн шалгах шаардлагатай болно. Ийнхүү шалгасны эцэст ерөнхийлөгчийн хийсэн дүгнэлтийг эсэргүүцэх ёсгүй.

Парламентын гишүүн дүрэм зөрчсөн тухай Ерөнхийлөгчийн эцсийн дүгнэлтийг Бундестагийн албан ёсны мэдээ болгож нийтэлнэ. Шалгасны үр дүнд парламентын гишүүн гэм буруугүй нь нотлогдвол мөн энэ тухай мэдээг нийтэлж болно. Ийм тохиолдолд парламентын холбогдох гишүүн энэ тухай мэдээлэхийг шаардах эрхтэй. Харин Бундестагийн ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгчид буюу намын бүлгийн ахлагчид Дүрмийг зөрчсөн гэсэн сэжиг байввал тэдний хувьд мөн адил журам үйлчлэх боловч тэд нар мэдээж веерсдее энэ процесст оролцохгүй, харин тэдэнтэй зөвхөн ярилцлага хийж сонсоно.

Манай дүрмийн дагуу зөрчил нотлогдсон тохиолдолд авах арга хэмжээ нь зөвхөн нийтлэл байдаг. Дүрмийн зөрчил нь зөвхөн шүүхээс гаргах ёстой эрүүгийн шийтгэлд хүргэдэггүйгээс гадна

мөн мандатыг хүчингүй болгох үндэс болдоггүй. Тэгсэн хэдий ч нийтлэх арга хэмжээний ач холбогдлыг дутуу үнэлж болохгүй. Германы Бундестагийн ерөнхийлөгч тодорхой гишүүн дүрэм зөрчсөнийг албан ёсоор мэдээлсэн тохиолдолд уг гишүүний цаашдын улстөрийн хувь заяа эргэлзээтэй болно. Ямар ч атугай ноцтой зөрчил үйлдсэн тохиолдолд түүнийг дараачийн сонгуулиар дахиж сонгохгүй гэдэг нь бараг эргэлзээгүй болдог. Ямар ч атугай манайд улам бүр идэвхжих буй олон нийтийн талаас маш их шахалт үзүүлэх нь дамжиггүй билээ.

Одоог хүртэл Германы Бундестагийн ерөнхийлөгч Дүрмийг зөрчсөн тухай албан ёсны мэдээлэл гаргаагүй байгаа нь мөн доорхи шалтгаантай гэж үздэг. Бундестагийн ерөнхийлөгч ба Бундестагийн Тамгын газар Дүрмийг сахиулах талаар Бундестагийн гишүүдэд байнга анхааруулж, эргэлзээтэй үед тэдэнд зөвлөж, тухайн гишүүн өөрийнхэе тухай мэдээлэх үүргийг буруугаар ойлгох буюу зөрчих магадлал гарсан тохиолдолд тэднийг алдаа хийхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авдаг юм.

Үүнээс гадна бас нэг хэлэх зүйл бол: Парламентын гишүүдийн биеz авч явах Дүрэмд энэ талаар тодорхой заагаагүй ч гэсэн, зөрчлийг зөвхөн санаатайгаар үйлдсэн тохиолдолд албан ёсоор нийтлэх зарчмыг манайд баримталдаг юм.

*Штази-д хамаарах шалгалт:* Энэ сэдвэтий холбогдуулж Германы Бундестагийн ерөнхийлөгчөөс албан ёсоор мэдээлэх ёстой вэр нэг зүйлийн тухай товч дурддья.

Хоёр Герман улс нэгдсэний дараа Германы Бундестагийн гишүүд урьд нь БНАГУ-ын Улсыг аюулаас хамгаалах албанад ажиллаж байсан эсэхийг шалгах процессуудыг хуулийн үндсэн дээр баталсан юм. Зарчмын хувьд бол энэ шалгалтыг тухайн Бундестагийн гишүүнээс хүсэлт гаргасан тохиолдолд явуулдаг. Үүнээс гадна холбогдох гишүүн хуучин БНАГУ-ын Улсыг аюулаас хамгаалах яаманд ажиллаж байсан тухай тодорхой баримт сэлт илэрсэн онцгой тохиолдолд шалгалтыг тухайн гишүүний зөвшөөрөлгүйгээр явуулж болно. Шалгалтыг Германы Бундестагийн дотоод журмын асуудал хариуцсан байнгын хорооноос удирдан явуулна. Энэ тохиолдолд ч авах арга хэмжээ нь мөн л

Бундестагийн албан ёсны мэдээ нийтлэх явдал байна. Холбогдох Бундестагийн гишүүн нь мэдээний хамт өөрийнхэе тайлбарыг нийтлүүлэх эрх эдэлнэ. Одоог хүртэл цөөн хэдэн тохиолдолд ийм албан ёсны мэдээг нийтэлсэн юм. Яг одоо олон нийтийн анхаарлыг ихэд татаж буй нэг асуудал шалгагдаж байгаа. Энэ нь Германы Ардчилсан социализмын намын Бундестаг дахь хэсгийн дарга доктор Гизи-тай холбогдсон асуудал юм.

г) Дүрмийн эрх зүйн статус: Эцэст нь Парламентын гишүүдийн биеz авч явах Дүрмийн эрх зүйн статусын тухай хэдэн зүйлийг хэлье.

Дүрэм нь Германы Бундестагийн дотоод ажлын журмын бүрэлдэхүүн хэсэг юм. Дотоод журам бол хууль биш бөгөөд түүнийг хууль батлах журамтай адил төстэй хялбарчилсан журмаар баталсан бөгөөд тэр нь зөвхөн Бундестагийн гишүүдэд хамаарах үйлчилгээтэй юм. Дотоод журам нь зөвхөн Германы Бундестагийн дотоод зохион байгуулалт, дэгийг зохицуулах зорилготой. Дотоод журам нь зөвхөн тухайн сонгуулийн хугацаанд хүчинтэй байдаг бөгөөд шинэ сонгууль болж өнгөрсний дараа түүнийг шинээр батлах ёстой.

Журмын нэг онцлог нь зарим тохиолдолд түүний заалтаас парламентын гишүүдийн гуравны хоёрын саналаар няцаж болдог явдал юм. Германы Бундестаг нь үндсэн хуулиар олгогдсон эрхийнхээ дагуу өөрийнхэе дотоод ажлын журмыг баталдаг бөгөөд түүнд энэ талаар тусгай хуулиар эрх ойлгох шаардлагагүй. Парламентын гишүүдийн биеz авч явах дүрэмд юг тулгавал зохижтойг парламентын гишүүдийн тухай хуульд заасан байдаг нь сонирхолтой юм.

Дүрэм нь нэг талаас журам, нөгөө талаас хуулийн эх үүсвэртэй байгаа нь зөвхөн онолын хувьд анхаарал татах асуудал биш юм. Тухайлбал Дүрмийн тухай албан ёсны тайлбарыг дотоод журмын байнгын хороо хийх ёстой юм уу эсвэл Бундестагийн ерөнхийлөгчийн ёстой юм уу гэсэн асуудал гарч болно. Эсвэл вэр нэг асуудал бол Дүрмийн заалтаас Дотоод журмын адил парламентын гишүүдийн гуравны хоёрын саналаар няцаж болох уу гэсэн асуулт гарна. Бид энэ асуултад үгүй гэсэн хариултыг егөх болов уу. Анхаарал тавьсанд баярлалаа.

Б. Дэлгэрмаа

УИХ-ын гишүүн, Хуний эрхийн дэд  
хорооны дарга

Улс төр нь төрийн эрх мэдлийн тусlamжтайгаар нийгмийн хөгжлийн процессийг удирдах, чиглүүлэх ухамсартай ўйл ажиллагааны хувьд нийгмийн сонирхлыг бүхэлд нь эсхүл тодорхой бүлгийн сонирхлыг хэрэгжүүлэхэд баримжаалсан байдаг. Улс төрийн субъектууд энэхүү ўйл ажиллагаандаа сайн сайхан, муу муухай, шударга ёс ба бусармаг явдал зэргийн талаар өөр өөрийн тесөөлөлтдэд хөтлөгддэг. Эдгээр ёс суртахууны хэм хэмжээ улс төрийн амьдралд оролцогчдын үйлдлийг чиглүүлэхэд нелөөлдэг. Гэхдээ амьдралд улс төр ба ёс суртахуун харилцан үйлчлэх явдал дээрх хэм хэмжээний аль нэг дээр үндэслэнэ гэдэг нь ховор, хэрэв тийм аваас энэ нь идеал байх болно.

Бодит амьдрал дээр улс төрд хамгийн шударга, үнэнч хүн орсон ч ялгаагүй өөрсдийн сайн сайхан чанараа алддаг тавилантай. Үүнийг янз бүрээр тайлбарлаж болно. Ийм эндерлэгт хүрээн хүний хэрэгцээ ёсдег байхад түүнийг хангах боломж хязгаарлагдмал хэвээр байдаг боловч эгэл жирийн хүмүүстэй харьцуулахад улс төрчид бусад хүнээр хангуулах боломжийг эрх мэдэл олгодог.

Чухамхүү улс төрийн эрх мэдэл баялаг болон неөцийг хуваарилах, дахин хуваарилах боломж олгодог шидээт нелөөтэй. Эрх мэдлийг ашигласнаар эд баялаг, бусдыг захирах хүсэл зэрэг эрмэлзлийг хангах боломжтой болно. Хүнийг эрх мэдлээр звдэж завхруулах явдлыг улс төрийн сургаалийн түүхэнд өнө эртнээс судалж тэмдэглэсэн байдаг. Улс төрийн ўйл ажиллагаанд дахь хенеэлт, деструктив шинжийг зогсоож барихыг ёс суртахууны тусlamжтай оролдож байжээ. Ёс суртахууны хэм хэмжээг заавал дагаж мөрдех нь олон нийтийн санаа бодол, хувь хүний өөрийн итгэл үнэмшилд үндэслэгддэг. Гэхдээ ёс суртахууны хэм хэмжээгээр эрх мэдлийг зохицуулах нь ураг төрлийн харилцаанд суурилсан бүдүүлэг нийгэмд илүүтэй тохиолдож байжээ. Хүний ўйл ажиллагааны онцгой төрөл болох улс төрийн тусlamжтай нийгмийн харилцааг зохицуулах болсон нь хүн төрөлхтний хөгжлийн бас нэгэн дэвшил болсон. Гэхдээ яг одоогийн хэв шинждээ хүрэх болтол хэд хэдэн хөгжлийн хувилбарыг үзсэн гэж хэлж болно.

Эхэндээ улс төрийг нийгмийн ёс зүй, ёс

суртахууны философи гэж үзэж байсан бол Н. Макиавеллийн нэртэй холбоотойгоор улс төр ёс суртахуун хоёр салган яригдах болсон. Ёс суртахуун нь мөнх оршино, учир нь ёс суртахууны сургааль түгзэмэл, үүнийг хүмүүс дагаж мөрдех нь сайн дурын хэрэг.

Тэгвэл улс төрд илүү прагматик хандлага давамгайлах ёстой. Улс төрд сонирхлын эрх ашиг давамгайлах тулд эдгээрийг хэрэгжүүлэх нь янз бүрийн нэхцэл байдалд болно, эдгээрийн нелөөн дор улс төрийн субъектууд зорилгоо өөрчилж болно. Ийнхүү сонирхлын ялгарал, улс төрийн тэмцлийн нэхцэлд үгэндээ хүрэх, үнэнч шударга байх нь магтууштай чанар гэж үү? Зорилгодоо хүрэхийн тулд ямар ч аргыг хэрэглэж болно хэмээсэн ёс суртахуунгүй бодлогын дүрийг боловсруулсан хүн бол Макиавелли. Энэ дүрмээр олон үеийн улс төрчид тоглож ирснийг дурьдахад илүүдэхгүй бизээ.

Үүнээс хойш сэтгэн бодогчид улс төр ба ёс суртахууны холбоосыг гаргах гэж оролдож байсны дотор Т. Жефферсон удирдлагын урлаг үнэнч шударга байхад оршино хэмээж байсан бол, М. Вебер улс төрийн онцлог бол хүч хэрэглэх явдал тул ёс суртахуун хүчирхийлэл хоёрыг тэрээр өвлөрүүлэхийг оролдож тодорхой үе шатанд хувааж байжээ. Тухайлбал, улс төрийн шийдвэр гаргахын өмнө улс төрч өөрийн итгэл үнэмшил, ёс суртахууны зарчмыг баримталж болно харин шийдвэр гаргахдаа түүний үр дунг тооцох ёстой. Гэхдээ аль болох бага хор учруулах, өөрийн ёс суртахууны зарчмаа хатуу баримтлах хоёрын алиныг сонгох вэ гэсэн асуудлыг улс төрчид өөрт нь үлдээжээ. Ингэснээр улс төрд ўйл байдлын ёс суртахууны нэгдсэн кодекс байх шаардлагагүй, тодорхой нэхцэл байдалд ўйл байдлын моделийг улс төрч өөрөө сонгох ёстой ажээ.

Улс төр судлалын шинжлэх ухааны үүднээс дээр хэлсэн зүйлтэй холбоотой өнөөдөр улс төр ба ёс суртахуун хоёрыг холбох зүйл нь улс төрийг хүмүүнлэг болгоход чиглэсэн хуулиуд үйлчлэх байдлаар илэрнэ. Улс төрийн хүмүүнлэг шинжийг тодорхойлсон түгзэмэл шалгуурыг тогтоож улмаар эдгээр шалгуур нь болсон хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулж үүгээр улс төрчийн ўйл ажиллагааны утга учир, хариуцлагыг хэмжих ёстой. Улс төрд ёс суртахууны үүднээс хандах явдлын ач холбогдлыг нийгмийн зүгээс улс төрийн институтуудыг хянах боломжид оршино. Ингэснээр нийгмийн хувь заяаг хариуцагч улс

терчдийн үйл ажиллагааг нээлттэй, ил тод болгож, буруутай үйлдлийн төлөө хариуцлага хүлээх зэрэг зүүрүүл байдал тогтоно.

Одоо улс төрийн соёлын асуудлыг ёс зүйн огтолцолд товч хөндье. Улс төрийн үйл байдлын соёлын кодыг өөрчлөх явдал тун удаан хугацааг шаарддаг. Ноёрхогч элитийн улс төрийн оролцооны соёлд тооцоологдсон улс төрийн шийдвэр нь ард нийтийн уламжлалт албат шинжтэй соёлтой тулгардаг. Ийнхүү улс төрийн институтын шинэ бүтэц соёлын хуучин стандарт хоёр хоорондоо нийцэхгүй болохоор улс төрийн зерчилдөөн, хямралт байдалд хүргэнэ. Чилжилтийн үе дэх үндсэн үнэт зүйлс, идеал, нийгмийн зорилгын талаар субкультурын зөвгч нарын хооронд үл зохицолдох нь илүүтэй гарч байгаа тул манай хүн амын зүгээс төрийн институтэд итгэх итгэл доогуур, зөрчлийг хууль ёсоор шийдэх арга замыг үл тоомсорлох хандлага давамгайлж байна.

Илтгэлийнхээ эхэнд ийнхүү улс төр ба ёс суртахууны холбоос, улс төрийн соёл ба улс төрийн ухамсырын асуудал зэрэг дээрх тезисийг авч хэлэлцэх нь бидний өнөөдөр хэлэлцэх гол сэдэв болох улс төрийн ёс зүйн асуудалтай шууд холбоотой. Улс төрийн ёс зүй төлөвшүхэд тухайн нийгмийн үнэт зүйлс, ёс суртахууны хэм хэмжээ, улс төрийн уламжлал шууд нелөөлдгийн дээр улс төрийн шийдвэр гаргах процесст оролцогч гол субъект болох улс төрийн үйл байдал, түүнийг хуульчлан зохицуулсан хэм хэмжээ ихээхэн чухал болж байгаа нь нийгмээс тавьж буй шаардлагаар нөхцөлдөж байна.

Үчир нь хөгжлийн хямрал хурцдахын хамт хөгжиж буй орнуудын төрийн хямрал анхаарал татаж байна. Энэхүү хямралт байдлыг судлаачид, "туравдагч ертенцэд ч гэсэн төрийн аппарат хэт хүчирхэг болсон, энэ нь эдийн засгийн хөгжлийг сватуулж хувийн санаачилгыг живүүлж хэт хүнд сурталжсан үр ашиггүй, голдуу коррупцийн шинжтэй бөгөөд дэлхийн эдийн засгийн тогтолцоог нийцүүлэхэд саад учруулж байна" гэсэн байдлаар нэгэн утгатай оношложээ. Тэгвэл хөгжлийн хямрал нь тогтолцооны трансформац хийж буй манай орны хувьд бүр ч илүү тусах нь ойлгомжтой.

Эргэлтийн дараахи 1990 оноос эхлэн хугацаанд улс төр, эдийн засаг, социал ямар өөрчлөлт манай нийгэмд гарсан бэ гэдэгт дүн шинжилгээ хийснээр улс төр дэх ёс суртахууны асуудлыг тодорхойлох боломжтой. Гэхдээ асуудлыг нэлээд явцуу хүрээнд үзвэл:

**Улс төрийн салбарт:** олон нам үүсч бий болсон, эрх мэдэл өргөжсөн, улс төрийн янз бүрийн хорио цээрийг устгасан, эрх мэдлийн, юуны өмнө гүйцэтгэх эрх мэдлийн чиг үүрэг супарсан.

Эдийн засгийн салбарт: үйлдвэрлэл хумигдсан, үнэ либералчлагдсан, эдийн засгийн гадаад харилцаа чөлөөтэй болсон, хуучин дамын наймаа гэж үзэж байсан үйл явцыг зөвшөөрсөн, хүн ам ядуурсан.

Оюуны хүрээнд: эрх зүй, ёс суртахууны хэм хэмжээ ач холбогдоо алдах, уламжлалт үнэлэмж гээгдэх, хуулиар хориглоогүй бүгдийг зөвшөөрнө гэсэн зарчмын "хуулиар хориглоогүй" гэсэн хэсэг нь үйлчлэхгүй болж дур зоргоор авирлах явдал газар авсан.

Одоо үүний улс төрийн ёс зүйтэй холбож үзэхийг оролдье, өөреөр хэлбэл орчин үед манай нийгэмд явагдаж буй процессыг улс төр ба ёс суртахууны холбоосын өнцгөөс тайлбарлада.

Өнөөдөр хоёр төрлийн зөрчил буюу зааг ялгаа байна.

1. Хувь хүн, хүн амын аль нэг давхрааны хэрэглээ, боломж хоёрын хоорондын зааг ялгаа
2. Эрх зүйн хэм хэмжээ ба хүн амын үнэлэмжийн баримжаа хоёрын хоорондох зөрчил

Улс төр, эдийн засаг, оюуны хүрээнд бий болсон дээр дурьдсан үзэгдэл энэ хоёр зөрчлийг хурцатгажээ. Тухайлбал, урт удаан хугацаанд хэрэглээ нэг ижил ойролцоо түвшинд байсан бол одоо нэлээд их ялгаа гарч байна. Хүн амын ихэнх хэсэг хэрэглээгээ багасгахаас өөр аргагүйд хурсэн байхад, цөөнхийн хэрэглээ эрс нэмэгдсэн, хүмүүсийн үйл байдлын шинэ хувилбарыг бий болгодог зах зээлтэй холбоотойгоор боломж нь ч их өргөжсөн. Одоо хүн амын ихэнх нь давхар орлоготой болжээ. Эдгээр орлогын нэлээд нь хууль бус шинжтэй юм.

Эрх зүйн шинэ хэм хэмжээ тэр бүр үйлчлэхгүй байна. Мөнгө, ашиг орлогыг тахин шүтэж, "баяжигтун" лоозон амьдралд дэвшигдлээ. Ийнхүү хүн амын шинэ бодит баримжаа, эрх зүйн хэм хэмжээ хоорондоо зөрчигдэх нь үлэмж ихэслээ. Гэтэл материаллаг амжилт бүх нийтийг хамарсан зорилго болсон байхад төрөөс түүнд хүрэх хуулиар зөвшөөрөгдсөн аргыг хангаагүй, иймд ашиг олохын тупд ямар ч арга хэрэгсэл ашиглахаас буцахгүй болжээ.

Хуучин тоталитар хүнд суртлын хяналтын систем Намын хянан Шалгах Хороо, Ардын Хянан Шалгах Хороо, прокурорын өронхий хяналт гэх мэт нурсан, гэтэл эдийн засгийн шинэ хяналтын механизм хүчтэй үйлчилж чадахгүй байгаа энэ үед төвлөрсөн удирдлагат хуваарилалт үгүй болж, үнэ цалин хөлсний түвшинд хяналт байхгүй болсон зэрэг нь зах зээлийн харилцаанд оролцогчийн эрх ашигт үл нийцүүлэн өмчийг солилцоо бус тэгш байдлаар дахин хуваарилалтад оруулсан юм. Өөреөр хэлбэл, зах зээлийн хуулиар бус, төрийн аппаратын албан тушаалтны үзэмжээр өмчийн

хэлбэр солигдох зэрэг нь тэгш бус солилцоог бий болгосон. Энэ нь хувьчлагдах объект, түүний үнийг тодорхойлоход албан тушаал шийдвэрлэх хүчин зүйл болж, ингэснээр коррупцийн боломжийг нэмэгдүүлж байна. Тухайлбал, маш хямд төсөр үнээр түүхий эд материалыг худалдан авч гадагш гаргах, ямар нэг бодит баталгаагүйгээр зээл олгох, албан тушаалтан давхар ажил хийх, өөрийн хяналтад байдаг арилжааны бүтцэд орох зэрэг явдал шинэ засаг төрд ч үргэлжилсэн хэвээр байна.

Гэвч улс төрчийн ёс зүйн асуудлыг судалж тодорхойлохдоо шинэ социал-эдийн засгийн бодит байдлыг мэдэрч ойлгох нь чухал. Эдийн засгийн үйл байдал, улс төрийн үйлдэлд дүгнэлт хийхэд хуучин тесеөллөөр хандаж үнэлэх нь нэгэнт учир утга багатай юм. Ялангуяа здийн засгийн үйл байдлыг үнэлэхдээ зарим талаар өрөөсгөл, нотолгоогүй байх нь элбэг байна. Социалист нийгэмд хөдөлмөрийнх бус орлого, дамын наймаа гэгчтэй өне удаан жил тэмцэж ирсэн нь биржийн арилжаа, богино хугацаанд гэнэт баяжих, менгэ хөрөнгө нэг хүнд төвлөрөх зэрэг байх ёстой зүйлийг ердийн ухамсарын түвшинд хүлээж авахгүй байх, өдөр тутмын эдийн засгийн бодит дүн шинжилгээнд дадаж зуршаагүй, аж ахуй эрхлэх шинэлэг аргад дасаагүй зэрэг нь сүүдрийн эдийн засгийн тухай шуугих, түүнчлэн өөрсдийн онцлог бүхий үйл байдлын хэм хэмжээтэй мэргэжлийн болон бусад бүлгийн сонирхолыг илэрхийлэх мафи байна гэж нотлохыг оролдох нь гэнэн хэрэг. Иймд нийгэмд ээлжит дайснаа илрүүлж шүүмжлэх нь гол бус, байдаа засах бодит шийдвэр эрэлхийлэх нь чухал байна.

Улс төр дэх ёс суртахуунтай холбоотой бас нэгэн зүйл бол манайд төрийн аппарат хүчирхэг байх нь парадокс байдлаар төр улс нь сул дорой байх шинж болж байна. Судлаачид төрийн аппаратын бүтээмж нь сул дорой байх гол шалтгаанд дараах зүйлийг оруулж байдаг:

- санхүүгийн нээц баялаг ховор хомс байдаг, төр улс ядуу учраас төрийн аппарат бас л ядуу байдаг.
- удирдлагын мэргэжлийн боловсон хүчин дутагдаж байдаг, ийм хүмүүсийг ажилд авахдаа мэргэжлийн чадвар мэдлэгээс илүү хувь хүний ивээлийн харилцаа, дотно харьцааг урьтал болгодог. Монголын нэгэн баримт бичигт үүнийг "эрдэмтэнг аглаг, зусар бялдуучийг ойр" гэж

томъёолсон нь бий. Ялангуяа сүүлийн хэдэн жил намын гишүүнчлэлийг урьтал болгон мэргэжлийн ажилд тохоон томилох гаж буруу үзэгдэл дэлгэрч байна.

□ коррупцийн олон хэлбэр бий болж, тэр нь төрийг мелжих объект болж, улс төрчид, аппаратын ажилтан, бас түүнчлэн улс төрийн шийдвэрийг худалдааны зүйл болгодог.

□ засаг захираганы ухаалаг оновчтой байдал, эрх зүйн удирдлагын хэрэгсэл, эрх мэдлийн тодорхой зааг бүхэлдээ дутагдаж, ер нь удирдлагын энгийн техник ихээхэн дутагддаг.

Дээрхээс дүгнэхэд, Монголын парламентчийн ёс зүйн төлөвшилтэд субъектив, объектив олон янзын хүчин зүйлс нөлөөлж байгаа нь тодорхой. Ёс зүйн ойлголтын аппарат улс төрчдийн дунд ижил түвшинд жигд суугаагүй тул түүнийг өөртөө ашигтай байр сууринаас янз бүрээр тайлбарлах явдал ч ажиглагддаг. Тэр ч үүднээс өнөөдөр зохион байгуулалтын болон эрх зүйн шинжтэй арга хэмжээ авах шаардлагатай байна. Үүнд:

1. УИХ-ын гишүүний ёс зүйн дүрмийг хуульчлан батлах явдлыг түргэтгэх, энд цаг хугацаа алдмааргүй байна. Энэхүү дүрэмд гишүүний өдер тутмын үйл ажиллагаанд мөрдөх үйл байдлын хэм хэмжээнээс гадна хамгийн гол нь түүний орлогын эх үүсвэр, коррупцээс урьдчилан сэргийлэх, сонирхлын зөрчил үүсэхэд түүний арилгах арга замыг тод томруун тусгах. Тэр утгаараа өнөөдрийн УИХ-ын зарим гишүүдийн боловсруулж өргөн барьсан хуулийн тесел шаардлага төдийлен хангаагүй гэж үзэж болно.

2. УИХ-ын гишүүн шинээр болсон этгээд болон түүний туслах, бие төлөөлөгч наарт албан үүрэгтээ орохос өмнө ёс зүйн хичээл орж парламентийн дэг жаягтай танилцуулах журам тогтоох.

3. УИХ-ын бүтцэд байгаа Ёс зүйн дэд хороог байнгын хорооны статустай болгох. Ингэхдээ олонхи цөөнхийн төлөөлөл яг ижил байхаар тогтоож, намын харьяалалыг харгалзахгүй парламентын хугацааны ахлааар хороондаргыг сонгох.

4. Төрийн дээд албан тушаалтны зүгээс ёс зүйн ноцтой алдаа гаргасан тохиолдолд импичмент хийж байх. Импичмент хийх процедурыг нарийвчлан тогтоох. Ёс зүйн хороонд шалган мордох эрх олгох болно.

## **Ёс зүй: уламжлал ба шинэчлэл**

**R. Вандангомбо**

**Дэд доктор, дэд  
профессор**

Хүн төрөлхтний сэтгэлийг өнө эртнээс зовоосон зүйлийн нэг бол ёс суртахууны асуудал юм. Хүмүүсийн хоорондын харилцааг тодорхой байдлаар журамлах асуудал бараг хүнтэй зэрэг үүсчээ. Эл асуудлыг шинжлэх ухааны янз бүрийн салбарынхан сонирхож, тайлбарласаар ирэв.

Эртний Грекийн нэрт гүн ухаанч Аристотель "Этика" хэмээн ухагдахууныг анх шинжлэх ухаанд оруулж ирсэнээр түүнийг ёс зүйн ухааныг үндэслэгчийн нэг хэмээн үздэг. Аристотелийнхаар "ёс зүй гэдэг бол хүнд юуг хийх ёстой, юунаас татгалзах хэрэгтэйг танихад тусалдаг шинжлэх ухаан" ажээ. Аристотель. Этика. Сб. 1 1908 стр 41

Тэгвэл Английн социологич Г. Спенсер зан суртахуунтай хүн гэдэг гадаад орчныхоо нехцэлд дээд зэргээр зохицохыг хэлнэ гэжээ.

Өнөөгийн энэ салбарт ажиллаж байгаа олонхи эрдэмтэд ёс зүйг-хүмүүсийн зан суртахууны үйлдлийн үндэслэл, тэдгээрийн зан суртахууны ухамсарыг судалдаг ухаан гэж үзэх болжээ.

Зан суртахуун нь нийгмийн үзэгдэл болохынхoo хувьд онолын талаасаа харилцаа ба ухамсар гэсэн түвшинд хуваагдана. Зан суртахууны доор бид хүнээс хүнтэйгээ, мөн материаллаг ба оюуны үнэт зүйлстэй, хүрээлэн байгаа орчин, амьд өртөнцтэй харилцах харьцааг ойлгодог. Зан суртахуун нь бие хүнээс өөрийн эрх үүргээ хэрэгжүүлэхдээ нийгмийн өмнө хүлээх хариуцлагаа хэрхэн ухамсарласнаар илэрч байдаг.

Ёс зүйн судалгааны объект нь маш олон янзын хэлбэрээр илэрдэг зан суртахууны үзэгдэл болдог. Нэлээд хугацаагаар ёс зүйн практикийн философи гэж ойлгосоор иржээ. Эдүгээ түүнийг онолын ба норматив ёс зүй гэж ангилж байна. Онолын ёс зүй нь ёс суртахууны үүсэл ба мөн чанарын асуудлууд нийгмийн харилцааны системд түүний эзлэх байр суурийг тодруулах, зан суртахууны ухамсарын хэлбэр, бутцийг тайлбарлах зэрэг асуудлыг судалдаг. Норматив ёс зүй нь хүмүүс ёс суртахууны зарчим ба хэм хэмжээг хэрхэн сахин биелүүлж байгаа тухай асуудалд хариулт өгдөг.

Ер нь энэ асуудлыг авч үзэхдээ ерөнхий ярих бус ёс зүй нь Хоорондоо харилцан няйт уялдаа бүхий, түүнийг нь салган зааглахад нэн бэрхшээлтэй,

тэгсэн мөртлөө нарийвчлан нягтлах шаардлагатай олон хүчин зүйлүүдээс бүрэлддэгийг анхаарах ёстой. Энд тухайлбал: гэр бүл ба ёс суртахуун, шашин ба ёс суртахуун, уламжлал, зан заншил болон ёс суртахууны харилцаа, эрх зүй, ёс суртахууны нийтлэг ба ялгаатай талыг тодруулах зэрэг олон асуудал хамрагдаж байна.

Францын эрдэмтэн, социологич Э. Дюргеймийн судалснаар бол аливаа нийгмийн тогтвортой ба тогтвортгүй байдалд оруулдаг 3 гол хүчин зүйлд: гэр бүл, шашин, ёс суртахууныг оруулсаныг өнөөдөр олон эрдэмтэд хүлээн зөвшөөрсөн хэвээр байна. Би үүний Монгол орны өнөөгийн байдалтай холбон тайлбарлахыг оролдьё.

**1. Гэр бүл.** Өнөөдөр Монголын гэр бүлийн зонхилох олонхи нь сайн сайхан аж төрж, нийгэм, түүхэн үүргээ нэр төртэй биелүүлж байгаа. Гэхдээ гэр бүлийн амьдралд зарим нэг сөрөг үзэгдэл ажиглагдаа байна. Үүнд:

- өмнөх үетэй харьцуулбал гэр бүл болох нь нэлээд оройтох шинжтэй байна.
- гэрлэлт дээр тулгуурлаагүй гэр бүл үүсгэх хандлага олширч буй.
- архидалт, амьдралын ядуу, зүдүү байдал бусад шалтгааны улмаас зарим гэр бүлд хэрүүл, маргаан бий болж улмаар салж сарних явдал нэлээд гарах боллоо. Үүнээс болоод хараа хяналтгүй, хүмүүжилгүй хүүхэд, запуучууд, асран тэтгэх хүнгүй хегшчүүл улам олширсоор байна.
- мөн зарим гэр бүлд гэмт хэрэг хамсан үйлдэх, дарангуйлал хүчирхийлэлд автагдах, аливаа ёс суртахуунгүй үйлдэл явагдах үүр уурхай ч болох тал байна.

Иймээс нийгмийн анхдагч эс болохынх нь хувьд гэр бүлийн ёс суртахууныг цэвэр, тунгалаг байлгахгүй бол болохгүй байна. Үүнээс олон зүйлс улбаалж байна.

**2. Шашин, ёс суртахуун хоёр маш амин холбоотой билээ.** Иймээс ч зарим судлаачид шашин бол хүн төрөлхтентэй хамт бий болсон, мөнхийн зүйл хэмээдэг байхад, нөгөө хэсэг нь ёс зүйтэй харьцуулах юм бол шашин хожуу үүссэн гэж үздэг байна.

Монгол оронд 1990-ээд оноос эхэлсэн ардчилал, шинэчлэлийн буянаар шашин сэргэж, сум дуган дахин амилж иргэд чөлөөтэй сүсэглэх болов. Энэ үед нийслэл дэх ганцхан Гандантэгчилэн хийдэд 100 орчим лам шашны хурал номын ажлыг эрхлэн явуулж байсан бол эдүгээ Монголд 200 байна. Үндсэн хуулинд тэр нь шашнаа хүндэтгэж, шашин

нь төрөө дээдэлнэ гэсэн заалт орсон байхад "Монгол улс төр, сүм хийдийн харилцааны" хуулинд Монгол улс дахь буддын шашны зонхилох байр суурийг хүндэтгэн үзнэ гэжээ.

1994 онд шашин, шүтлэгийн асуудлаар Улаанбаатар хотын 6 дүүрэг, 8 аймгийн 20-иод сумын 1800 хүний дунд явуулсан социологийн судалгаагаар хүмүүсийн 80,4% нь өөрсдийгээ шашинтай ямар ч холбоогүй гэж хариулсан сонин үзүүлэлт байх юм.

Шашин судлаачдын бичсэнээр бол аливаа шашин нийгэмд жам ёсныхоо үүргээ биелүүлэхэд нөлөөлдөг З гол хүчин зүйл байдаг ажээ. Энэ нь:  
a) төр засгаас шашны талаар зөв бодлого явуулж, хэрэгжүүлэх  
b) шашны мяндаг, тушаалтнууд нь 1lam, хуврагч мэдлэг, чадвар сайнтай, сахил, санваараа чанд сахидаг байх  
v) сүсэгтнүүд нь бурхан, шашиndaа чин сэтгэлээсээ сүсэглэдэг байх чухал ажээ.

Энэ байдал өнөөгийн манай бодит амьдрал дээр ямар байна вэ? Тэгвэл бурханы шашны ёс суртахууны гол сургаал болох. Арван хар нүглийг тэвчиж, арван цагаан буяныг үйлдэж буй лам, хуврага ч, сүсэгтэн ч төдийлэн элбэг биш байна. Үнэн чанартай бол "10 хар нүгэл" гэгч хориглосон зүйл монголын ардын ёс суртахуунаас эх авсан бөгөөд түүнийг хэрвээ биелүүлж чаддагсан бол өнөөгийн манай хүмүүсийн сэтгэлийг зовоогоод байгаа гэмт хэрэг, замбараагүй байдал, ёс бус үйлдлүүд устах учиртай юм.

Цэцэрлэг, сургууль хичээл номоо эхлэхээс аваад жагсаал, цуглаан болоход лам хувраг ирэн ариусгаж, албан байгууллагууд бурхан шүтээнтэй болж, овоо тахилга, шашны уншлагад төр, засгийн нэр оролцох болж, хэвлэл, радио, телевизээр зурхайн хэмнэл гэгчийг байнга сурталчлах болсныг монголын нэн шинэхэн туйлшрал гэлтэй. Ер нь Монгол улс өнөөдөр дундад зуундаа эргэж хургаад шашнаа мандуулах гээд байна уу? Аль эсвэл 21 зуун өөд шинжлэх ухааны хурдаар давшаад байна уу? гэдэг асуудал аяндаа урган гарч байна. Ямар боловч улс орны эдийн засаг хүнд, хүн ардынхаа ядуу зүдүү байдлыг тооцож боломжтой тооны сүм дугантай, боловсрол мэдлэг, дэгжаяг сайтай лам хуврагтай байж, соёл түүхийн дурсгалт зүйлээ сэргээж, шашнаа гүнзгий судлан түүнд авах, гээхийн ухаанаар хандах нь зүйд нийцэх болов уу.

3. Ёс суртахуун. Миний ойлгож байгаагаар бол өнөөдөр манай нийгэмд З янзын ёс суртахуун зэрэгцэн оршиж байна.

a) Уламжлалт ёс суртахуун. Монголын уламжлалт ёс суртахууныг бусадтай жишигээд

өвөрмөц бөгөөд давуу талтай зүйлс их бий. Үүнд:

- эрдэм ном, багшаа илүү эрхэмлэдэг
- хүндлэх, зочилох
- шудрага ёс, зе эвийг хичээх
- дээдэд зусардахгүй, доордод бардамнахгүй байх
- ахас эхсээ хүндлэх асрах
- олон янзын хориг, цээрүүд
- хүүхдийг нялх балчираас нь хөдөлмөрт сургадаг гэх мэт

Эдгээр сайхан уламжлалууд өдгөө хөдөө нутгийн хүн ардад нэлээд хадгалагдаж, харин хот, суурин газруудад нэлээд бүдгэрч байна.

b) Социалист ёс суртахуун. 70 жил ийм үзэл, хүмүүжлээр явж ирсэн болохоор энэ ёс суртахууны нэлээд шинжүүд хүмүүсийн оюун санаа, амьдрал ахуйд мөрдөгдсөөр байна. Үүний гол зарчим нь "нэг нь нийтийнхээ төлөө, нийт нь нэгийнхээ төлөө" болохоор хамтын хүмүүжил олгох, нийгмийн эмзэг хэсгээ хамгаалалтанд авч, өөд нь татдаг зерэг талтай байв. Мөн хувь хүний гаргасан ёс суртахууны гажуудлыг хамт олон, нам, эвлэл, пионерийн байгууллагын хурлаар шүүн хэлэлцэж дутагдлыг нь засахыг оролдож, зөвлөгөө, сануулга огдог байсан нь тийм ч муу зүйл байсангүй. Харин "хоногийн нэгдсэн бригад", "аж ахуйн нэгдсэн тооцоотой хамт олон" гэх мэт олноор бий болж, олсон орлого, ашгийг нь адил тэнцүүхэн хувааж өгч байсан нь хувь хүний бүтээлч үйл ажиллагааг боогдуулж, хэт тэгшитгэж, улмаар бусдаар тэжээлгэх сэтгэл зүйд сургасан сөрөг зүйл байлаа.

3. Өрнөдийн ёс суртахууны зарим шинж нэвтрэн орж байна. Энэ нь зонхилж индивидуализм дээр сууриндаг бөгөөд монголоор бол "хүн бүхэн хувиа борлуулж, довоо шарлуул" гэсэнтэй утга ойролцоо юм. Үүнийг би нэг их муучлахыг хүсэхгүй байна. Үнэхэр л хүн болгон өөрийгөө, гэр бүлээ аятайхан авч явж чадаад байх юм бол тэр тэнэмэл хүүхэд, хучирхийлэгсэд, гэмт хэрэгтнүүд хаанаас гараад ирэх билээ дээ.

Иймээс ч эдүгээ овсгоотой, амьдралынхаа төлөө тэмцэж чадсан нь дээшилж, олиггүй арчаагүй нэг нь уруудаж, нийгэмд баян, дунд, хоосны ялгарал бий болдог жамтай юм байна. Энд харин нийгмийн зүгээс энэрэл, халамж үзүүлэх бодлого хэрэгтэй бололтой.

Манайд өнөөдөр хүмүүс ёс суртахууныхаа сонголтыг зөвхөн хийх, олон янзын боломжоос сайныг нь шингээн авч, саар зүйлтэй нь аль болохоор хутгалдахгүй байх явдал чухал болжээ. Энэ талаар төр, засгийн зүгээс бодлогоор зохицуулах зүйлс ч нэлээд байна.

Одоо удирдах ажилтны ёс зүйтэй холбоотой зарим

нэг санаа хэлье. Удирдлагын ёс зүй нь удирдах хүн ёс суртахууны үндсэн ойлголтууд, хамтаж харилцааг төлөвшиүүлэх зүй тогтол, зан суртахууны үнэт зүйлс, ажлын арга барилын талаар мэдлэгтэй болж, түүнийгээ практик ажилдаа хэрэглэхэд тусалдаг. Эл утгаар нь авч үзвэл Удирдлагын ёс зүйн шинжлэх ухаан эдүгээ төлевших шатандаа байгаа аж.

Ёс зүйн мэдлэг нь удирдах хүмүүст хувийн нэр хүндээ дээшлүүлэхэд нь зайлшгүй хэрэгтэй. Мөн хамт олны дунд зан суртахууны бүтээлч уур амьсгалыг бүрэлдүүлэх, залуу үеийг дэвшилт хүмүүжилтэй болох, аливаа сөргөлдөөнтэй байдлыг арилгахад тусалдаг.

Удирдах хүн бол олон янзын санамсаргүй эсэргүүцэлтэй тулгардаг. Энэ нь түүний удирдлаганд байгаа хүмүүсийн ашиг сонирхолтэр болгон удирдлагатайгаа нийлдэггүй, бас ч заримдаа эсрэг байдагтай холбоотой. Харин аливаа санал зөрлөдөөний гол шүүгч нь үндэслэгээс байдаг. Италийн улс төрч, сэтгэгч Никколо Макиавелли хэлэхдээ: Удирдана гэдэг бол итгэлийг олж авна гэсэн уг гэжээ.

Удирдах ёс зүйг практик талаас нь яривал манай хувьд анхаарууштай асуудал нэлээд байгаа юм.

Саяхан болсон "Ардчилсан төр, удирдлагын ёс зүй" сэдэвт семинар дээр АНУ-ын Конгрессийн гишүүн хэлэхдээ: "Танай засгийн газар ард түмэндээ их эрх чөлөө олгожээ. Хэрвээ олон түмэн түүний зөв ухамсарлаж сураагүй бол дэндүү эрх чөлөө бас аюултай".

Үүнийг удирдлагаасаа эхлэх ёстой. Удирдлагын гол шинж бол үнэнч шудрагаа байдал. Энэ бол ард түмэн итгэлээ өгнө гэсэн уг... Зөв юм бол тухайн үедээ танигдаагүй боловч хэзээ ч зөвөөрөө байдаг. Буруу зүйл нь тухайн цагтаа баригдаагүй ч цаашдаа буруу нь нотлогддог юм" гэсэн манай нийгмийн амьдралын эрээн барааныг нэлээд сайн олоод харчихсан, дүгнэлт хийж ажиллахаар чухал санаа юм.

Ер манайд удирдах, удирдуулахын ёс зүйд суралцах хамгаас чухал болж, суралцах зүйл ч нэлээд байна. Энэ дараах шалтгаантай байна.

1. Сонгуулийг жинхэнэ утгаар нь явуулж байсан туршлага манайд хомсюм. Тер, засгийн гол албан тушаалд тавигдах хүмүүсийг сонгуулиар шийдэж, мөн янз бүрийн албан тушаалд өрсөлдүүлэн томилдог болсон өнөө үед ёс зүйн хэм хэмжээг сахих явдал үнэхээр чухал байна.

2. Сонгуульд оролцохдоо өрсөлдөгчиддээ хүндэтгэлтэй хандаж, өөрийн давуу байдлаа харуулахын оронд хэт намчирхаж, талцаж ямар ч

үнээр хамаагүй ялахыг эрмэлзэх явдал ч ажиглагдах болов.

Негee талаас, сонгогч олон түмэн ч гэсэн нэгэнт итгэл хүлээлгэсэн юм бол төр, засгийнхаа түшээ нарыг хүндэтгэхгүй, хардаж сэrdэж, элдэв янзын цуу яриа гаргах, нэр төрийг гутаадаг нь төрт ёсны ёс зүйд харшилж байна.

Эрх зүйн болон ёс зүйн ойлголтыг хооронд нь хольж хутгах тал байна. Чухам ямар зүйлийн үйлдлийг хийхээр ёс зүйн хэм хэмжээг зөрчлөө гэдгийг зөв тогтоох шаардлагатай байна.

Жишээ нь, манайхны ёс зүй зөрчлөө гээд бичиж яриад байгаа УИХ-ын зарим гишүүд хуралдаанаа тасаллаа, зарим нь бизнес, аж ахуй эрхлэхтэй хутгалдлаа гээд байгаа маань зөв үү? Миний бодлоор бол энэ нь хөдөлмөрийн болон төрийн албаны хуулийг зөрчсөн учир юм шиг санагдах юм.

3. "Төрийн ажилтны ёс зүй" хууль гарахаар олон жил дуншиж байна. Энэ бодит бэрхшээлтэй байхаа. Логикийн хувьд бичмэл биш хуулийг бичмэл хуулиар зохицуулна гэдэг хүнд л дээ. Хүний дотоод сэтгэлийн асуудлыг хэт хуульчлах гэж оролдвол хожих зүйл бага байдаг гэсэн уг ч бий.

Үнэхээр сайн хууль гарвал маш хэрэгтэй байна. Үүнийг яаравчилмаар байна.

4. Өнеөдөр олон түмний санаа сэтгэл, ёс суртахуунд багагүй нөлөө үзүүлэгч нэг хучин зүйл бол хэт олширсон сонин сэтгүүл, "шар сонин" гэгч болоод байна. Энд би бүгдийг нь хамааруулах гээгүй, үүргээ зохих ёсоор биелүүлж байгаа хэвлэл зөндөө бий.

Зарим сонин хүнд өгөх мэдлэг, мэдээгээр нэн ядуу, хутган үймүүлж, хов тараасан, тер засгийн албан хаагчдын нэр төрийг зориудаар гутаахаар оролдсон бүүр бүтэхгүй болохоор нь тэдний ах дүү хамаатан садан, авгай хүүхдээр нь оролдох болжээ. Ийм материал хэнд хэрэгтэй юм бэ? Эзэндээ хадан зоос унагадаг бололтой юмаа. Ийм сонингууд нь олон түмний оюуны хоосрол, ёс суртахуунгүй адал балмад үйлдэлдuriлан дуудаж, эцэст нь хов, жив сонсох хоббитой болгож байна.

Тер засгийн удирдах хүмүүсийн өгсөн ярилцлаганд ч шар сонинд миний талаар янз бүрийн зүйл бичдэг л юм. Би түүнийг нь тоодоггүй юм гэж нөгөөдүүлээ өөгшүүлэх боллоо. Үүнийг боох хэрэгтэй ба хүний нэр төрийг гутаагчдад таарсан нянгийг нь хүртээмээр байна. Эс тэгвээс газар авах шинжтэй.

Ийм болохоор хэвлэлийн хууль, ус агаар мэт

хэрэгтэй байна.

5. Радио, телевизийн сурвалжлагч, сэтгүүлчид ч заримдаа албан тушаалаараа дулдуйдан, энэ хүнтэй зэвсгийг олны санаа сэтгэлийг үймүүлэхэд хэрэглэх тал бий. Жишээ нь "малын хулгайтай тэмцэх асуудлаар" ярихаар цаг авсан мөртлөө тэнд төр засгаа муулах зарим сайдыг гүтгэх, ГОК-ийн асуудлыг шургуулах ямар хэрэг байна вэ?

6. Эцэст нь тэмдэглэхэд улс орны эдийн засаг, үйлдвэр уналтанд ороход засаж сайжруулах харьцангуй гайгүй байдаг юм гэнэлээ. Харин нийгмийн оюун санааны амьдрал, ялангуяа ёс суртахуун доройтолд орвول сэхээн авахдаа их хугацаа шаарддаг хэмээн эрдэмтэд, мэргэд өнөө эртнээс сургасаар иржээ.

Нэгэнт эдүгээ манай ёс суртахууны амьдрал ийм эрээн мяраан байгаа болохоор энд хүн хүч, хөрөнгө зардал гаргаж, шинжлэх ухааны үндэстэй, дорвitoй судалгаа хийж, чиг зүгээ зөв тогтоож, бодлого боловсруулж хэрэгжүүлмээр байна.

Завсар чөлөөгөөр нь цаг алдалгүйгээр энэ талын хичээл ном заах, сурталчилгаа, ухуулгын ажил хэрэгтэй үгүйсгэх аргагүй. Харин ч суулийн үед хоёр ч удаа семинар, хурал зохион байгуулж байгаад талархлаа илэрхийлье.

Анхаарсаны баярпалаа

**Түвэгтэй журмыг магтах нь.**  
**ХБНГУ-ын Бундестагт шийдвэр гаргах үйл явц ба парламентын ажлын зохион байгуулалт**

**Ехөн Ноот**

**"Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг"**

**ХХК-ий Гүйцэтгэх захирал**

1. Германы Бундестагт шийдвэр гаргах процесс нь нэлээд түвэгтэй бөгөөд заримдаа их цаг хугацаа шаарддаг. Хэдэн жилийн турш хэлэлцэгдсэн асуудлын үр дүн нь хангалттай биш буюу бүр ямар ч үр дүнд хүрэхгүй байх тохиолдол ч гардаг. Үүний нэг жишээ нь татварын тогтолцооны шинэчлэлийн тухай хэлэлцүүлэг юм. Энэ асуудал нь үндэсний чухал ач холбогдолтой гэдгийг бүх нам тэмдэглэж байсан боловч түүний хэлэлцүүлэг үр дүнгүй болов. Иймэрхүү явдалд олон нийт шүүмжлэлтэй ханддаг. Тэд улстөрчдөөс тодорхой, шуурхай, шийдвэр гаргахыг хүсэн хүлээж байдаг юм. Тийм ч учраас ардчиллын нехцөлд ч гэсэн хурдан шаламгай, шийдэмгий, улс төрчийн нэр хүнд олон нийтийн дунд өндөр байдаг билээ.

Парламентат ардчиллын эсрэг байдаг хэт зүүний болон хэт барууны үзэлтнүүд ардчиллын тогтолцоог түвэгт удсан, шийдвэрийг удаашруулдаг, буулт хийхийг эрхэмлэсэн гэж шүүмжилж, энэ үзэгдлийг ялзрал, коррупцтэй адилтгадаг юм. Тэд өөрсдийнхөө зорилгыг хурдан, шийдэмгий, ямар нэг эргэлзээгүйгээр хэрэгжүүлэхийг бардагнан амладаг билээ. Харин тэдний зорилго нь юунд оршиж байна вэ гэсэн асуулт сонирхол татна.

2. Төрийн үйл ажиллагааны болон улс төрийн шийдвэрийг эрж олох явдлын үндэс суурь нь болдог. ХБНГУ-ын Үндсэн хууль нь төрийн улс төрийн зорилгыг тодорхойлоходоо их болгоомжтой хандсан байдаг. Үүгээрээ уг Үндсэн хууль нь тодорхой үндэстэн ястны давуу эрхийг эрхэмлэсэн барууны үзэлтнүүдийн буюу тодорхой нэгэн нийгмийн ангийн диктатурыг тогтоож ангигүй нийгэмд шилжин орох тухай зүүний үзэлтнүүдийн үндсэн баримт бичгүүдээс ялгаатай юм.

Үндсэн хууль нь баримтлах ёстой зарчим, журмыг тодорхойлсон бөгөөд тэдгээрийн зарим нь үл өөрчлөгдхөн шинж чанартай юм. Үүнд: хүний үндсэн эрх, нэн ялангуяа "хүний амьд явах ба чөлөөтэй хөгжин байх эрх, ард түмний бүрэн эрх, засаглалын зарчим, засгийн газрын хариуцлага, засаг захиргаа, хуульд нийцсэн байх, шүүхийн хараат бус байдал, олон намын

тогтолцоо, улс төрийн бүх нам адил тэгш эрхтэй байх, түүний дотор үндсэн хуульд нийцсэн серег хүчнийг бүрдүүлж ажиллуулах эрх" хамаарна. 1953 онд Үндсэн хуулийн шүүх, Тэгэхдээ уул зарчмуудын агуулга нь юу юм бэ, нийгмийн буюу улс төрийн чухам ямар зорилго тэдгээрт агуулагдаж байгаа талаар Үндсэн хуульд тэр бүр дурдаагүй орхисон юм.

Нийт улсын хэмжээнд амжиргааны адил төстэй нехцөл боломж бий болгоно гэх мэтчилэн нааштай зорилтыг дэвшүүлэн тавихдаа уул зорилтыг төрийн төвлөрсөн төлөвлөгөөний үндсэн дээр хэрэгжүүлэх үү аль эсхүл хувийн аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны үндсэн дээр хэрэгжүүлэх үү гэдгийг тодорхой заагаагүй юм. Энэхүү зорилтыг ийнхүү ерөнхийлен тодорхойлсон нь негеэ талаас түүний аргачлалын шинж чанартай удирдамж болгож байгаа бөгөөд түүнийг хэрэгжүүлэх талаар цэц булаацалдах шаардлага гарна.

Уг шаардлагыг үндэс болгосон энэхүү аргачлал нь ХБНГУ-ын сүүлийн 50 жилийн улс төрийн тогтвортой хөгжлийн үндэс суурь нь болж ирэв. Ингэснээр нийгмийн зөвшилцөлд аюул учруулж болохуйц нийгмийн эрс тэс ялгавартай байдал, хэт туйлшрал бий болохоос сэргийлж чадсан юм.

Одоогоор оршин тогтнож буй улс төрийн тогтолцоог эсэргүүцэж буй этгээдүүдийн үйл ажиллагааг тэдний тавьж буй нийгмийн зорилтын улмаас хориглодоггүй, харин тэд энэ зорилтоо хэрэгжүүлэхийн тулд ардчиллын ёс журмыг устгах зорилго тавьдаг учир хориглодог юм. Тийм ч учраас Үндсэн хуулийн түүх Германы коммунист намын үйл ажиллагааг 1956 онд хориглоходоо хориглох үндэслэл нь энэхүү намаас тавьж буй үйлдвэрлэлийн хэрэгслэлийг нийгэмчлэх шаардлага биш, харин төрийн байгууламжийн эсрэг хандсан түүний үйл ажиллагаа юм гэж тусгайлан заасан юм.

3. Парламентын үйл ажиллагаатай холбогдуулан Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжинд тусгасан зарчим ба журам, тэднээс улбаатай чиг баримжа:

□ Парламентын Бундестагт гишүүдийг дөрвөн жилийн хугацаагаар сонгох бөгөөд тэднийг сонгогчид эгүүлэн татах боломжгүй

□ Парламентын гишүүд нь "Бүх ард түмний элч төлөөлөгчид мөн. Тэд аливаа захиас, даалгавар, удирдамжаас ангид бөгөөд зөвхөн

өөрийн итгэл үнэмшилд захирагдана" 19Х-ийн 38-р зүйл.

□ Парламентын гишүүдийн нэг хэсэг нь шууд, негеөх хэсэг нь муж улсын намын жагсаалтаар сонгогдоно. Өөрөөр хэлбэл, тэд ямар ч тохиолдолд бас орон нутгийн эрх ашигийн илэрхийлэгчид мөн юм.

□ Улс төрийн намууд нь нийгмийн болон парламентын хүрээнд үзэл бодол төлөвших процесст гол үүрэг гүйцэтгэнэ. Парламент нь намын бүлгүүдийн зохион байгуулалттай байх ба тэдгээрийн гишүүд нь бүлгийн сахилга батыг чанд мөрдөнө

□ Намууд зарим тохиолдолд зарчмын хувьд ялгаатай улс төр, үзэл бодлын байр суурьтай байдаг. Тэгэвч парламентын олонхийг бурдуулэх үүднээс нам хоорондын холбоо, удаан хугацааны эвсэл байгуулах шаардлага гардаг.

□ Улс орны хэмжээнд аль болох олон санал авах зорилгоор, мөн түүнчлэн сонгуулийн хуулийн шаардлагыг биелүүлэх үүднээс 15 хувийн санал авах. Бундестагт төлөөлөлтэй намууд нийгмийн янз бүрийн давхаргын өөр өөр үзэл бодолтой хүмүүсээс бүрддэг: ажилчид, бизнес эрхлэгчид, янз бүрийн шашны сүсэгтнүүд, шашинд итгэдэггүй хүмүүс, тариачид, сэхээтэн г.м. Бусад намаас ялгагдах, үүгээрээ аль болох олон санал авахын тулд өөрийн гэсэн улс төрийн хетелбертэй байж, түүнийгээ хэрэгжүүлэх, олонтаа тохиолдолд тухайн намын гишүүд болон сонгогчдын хоорондоо зөрчилдөөнтэй ашиг сонирхлыг нам уялдуудан зохицуулах чадвартай байх ёстой.

□ Засгийн газар нь парламентын ёмне хариуцлага хүлээнэ. Канцлерийн хүчтэй байр суурь болон эрх мэдлийн монополийн үр дүнд засгийн газар нь парламентаас гаргах шийдвэрт хүчтэй, нелөөлөх боломжтой.

□ Холбооны Үндсэн хуулийн шүүх нь парламентаас гаргасан шийдвэр, хэрэгжүүлж буй арга хэмжээнд хяналт тавьж, шаардлагатай гэж үзвэл тэдгээрийг хүчингүй болгох эрхтэй

Өнгөцхөн харагд парламентын үйл ажиллагаатай ямар ч холбогдолгүй мэт сэтгэгдэл төрүүлж болохуйц Үндсэн хуулийн дараахи чухал заалтууд байдаг. Үүнд:

□ аж ахуйн ашиг сонирхлоо хэрэгжүүлэх зорилгоор эвсэл, холбоо, нийгэмлэг байгуулах эрх чөлөө 18вэлзлдэн нэгдэх эрх чөлөө;

□ үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх болон хэвлэлийн эрх чөлөө

Нэг талаас олон нийтийн нийгмийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл ба олон нийтийн үзэл бодлыг чөлөөтэй илэрхийлэх явдал, негеөт талаас өөрийнхөө үзэл бодлыг эвсэл холбоогоор дамжуулан илэрхийлэх нь парламентын байр суурийг бурдуулэхэд шийдвэрлэх нөлөө бүхий хүчин зүйлүүд юм.

4. Дээрхи заалтууд нь дотроо зөрчилдөөнтэй гэдэг нь тодорхой байна. Эдгээрээс хамгийн анхаарал татахуйц хэдийг нь авч үзье. Үүнд:

- Парламентын гишүүд бүх ард түмний элч төлөөлөгч боловч тэднийг сонгосон хүмүүс нь орон нутгийн, нийгмийн болон үзэл бодлын өөр өөр ашиг сонирхлыг илэрхийлнэ

- Парламентын гишүүд аливаа үүрэг даалгавраас хараат бус байна гэдэг боловч тэд парламентыг бүрдүүлдэг намын бүлгүүдийн сахилгад захирагдана

- Тэд засгийн газрыг хянах ёстой. Гэвч тэд хэрвээ парламент дахь олонхид хамаардаг бол засгийн газрыг хянахаасаа үнэн хэрэг дээрээ түүнийг серөг хүчинээс хамгаалах үүрэг гүйцэтгэдэг.

Дашрамд хэлэхэд засгийн газар нь асар том ажлын аппарат, материаллаг ба мэдээллийн хүчтэй баазтай байдаг учир түүний нелее хэтэрхий их. Тийм ч учраас засгийн газар хуулийн теслүүдийн 90 хувийг санаачилж ихэнхи тохиолдолд теслүүдээ амжилттай хамгаалж чаддаг.

Өөр өөр намаас нэр дэвшсэн депутатууд сонгуулийн сурталчилгааны үеэр хоорондоо ширүүн өрсөлдж, парламентын хэлэлцүүлгийн үеэр их маргадаг боловч хууль боловсруулхтай холбоотой парламентын едер тутмын ажлыг явуулахдаа намын бүлгийн харьяаллыг үл харгалzan ажлын эрх ашиг, орон нутгийн буюу цэвэр pragmatik ашиг сонирхлын үүднээс ихэнхи тохиолдолд хамтран ажилладаг юм. Ер нь Германы Бундестагийн түүхийг сөхөж үзэхэд ихэнхи хуулиуд серөг хүчиний дэмжлэгтэйгээр батлагдсан юм.

5. Энэхүү олон янзын бөгөөд дотроо зөрчилдөөнтэй харилцаа холбоог харгалзан Германы Бундестаг нь шийдвэрийг боловсруулан гаргах, ажлаа зохион байгуулахын тулд олон комисс ба ажлын хэсэг байгуулан ажиллуулдаг. Бундестагийн 5-аас доошгүй судалтай нам намын бүлэг байгуулж ажиллуулна. 13үүн Германы Ардчилсан социализмын нам намын бүлэг байгуулах нехцлийг хангаагүй учир парламентын хэсэг байгуулсан юм. Намын бүлгүүд нь зарим тохиолдолд хэд хэдэн шат дамжлагатай удирдлагыг сонгож, олон тооны ажлын хэсэг, орон нутгийн нэгжүүдийг томилон ажиллуулна. Өдөр тутмынхаа ажлыг явуулахдаа намын бүлгүүд парламентын 22 байнгын комисс, зарим дэд комисс, тусгай комисс, хянан шалгах комисс, мөрдөн шалгах комисс ажиллах шаардлага гарна. Парламентын таван хүний бүрэлдэхүүнтэй тэргүүлэгчид болон намын бүх бүлгүүдийн төлөөлөгчдөөс бүрдсэн ахмадын зөвлөл удирдана. Бундестагийн Тамгын газар

нь эрдэм шинжилгээний албыг оруулан нийтдээ 2200 гаруй ажилтантай. Намын бүлгүүд нийтдээ 700 гаруй ажилтантайгаас гадна депутатын шадар туслахын үүрэг гүйцэтгэдэг хэдэн мянган хүн ажилладаг юм. "Бундестагийн бүтэц" гэсэн хавсралт зургийг үзнэ үү.

6. Засгийн газар, парламентын хоорондын нарийн түвэгтэй харилцаа холбоог Герман улсын федераль бүтэц болон Холбооны зөвлөл 'Бундесрат' хэмээх парламентын нэгж нь бүр илүү түвэгтэй болгоно. Холбооны зөвлөл нь бүрэн хэмжээгээр, зарим тохиолдолд Бундестагтай адил эрхтэйгээр хууль тогтоох үйл ажиллагаанд оролцено. Холбооны зөвлөлд холбооны бүх муж улсын засгийн газрууд төлөөлөлтэй байдаг. Мен энд ч Бундестагт суудалтай намууд шийдвэрлэх үүрэг роль гүйцэтгэнэ. Харин одоогийн байдлаар Холбооны Зөвлөл дэхь намуудын төлөөлөл Бундестагаас өөр байгаа. Бундестаг дахь цөөнх нь Бундесратад олонхи байгаа юм. "Холбооны түвшингийн хууль тогтоох процесс" бүдүүвчийг үз.

7. "Бундестагийн тэргүүлэгчид" гэсэн хэсэгт тусгаснаар Бундестагт хууль батлах үйл явц нь дараахи дэс дарааллтай байдаг юм.

□ Хуулийн тэслүүдийг яамдын мэргэжлийн нэгж, салбарууд холбогдох байгууллагуудыг оролцуулан бэлтгэх нь засаг захирагааны аппаратын болон сонирхлын болон холбогдох хүрээнүүдийн аль алиных нь мэдлэг, туршлагыг ашиглахад ач тустай юм.

□ Салбарын яамд болон засгийн газрын танхимын хооронд хуулийн тэслийн талаар зөвшилцэх нь тухайн арга хэмжээг засгийн газрын ерөнхий чиг шугамд болон улсын тэсвийн санхүүгийн нөхцөл байдалд нийлуулэх боломж олгоно

□ Хуулийн тэслийг Бундесратад танилцуулах нь хуулийн тэслийг муж улсуудын хууль тогтоомжтой уялдуулан зохицуулж, үүнд тэдгээрийн эрх ашгийг бодолцон тусгах боломж олгоно

□ Бундестаг дахь хуулийн тэслийн анхны хэлэлцүүлэг нь Бундестагийн гишүүд болон олон нийтэд тухайн асуудлаар хууль батлан гаргах үйл явц эхлээд байгаагийн дохио болдог юм

□ Бундестагийн байнгын комиссууд хуулийн теселтэй нарийвчлан танилцах нь хуулийн теселд мэргэжлийн болон улстериийн бусад ашгийг нэмж тусгах, хуулийн тэслийн талаар намын бүлгүүдтэй зохицох, зарим талаар тохиролцоонд хүрэх, харилцаан буулт хийхэд тус дэхем болно

□ Хуулийн тэслийг байнгын комиссоор авч хэлэлцэх нь тухайн асуудлыг мэргэжил, шинжлэх ухааны талаас гүнзгийрүүлэн судлах, олон нийтийн анхаарлыг тухайн асуудалд хандуулах, сонирхсон иргэд, байгууллагын оролцоог идэвхжүүлэхэд тус дэхем болно

□ Хуулийн тэслийг Бундестагийн нэгдсэн хуралдаанаар 2 дахь удаагаа хэлэлцүүлэх нь теслийн талаархи ил тод маргааныг өрнүүлж, улс терийн хүчинүүд тухайн асуудлаар баримталж байгаа байр сууриа илэрхийлэх, хэлэлцүүлгийг сонин хэвлэл, радио телевизээр мэдээлснээр иргэдэд тухайн асуудлаар тодорхой ойлголттой болох боломж олгоно

□ Хуулийг Бундестагаар баталсны дараа дахин Бундесратад оруулах нь ХБНГУ-ын Холбооны зохион байгуулалтын онцлог бөгөөд нийт улсын хэмжээнд ба орон нутагт хэрэгжүүлэхэд муж улсууд өндөр үүрэг рольй байдгийг нотлож байгаа юм

□ Бундестагийн зөвшилцлийн байнгын комисс нь холбооны тогтолцооны улмаас төв ба муж улсуудын хорронд гарч болзошгүй зөрчилдөөнийг харилцаан буулт хийх замаар шийдвэрлэж, нийт улсын ашиг сонирхолд үндэслэсэн нэгдмэл шийдвэрт хүрэхэд тус дэхем болох үүрэгтэй юм

□ Эцэст нь заавал шарадлагатай биш боловч байж болох нэгэн үйлдэл бол батлагдсан хуулийг Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг шалгуулахаар Үндсэн хуулийн шүүхэд танилцуулах явдал юм. Хууль батлах бүх үйл явц нь төрийн эрх зүйн үүднээс Үндсэн хуулийн хэм хэмжээний дагуу шалгагдах бөгөөд энэ шалгурт нийцээгүй хууль нь хүчин төгөлдөр болж чадахгүй

8. Хууль тогтоох үйл ажиллагаа нь хэрэг дээрээ дээр дурдсанаас илүү нарийн түвэгтэй байдаг юм. Засгийн газар ба парламентын хооронд, Бундестаг дотроо, Бундестаг ба Бундесратын хооронд зөвшилцех явдал нь ямар нэг тодорхой орон зайнд биш харин олон нийтийн хараан доор болон маш олон эвсэл холбоодын идэвхтэй оролцоотойгоор болдог юм. Германд нийтдээ 4 мянган орчим эвсэл холбоод байдаг ба эдгээрийн хамгийн их нөлөө бүхий нь хууль тогтоох үйл ажиллагааны бүх үе шатанд оролцдог юм. "Эвсэл холбоод ба тэдгээрийн үр нөлөө" бүдүүвчийг үз Эвсэл холбоод нь:

□ Шийдвэрийг эрэлхийх үйл явцын анхны үе шатанд тэднийг салбарын яам, байнгын комиссуудтай зөвлөлдөх ажилд татан оролцуулдаг ба тэд мөн холбогдох мэдээлэл, дүгнэлтийг гаргаж өгнө

□ Сонсгал мэдээ хийхэд ба хянан шалгах комиссуудын ажилд оролцсоноор тэд парламентын үйл ажиллагаанд оролцох боломжтой

□ Эвсэл холбоодын төлөөлөгчид улс төрчидтэй ойр дотны харилцаатай байдаг бөгөөд улс төрчдөд ч тэдний мэргэжлийн мэдлэг туршлага хэрэгцээтэй байдаг юм

□ Ихэнх депутатууд өөрсдөө ямар нэгэн эвсэл, холбооны гишүүн байдаг

□ Бүх эвсэл холбоод олон нийтийн дунд сурталчилгааны идэвхтэй үйл ажиллагаа

явуулдаг ба үүгээрээ уламжлан парламентад нөлөөлөх оролдлого хийдэг

□ Тухайлбал намуудад хандив өргөх явдал хяналтанд байдаг хэдий ч тэдэнтэй ийм арга замаар харилцаа холбоо тогтоох нь хуульд үл харшлана.

Парламентын байгууллагууд дотроо болон хоорондоо, түүнчлэн засгийн газрын байгууллагуудтай-олонтаа зөвлөлдөхөөс гадна депутатууд албаны бөгөөд албан бус хэлхээ холбоо тогтоох уулзалт, бага хурал, зоог, хүлээн авалт зэрэг арга хэмжээ маш олон удаа оролцох шаардлага гардаг ба эвсэл холбоод, тодорхой ашиг сонирхол бүхий бүлэглэлүүд, тэдэнд нөлөөлөх оролдлогыг байнга хийдэг.

9. Эвсэл холбоод өөрсдийнхөө янз бүрийн хүсэл эрмэлзлийг хэрэгжүүлэхийн тулд олон түмний үзэл бодлыг ашиглан парламентын гишүүдэд нөлөөлөхийг оролддог ба энэ оролдлого олон нийтийн ба хувийн хэвлэл мэдээллийн байгууллагуудаар дамжуулан хийнз. Энэ нь ч хүн амд нөлөөлдөг ба уг нөлөөг баталгаажуулахын тулд санал асуулга явуулдаг.

Хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр хүмүүсийн анхаарлыг хамгийн их татсан цөөн хэдэн асуудлыг мэдээлэх боломжтой. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь хүн амын ашиг сонирхол, үзэл бодол, ёс суртахууны илэрхийлэгчийн хувьд парламентын үйл ажиллагааг дүгнэж цэгнэхэд хийгээд энэ утгаараа тодорхой депутат дахин сонгогдох эсэх асуудлыг шийдвэрээд чухал байдгийн зэрэгцээ тэд бас парламент доторхи шийдвэр гаргах процесст оролцдогийн хувьд үүрэг гүйцэтгэнэ.

10. Учрыг нь олоход бэрх, цаг хугацаа шаардсан эн үйл явцын хүрээнд ер нь оновчтой шийдвэр гаргах боломж бий ю? Парламентын гишүүн нь хоорондоо зерчилтэй үй олон шаардлага, ашиг сонирхлын нөлөөнд байдаг "аливаа захиас, даалгавраас ангид зөвхөн өөрийн итгэл үнэмшилд захирагдах бүх ард түмний элч төлөөлөгч"-ийн хувьд өөрийнхөө үүрэг даалгаврыг биелүүлэх боломжтой эсэх асуудал аяндаа гарна.

Хамгийн ярвигтай нь "итгэл үнэмшил"-ийн асуудал юм. Уг ухагдахуун нь христос шашнаас уламжлагдаж ирсэн юм. Үүний дагуу энэ нь хувь хүн өөрийнхөө үйлдэл, үзэл бодлыг бурханы сургаалд хэрхэн нийцэж буйг шалгаж үздэг нэг ёсны шалгур юм. Христос шашны номлороор бол зөвхөн бурханы сургаалыг буюу бурханаас тогтоосон хууль цаазыг бүх хүмүүс адил дагаж мөрдэх ёстой хэмээн үздэг. Америк болон Франц улсад гарсан хувьсгалын үр дүнд феодализмын үеийн уламжлалт үнэлээмжүүд өөрчлөгддэж, улмаар алга болсон билээ. Эдгээр хувьсгал, үзэл

санааны дагуу хүн бүр шашин шүтлэг, ёс суртахууны итгэл үнэмшилээ чөлөөтэй сонгох эрхтэйгээс гадна аж амьдралаа өөрийнхөө эдийн засаг, нийгмийн ашиг сонирхлын дагуу төвхнүүлэх эрхтэй бөгөөд гагцхүү энэ эрх нь бусдын эрх ашигийг хохирох ёсгүй.

Манай Үндсэн хуулийн цем нь болдог "Хүний эрхийн тухай Тунхаглал" гарснаар бүх хүний дагаж мөрдэх байсан ёс зүйн нэгдмэл хуулиас улс төрийн ба нийгмийн тавцан дээр өрсөлдэж байдаг, зарчмын хувьд адил тэгш эрхтэй хэм хэмжээний ба ёс суртахууны маш олон системүүд бий болсон юм. Ингэснээр итгэл үнэмшил хэмээх ухагдахуун нь хувь хүн өөрийнхөө зөв гэж сонгож авсан замнал, түүнээс үүдэн гарах ёс суртахууны зарчим, хууль ёсны ашиг сонирхлыг зөв хэрэгжүүлж байгаа эсэхийн шалгуур болж хувирсан юм.

"Бүх ард түмний элч төлөөлөгч" гэсэн нэр томъёолол нь тухайн депутатын төлөөлж буй хэсэгчилсан ашиг сонирхол нь тухайлбал түүнийг сонгосон хүмүүс, үйлдвэрчний звлэл буюу бизнесийн холбоо зэргийн ашиг сонирхол олон янзын эрх ашиг, үзэл санаа хоорондоо өрсөлдхөн боломжийг бий болгож байгаа тогтолцог бүхэлд нь бэхжүүлэхэд хувь нэмэр болох ёстой гэсэн үг юм.

11. Энэхүү олон янзын ашиг сонирхлын төлөөллийн, өөреөр хэлбэл олон ургальч үзэлд үндэслэсэн ардчиллын тогтолцоо нь хоёр үндсэн зарчмыг шаардана. Үүнд:

□ Ашиг сонирхол, үзэл бодол бүр адил тэгш эрхтэй бөгөөд адил боломжоор хангагдсан байх ёстой

□ Шийдвэр гаргахын тулд урт удаан цаг хугацаа шаарддаг, нарийн түвэгтэй ба бэрхшээлтэй замыг тулж зөвшилцед хүргэдэг процесс нь эцсийн эцэст сонирхогч бүх талуудын ашиг сонирхлыг наад зах нь цаг хугацааны хувьд хангадаг байх ёстой.

Гэвч Герман улс болон ардчилал хөгжсөн бусад улс орны улс төр, нийгмийн бодит нөхцөл байдлыг өнгөцхөн харахад дараах зүйл ажиглагдана:

□ Янз бүрийн ашиг сонирхлыг илэрхийлсэн нийгмийн бүх давхаргууд зарчмын хувьд адил тэгш эрхтэй хэдий боловч үнэн хэрэг дээрээ тэдэнд адил тэгш боломж байдаггүй. Эдгээр боломж нь монго хөрөнгө, тухайн бүлэглэлүүдийн бүрдүүлж буй хүмүүсийн тоо, хэрэглэж буй арга замаас шалтгаалж адил бус байдлаар хуваарилагдаг байна

□ Нийгмийн ашиг сонирхлыг тэнцвэржүүлэх нарийн түвэгтэй тогтолцоо болон нийгэмд тулгарч буй асуудлыг парламентын ёс жаягаар шийдвэрлэж байгаагийн үр дүнд хүмүүсийн гачигдал зовлон, тэдний санааг зовоож буй

асуудлыг бүрэн шийдвэрлэж чадахуйц нийгмийн нэхцэл байдлыг бий болгож чадахгүй байна.

Хүн төрөлхтөн өнгөрч буй зуунд үл биелэгдэх утопист тогтолцоог байгуулахыг оролдож байсан туршлагатай жишиж үзэхэд парламентат ардчилал нь нийгмийн идеал нэхцэл байдлыг бий болгохыг амладаггүй бөгөөд үүнд нь би сэтгэл хангалуун байдаг юм. Дээр хэлсэнчлэн ХБНГУ-ын Үндсэн хууль нь нийгмийн хөгжлийн зорилгуудыг тодорхойлооос татгалзсан билээ. Харин эл хууль нь нэг ёсондоо улс төрийн үйл ажиллагааг явуулах ёс журмыг тогтоож, энэхүү журмыг хэрэгжүүлэхдээ баримтлах зарчмуудыг тодорхойлсон юм. Эдгээр зарчмаас хамгийн эрхэмлэж үзүүштэй нь хүн бүр өөрийн аж амьдрал, ашиг сонирхлыг хуулийн хүрээнд зохицуулах боломж олгож буй хүний эрхийн зарчмууд юм.

12. Үүнд үндэслэн шийдвэрийг эрэлхийлж олох энэхүү нарийн түвэгтэй тогтолцоо нь үнэлж баршгүй дараах хоёр давуу талтай юм. Үүнд:

- Энэхүү тогтолцоо нь хувь хүний мөн нийгмийн бүлэглэлүүдийг ч хамгаалж, улс төрийн хүчирхийллээс айхгүйгээр оршин тогтоох боломж егч байна
- Энэхүү тогтолцоо нь pragmatik шинж чанар агуулж буй учир буруу буюу цаг үеэсээ хоцорсон шийдэл бүрийг засч залруулах боломж олгодог. Ингээнээр утопист идеал нэхцэл байдлыг бий болгож чадахгүй боловч хүмүүсийн амьдралд түвэг учруулдаг олон жижиг асуудлыг нэг дор үгүй юмаа гэхэд алхам алхамаар шийдвэрлэж, дараачийн асуудлыг мөн энэ хялбар бус, цаг хугацаа шаардсан арга замаар шийдвэрлэх боломж олгодог юм.

## **Монголын парламентын хуралдааны дэг ба нээлттэй байдлын асуудал, цаашид боловсронгуй болгох нь**

**Ч. Сайханбилэг**

**Улсын Их Хурлын  
гишүүн**

Монгол улс нийгэм, улс төрийн шинэ тогтолцоонд шилжин орсноос хойш Монголын парламент 9 дэх жилийнхээ, шинэ Үндсэн хууль үйлчилж хэрэгжиж эхэлсэнээс хойш 7 дахь жилийнхээ нүүрийг үзэж байна.

Хөгжил, төлөвшлийн хэдэн арав байтугай хэдэн зууны түүхтэй парламентуудтай харьцуулахад энэ нь хэтэрхий бага хугацаа ч бид парламентын үйл ажиллагааны үндсэн зарчмуудын нэг болсон нээлттэй байх зарчмыг энэ хугацаанд хэр төлөвшүүлж чадав, цаашид явавал эйтэй вэ гэдэг талаар та бүхэнтэй санаалаа хуваалцъя гэж бодлоо.

Монголын парламент хэр нээлттэй парламент вэ? Сонгодог утгаар нь аваад үзвэл, нээлттэй байлгахын тулд авч явуулж буй үйл ажиллагааны хэлбэрүүд, түүнийгээ хуульчилж, журамласан байдал зэргийг аваад үзэх юм бол давгүй нээлттэй парламентын дүр зураг ажиглагдана.

Чуулганы үйл ажиллагаатай танилцъя гэсэн хэнбугай ч зөвшеөрөлтэйгөөр шууд танхимд сууж болох бөгөөд хурлын тэмдэглэл протоколыг эхнээс нь эцэс хүртэл уншиж танилцах бололцоотой.

Төвийн хэвлэлүүд, телевиз радиогоор чуулганы хуралдааны үйл явцаас мэдээлэл авчихна. Хэн нэгэн гишүүний нэр дээр нэвтрэх үнэмлэх бичүүлчихвэл 76 гишүүний хэнийх нь ч өрөө рүү яваад орчиж болно.

Хэн гэдэг гишүүн ямар асуудлаар яаж санал өгснийг мэдэх бололцоо хуулийн дагуу нээлттэй. Оөрөөр хэлбэл нээлттэй байх зарчим, түүний илэрч байгаа хэлбэрийнх нь хувьд авч үзвэл үнэхээр хэрэгжиж чадаж байгаа гэж үзэх үндэслэлтэй.

Гэвч нэгдүгээрт: хуульчилж хэдийгээр тусгасан боловч хүмүүст төдийлөн хүрэхгүй байгаа, хоёрдугаарт: хэрэгтэй, шаардлагатай гэдэг нь ойлгогдоод байгаа ч хөрөнгө санхүү, мөнгөгүйгээс шалтгаалж хийгдэх бололцоогүй байгаа, гуравдугаарт: ажлын зохион байгуулалт, хууль журмыг сайжруулах шаардлагатай байгаа зэрэг олон шалтгаанаас үүдэж парламентын дэг, нээлттэй байдлын асуудлыг улам боловсронгуй болгох, дээрх асуудлын мөн чанарыг илэрхийлэх

шалгууруудаа улам нарийвчилж үзэх шаардлага гарч байна.

Хэдийгээр сонирхсон нэг нь зохих зөвшөөрөл авч чуулганы хуралдааныг ажиглаж болох боловч түүнд нэгэнт үйлчилж буй журмын дагуу 15 минутаас илүү бололцоо олдохгүй бөгөөд энэ хугацаа нь парламентад хэлэлцэж байгаа тухайн асуудлын эхлэл тэгсгэлийг ажиглах нь байтугай уг асуудлын мөн чанар, хэлэлцүүлгийн утга учрыг ч сайтар ойлгох боломж өгөхгүй хугацаа юм.

Телевиз мэтийн технологи ажиллагаа их шаардлагатай мэдээллийн хэрэгслийнхэн богино хугацаанд эвлүүлэг, монтаж хийх жижиг студи, зориулалтын өрөө өнөөдөр Төрийн ордонд байхгүй байна.

Телевиз радиогоор парламент дахь хэлэлцүүлгийн талаар дамжуулдаг ч энэ нь 7 хоногт 2-3 удаа, нэг удаад 20 минут орчим л дамжуулж байгаагас бүрэн дүүрэн мэдээлэл авах боломж сонгогчдод хомс байдаг.

Парламентын танхим маань угийн зориулалтын бус учраас парламентын үйл ажиллагаатай шууд танилцах хүсэлтэй хүмүүст зориулсан судлын багтаамж нь нэг удаад хориод хүнээс дээш хэтэрдэггүй бөгөөд дээрх хоёр хүчин зүйлээс шалтгаалж парламент жинхэнэ утгаараа нээлттэй байх зарчмыг хэлбэр төдий л хэрэгжүүлж байгаа гэж үзэх үндэстэй юм.

Парламентыг сурвалжлах эрх авсан 15 хэвлэл мэдээллийн байгууллагын 40 орчим сурвалжлагч байдаг гэх боловч парламентад 3-4 сонин, болон 1-2 телевизийн сувгийн сурвалжлагч тогтмол ажиллаж, бусад сонин хэвлэл дам маягаар шууд бус эх сурвалжаас парламентын үйл ажиллагааг олон нийтэд хүргэж байгаа бөгөөд энэ нь яваандаа мэдээллийн үнэн зөв бодитой, шуурхай байх зарчмыг ч алдагдуулахад хүргэж болзошгүй.

Шинээр гарч буй хууль, тогтоол бусад шийдвэрийг "Төрийн мэдээ" сэтгүүлд нийтэлдэг боловч бараг захиалагч байхгүй сонин сэтгүүлийн тоонд уг сэтгүүл байнга бүртгэгдэж байна.

Одоогоор төрийн тэв хэвлэлийн статустай Ардын эрх сонинд хууль, тогтоолыг бүрэн эхээр нь нийтэлж байгаа ч удахгүй хэлэлцэгдэх хэвлэл мэдээллийн хэрэгслийн болон эрх чөлөөний тухай хуулиар төрийн албан ёсны мэдээллийг

хэрхэн хүргэх, уг хэвлэлийн статусыг хэрхэн шийдвэрлэх зэрэг асуудлууд одоо хүртэл тодорхойгүй байна.

Чуулган, хуралдааны тэмдэглэл проколтой аймаг, хотын зөвхөн номын санд танилцаж болох бөгөөд, санал хураалтыг илээр, нэрээр хурааж байгаа боловч хэн нэг гишүүн аль нэг асуудлаар хэрхэн санал өгснийг тэр бүр шууд мэдэхэд техник ажиллагааны хувьд хүндэртэй, хүссэн хүн бүрт ч тэр бүр гаргаж өгөөд байх бололцоогүй байна.

Чуулганы үйл ажиллагааг байнга дамжуулж байгаа төлөвийн сүлжээ нь зөвхөн ордны дотор ажилладаг бөгөөд иргэд сонгогчид зөвхөн Сонгогчдын боловсрол төв дээр лирж энэ сүлжээг үзэх бололцоотой байгаа юм.

Энэ бүхнээс дүгнэлт хийж үзвэл парламентын дэгээс шалтгаалан түүний нээлттэй байдлыг хангах гол шалгуурууд зарчмын хувьд бий болсон боловч жинхэнэ утгаараа нээлттэй байдлыг бий болгож хараахан чадаагүй хэлбэрийн тедий байна гэдгийг хэлмээр байна.

Би ололт, ахицтай талуудыг харалгүй голлон шүүмжлэхийг зориогүй бөгөөд нээлттэй байдлыг агуулга, хэлбэрийн хувьд бүрэн хангахын тулд үүнтэй холбогдолтой асуудлуудыг зохион байгуулалтын хувьд оновчтой зөв шийдвэрлэх, шаардлагатай хөрөнгө санхүүгийн бэрхшээлийг давах, нээлттэй байх асуудлын ач холбогдолыг иргэд сонгогчдод сайтар ухуулах гэх мэтчилэн олон асуудлыг шийдвэрлэх шаардлага гарч ирнэ.

Илтгэлийнхээ хоёр дахь хэсгийг дээрх асуудлыг хэрхэн шийдвэрлэвэл зохистой байх талаар өөрийн санал бодлоо та бүхэнтэй хуваалцах гэсэн юм.

Өнөөдөр Төрийн ордонд Ерөнхийлөгч, түүний Тамгын газар, Улсын Их Хурал, түүний Тамгын газар, Засгийн газар, түүний Хэрэг эрхлэх газар бүгд нэг дор ажиллаж байна. Үндсэн хуулийн дагуу олгогдсон эрх үүргийнхээ дагуу, төрийн тэргүүний билэг тэмдгийнхээ хувьд Ерөнхийлөгч нь харьцангуй амар жимэр, харуул хамгаалалт чанга орчинд ажиллах, Засгийн газар нь гүйцэтгэх засаглалынхаа хувьд ажил хэрэгч шуурхай байх үүднээс яам, салбарууд руугаа ойртож ажил хэрэгч орчинд байх, сонгогчид иргэдтэй ойр байх, тэдний санал бодлыг байнга сонсож байх үүднээс УИХ жинхэнэ "бум бужигнаж, түм бужигнах" бололцоотой орчинд ажиллаж байх шаардлагатай юм.

Бид УИХ-ын хуулинд УИХ-ыг Төрийн ордонд байрлахыг хуульчилж өгсөн. Энэ утгаараа Ерөнхийлөгч өөрийн өргөө харшид, Засгийн газрыг Төрийн өмчийн аль нэг байранд байрлуулж,

Төрийн ордныг жинхэнэ парламентын утгаар нь өөрчилж зохион байгуулж болох юм. Үүнтэй холбогдон Төрийн ордны зохих түвшинд нээлттэй байх асуудал өөрөөр хэлбэл парламентын харуул хамгаалалтын мен чанар ч өөрчлөгдхө боловцоо гарах юм.

Нэгээ талаар өрөөний хүрэлцээнээс шалтгаалан ганц давчуу өрөөнд туслахуудтайгаа чихцэлдэн суугаа гишүүд сонгогчид, иргэдийг өөрийнх нь хүсэлтээр чөлөөтэй авч уулзах бололцоо бүрдэнэ.

Парламентын нэгдсэн хуралдааны танхимиг одоогийн зориулалтын бус танхимаас гаргаж хуучин Ардын Их Хурлын хуралдааны том танхимиг парламентын танхим болгон засч янзлах шаардлагатай байгаа юм. Энэ чиглэлийн саналыг улсын төсвийн тухай хууль хэлэлцэж байх үед зарим гишүүд гаргаж байсан бөгөөд төсөв мөнгөний хүрэлцээгүйгээс шалтгаалан уг асуудлыг хойшлуулаад байна. Том танхимд парламент шилжсэнээр танхимиын дээд суудлын хэсгийг засч өөрчлен чуулганы хуралдааныг сонирхох хүмүүсийн тоог эрс ихэсгэх бололцоо бий болох юм.

Ингэснээр суудлын цөөхөн тоо, сонирхох цөөхөн минуттай холбогдон гардаг асуудал, хүндэрлийг шийдвэрлэх боломжтой болно.

Дараагийн нэг чухал асуудал бол хуульд заасан саналаа илээр, нэрээр хураах зарчмыг нээлттэй болгох явдал мөн.

Чуулганы хуралдааны танхимд зөвшөөрсөн, татгалзсан гишүүдийн нээсийг санал хураалт болгоноор гаргаж байх хоёр том самбар, төхөөрөмж сууринуулах шаардлагатай байгаа юм.

Өнөөдрийн парламентад хэрэглэгдэж байгаа санал хураах төхөөрөмж үнэхээр хуучирч хоцрогдсон бөгөөд зөвхөн түүний техникийн ажиллагааны saatlaas шалтгаалж, УИХ-аар санал хураагдаж шийдвэрлэгдсэн асуудал Үндсэн хуулийн шүүх-цэцээр орон хэлэлцэгдэж байсан эвгүй тохиолдол өнгөрсөн жил гарсан юм.

Санал хураах төхөөрөмжийг солиход төсвөөс энэ онд 200 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсөн бөгөөд энэ мөнгийг дээрх нээлттэй байдлыг хангахуйц салбар, саналын төхөөрөмжинд зарцуулах талаар УИХ-ын удирдлага, Тамгын газар ажиллах нь зүйтэй юм.

Үүнээс гадна чуулганы ажиллагааг сурвалжлах, олон нийтэд хүргэх талаар хийж буй ажлыг нааштай шийдвэрлэх техникийн шинэ боломж срдее сар гаруйхны өмнөөс бий болоод байна.

Монгол төлөвиз, сансрын "Азиасат" системээс

"Интелсат" системд энэ оны 5 сарын 1-ээс эхлэн шилжин орсон нь телевизийн 24 цагийн тасралтгүй нэвтрүүлгийг бэлтгэж цацах бололцоог нээж байна. Ингэснээр өдрийн цагаар чуулганы хуралдааныг шууд нэвтрүүлдэг АНУ-ын "C Span" телевизийн суваг шиг парламентын өөрийн төрөлжсөн суваг нэвтрүүлгийн цагтай болох, эсвэл дор хаяж "Парламентын тойм"-ын гарах хугацааг нилээн нэмэх бололцоо олдох юм.

Мөн "Парламентын мэдээлэл" сэтгүүлийг чанаржуулж, өргөн олон нийтийн хүртээл болгох эсвэл хамгийн олон захиалгчтай Ардын эрх мэтийн гол зарим сонинтой төр гэрээний маягаар ажиллаж албан ёсны мэдээ хууль, тогтоомжийг хүргэх ажлыг зохион байгуулж болох юм.

Ажлын 5 өдөрт шилжсэнтэй уялдуулан 7 хоногийн хуралдааны график нягтарсан, хавар, намрын чуулганы хуралдааны хугацаа ажлын 75 өдрөөс шалтгаалан уртассан зэрэг шалтгаанаас тойрог, сонгогчидтойгоо ажиллах, уулзах хугацаа, боломж хууль тогтоогчдын хувьд багасч байна. Иймд Даваа гаригийн нам, эвслийн бүлгийн хуралдааны дараа үдээс хойш, эсвэл Бямба гаригт хагас өдөр сонгогч, иргэдтэйгээ уулзах албан ёсны өдөр болгон дэгэнд тусгах энэ тохиолдолд ажилласан Бямба гаригаа чуулганы ажилласан ажлын өдөрт ч тооцож болохыг үгүйсгэж болохгүй юм.

Парламентын дэгтэй шууд холбоогүй боловч парламентыг улам нээлттэй болгодог гол хүчин зүйлүүдийн нэг парламентаар дагнан "мэргэжсэн" төрийн бус байгууллагууд, тэдгээрийн үйл ажиллагааг энд дурдалгүй өнгөрч болохгүй. Нийгмийн Дэвшил Эмэгтэйчүүд хөдөлгөөн, Сонгогчдын боловсрол төв. Улс төрийн боловсролын академийн идэвхтэй үйл ажиллагаа сонгогчид, иргэдийг парламенттай улам ойртуулах чухал үүрэг гүйцэтгэж байна.

Парламент хэдийчинээ их нээлттэй байна төдийчинээ хяналттай болно гэсэн үг. Хяналт хүчтэй байснаар парламент дах улс төрийн хүчинүүд гишүүдийн хариуцлага, сахилга өндөржих нь дамжиггүй.

Эцэст нь тэмдэглэж хэлэхэд парламентын нээлттэй байдлыг хангахад хөрөнгө санхүүгийн эх үүсвэр чухал нелөөтэй. Шилжилтийн үед түүний хүндрэл бэрхшээлийг гол шалтгаанаа болгож цалин тэтгэврээ олигтой нэмээгүй байж сандал ширээ, санал хураах төхөөрөмжинд мөнгө зарлаа гэсэн популист шинжтэй шүүмжлэл санал төсөв хэлэлцэх үед их гардаг. Парламентыг аль болох нээлттэй байлгаснаар харин сонгогчдын сонирхоод, хүсээд байгаа шийдвэр яагаад гарахгүй байгаа, яаж хүндрэл бэрхшээлийг давж гарч байгаа, уг шийдвэрийг гаргахын тулд яаж нелөөлөх вэ мэтийн олон асуудлуудад иргэд сонгогчид илүү мэдээлэл, илүү хариултыг авах ач холбогдолтой юм.

Парламент нээлттэй байснаар аль ч улс төрийн хүчин, нам эвсэл хожно. Энэ бол улс төржиж, үзэл сурталжаад байх асуудал биш бөгөөд Монголын төр, парламент оршин байхаас л хойш хууль тогтоогчид ч тэр, иргэд сонгогчид ч тэр парламентыг улам нээлттэй байлгахын тулд хөрөнгө мөнгөе ч зарах хэрэгтэй, хүч чадлаа ч үүнд зарцуулах ёстой гэж үзэж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

## Парламентын гишүүнд хүлээлгэх ёс зүйн ба хууль зүйн хариуцлага

Ж. Бямбадорж

### Улсын Их Хурлын гишүүн

Монгол улсад байнгын ажиллагаатай парламент бий болсоор удаагүй ч гишүүдээс ямар нэг байдлаар хэл аманд өртөх явдал багагүй байна.

Улсын Бага Хурлын гишүүн Дамдинг хууль зөрчсон учраас огцруулж, УИХ-ын анхдугаар бүрэлдэхүүний үед гишүүн Ц. Төрмандах, С. Зориг нарыг Үндсэн хууль зөрчсен гэж Үндсэн хуулийн цэц дүгнэлт гаргаж байсныг та бүхэн мэднэ. Эдгээрээс өөр УИХ-ын гишүүдээс хэн нь ч ёс зүйн болон хууль зүйн хариуцлага хүлээсэнгүй.

УИХ-ын өнеегийн гишүүдээс УИХ-ын болон байнгын хорооны хуралдаанаас хожимдох, таслах, үнгэснээс болж эдгээр хуралдаанууд олон удаа тасалдаж байгаа төсвийн хууль зөрчих, аж ахуйгаа өөр хүнд эрхлүүлсэн ч бизнес ил далд эрхлэх, териин албаны хууль зөрчиж бусад байгууллага, аж ахуйн нэгжийн зардлаар гадаадад зорчих зэрэг хууль зөрчsen үйлдэл байнга гаргасаар байна. Энэхүү хуулийн зөрчлийг ёс зүйн зөрчил хэмээн нэрлэж ямар ч хариуцлага тооцохгүй байгаагас дутагдал архагшиж хавтгайрах хандлагатай боллоо.

Тэгвэл Франц улсад парламентын гишүүдэд ямар шаардлага тавьдаг, уг шаардлагыг хангах механизм ямар байгааг товч авч үзье.

БНФУ-ын Үндэсний Ассамблейн депутатад ёс зүйн алдаа болон эрх зүйн зөрчил гаргасан тохиолдолд зохих хариуцлага хүлээлгэдэг байна. Энэхүү хариуцлага нь шийтгэлийг тодорхой хэлбэртэй байдаг бөгөөд Үндэсний Ассамблейн Регламентад заасан байдаг.

#### 1. Сахилгын буюу ёс зүйн хариуцлага

Хурлын дэг зөрчсен депутатад дараах сахилгын шийтгэлийг хүлээлгэдэг байна. Үүнд:

1. Журам сахихыг шаардах
2. Журам сахихыг протоколд тэмдэглэж шаардах
3. Буруушаах
4. Хуралдааны танхимаас түр хугацаагаар гаргах зэрэг болно.

Даргалагчийн зөвшөөрөлгүй үг хэлэх зэргээр хуралдааны дэг зөрчсен депутатад зөвхөн хуралдаан даргалагч журам сахихыг шаардах

шийтгэлийг оногдуулдаг байна.

Журам сахихыг протоколд тэмдэглэж шаардах шийтгэлийн өмнө нь журам сахихыг шаардах шийтгэл нэг удаа хүлээсэн, түүнчлэн бусад депутатыг хараасан, дайрч доромжилсон бол хүлээлгэдэг байна. Энэхүү шийтгэлийг уг депутатад олгодог парламентын нэмэгдлийн деревний нэгийг сарын хугацаагаар хасахтай хамтатгаж хэрэглэдэг байна.

Буруушаах шийтгэлийг журам сахихыг протоколд тэмдэглэж шаардах шийтгэл оногдуулсны дараа хуралдаан даргалагчийн шаардлагыг биелүүлэгүй, эсвэл хуралдаан дээр шуугиан тарьсан тохиолдолд оногдуулдаг ажээ. Ийм шийтгэл хүлээсэн депутат нэмэгдлийнхээ тал хувийг сарын хугацаагаар алддаг.

Хуралдааны танхимаас түр хугацаагаар гаргах шийтгэлийг буруушаах шийтгэлийг эсэргүүцсэн эсвэл буруушаах шийтгэлээр 2 удаа шийтгүүлсэн, нийтийн хуралдаан дээр хүч хэрэглэсэн үтасны аппарат, аяга шидэх гэх мэтээр, Ассамблей болон түүний даргыг дайрч доромжилсон, Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Засгийн газрын болон Үндсэн хуульд заасан хурлуудыг хараасан, дайрч доромжилсон депутатад хүлээлгэдэг байна.

Хуралдааны танхимаас түр гаргах шийтгэл нь Ассамблейн бүхий л ажилд оролцохыг нь 15 хоногоор хориглох арга хэмжээтэй хамт явагддаг байна. Ассамблейн даргын шийтгэл оногдуулсан захирамжинд тухайн депутат захирагдахгүй бол хуралдааныг завсарлуулна. Энэ тохиолдол болон хуралдаанаас түр хугацаагаар гаргах шийтгэлийг хоёрдахь удаагаа хүлээвэл Ассамблейн бүхий л ажиллагаанд оролцохыг нь хориглосон хугацааг 30 хүртэл хоногоор сунгадаг байна.

Хуралдааны танхимаас түр хугацаагаар гаргах шийтгэлийг Ассамблейн даргын саналын дагуу хэлэлцүүлэггүйгээр босох, суух маягаар санал хурааж Ассамблейн шийдвэрээр оногдуулах.

#### 2. Хууль зүйн хариуцлага

Үндэсний Ассамблейн депутат Ассамблейн ордонд хуралдааны үеэр ямар нэгэн эрх зүйн зөрчил гаргавал даргалагч энэ тухай хуралдаанд мэдээлж хуралдааныг завсарлуулна. Харин хуралдааны бус цагт дээрхи зөрчил гаргасан бол дараагийн хуралдаанд иэн даруй мэдээлнэ.

Депутатын гаргасан эрх зүйн зөрчлийг депутатын үйл ажиллагаатай холбоотой депутатын үйл ажиллагаатай холбогдоогүй гэж 2 ангиlj үздэг.

Депутатын үйл ажиллагаатай холбоотой зөрчил сонгуулийн кампаний үед зарцуулсан хөрөнгийн тооцооны тайлангаа хугацаанд гаргаж өгөөгүй, орлогын мэдүүлгээ буруу гаргасан буюу хугацаанд нь гаргаагүй, хуулиар зөвшөөрснөөр бусад ажил, албан тушаал эрхэлсэн, хуралдааны явцад эмх замбаараагүй байдал гаргасан зэрэг ордог байна. Дээрхи зөрчил гаргасан нь нотлогдсон тохиолдолд депутат сайн дураараа огцрох буюу түүнийг Үндсэн хуулийн зөвлөл эгүүлэн татдаг байна.

Хэрэв депутат гэмт хэрэг зөрчил үйлдэж, шүүхийн журмаар мөрдөгдөж байгаа бол Үндэсний Ассамблей хэлэлцэж депутатын бүрэн эрхийг нь хасдаг байна. Энэ нь депутатын үйл ажиллагаатай холбоогүй зөрчилд тооцогддог.

Хариуцлагын эдгэр төрөл нь парламентын гишүүдэд хүлээсэн үүргээ үнэнч шударгаар биелүүлэх, өндөр ёс зүйтэй байх, хуралдааны дэгийг чанд сахих, бусдад хүндэтгэлтэй хандах зэрэгт эсрэгээр нөлөөлдэг байна. Монгол Улсын Их Хурлын дэгийн болон гишүүний эрх зүйн байдлын хуульд өөрчлөлт оруулж Франц улсын энэхүү туршлагыг хэрэглэж болох бүрэн үндэстэй гэж үзэж байна. УИХ-ын дэгийн тухай хуульд дэг зөрчсөн, бусдыг доромжилсон бол хуралдаан даргалагч урьдчилан сануулах, урьдчилан сануулга авсан гишүүн дахин зөрчил гаргавал түүний тухайн өдрийн хуралдаанд уг хэлэх эрхийг нь хасах хариуцлага хүлээлгэхээр заасан бөгөөд энэ нь өнөөдөр хүртэл хэрэгжээгүй байна. Хэрэгжээгүй байгаагийн гол шалтгаан нь шийтгэлийн энэхүү төрлийн үр нөлөө огт байхгүйтэй холбоотой болов уу.

УИХ-ын гишүүдийн хариуцлагыг сахилга сул, тэдэнд хариуцлага хүлээлгэж болохгүй байгаагийн гол шалтгааныг УИХ-ын сонгуулийн системтэй холбож үзэх бүрэн үндэстэй байна.

Дэлхийн жишгээр мажоритар гэж нэрлэгддэг системээр УИХ-ын сонгуулийг явуулж байна. Ялангуяа хамгийн энгийн, хамгийн их дутагдал доголдол агуулж байдаг нэг мандаттай тойргийг сонгож авснаас болж улс төрийн хүчний бодлого бүрэн дүүрэн явагдаж чадахгүй, хэдийгээр УИХ-ын гишүүд аль нэгэн нам, эвслэд харьялгадаг ч түүнийхээ өмнө хариуцлага хүлээдэггүй, нам нь ч гишүүнийхээ алдаа эндэгдлийн төлөө хариуцлага хүлээлгэх механизмыг байдлыг бий болгожээ.

Үүнээс шалтгаалж гишүүн бүрийн хэт бие даасан байдал УИХ-д ноёрхож, төрийн ажилд ихээхэн хохирол учирч байна. Намаас нэр нь дэвшиж сонгогдсон атлаа тухайн намаасаа гардаг, улс төрийн бодлогын асуудлаар нам, эвслийн бүлгийн шийдвэрийг дагадаггүй бараг хэл ч байдаггүй хачин байдал монголд бий боллоо.

Үүнийг намаасаа гарч намаа төлөөлөх боломжгүй болсон атлаа тухайн намын суудал дээр сууж байгаа, олонхи болсон атлаа засгийн газраа бүрдүүлж чадахгүй байгаа, сахилга хариуцлагаа алдаж, хууль зөрчсөн гишүүндээ нөлөөлж чадахгүй, татаж чадахгүй байгаа зэрэг олон жишээгээр баталж болно.

Ноёд хатагтай нараа,

Энэхүү хурлаас зөвлөмж гаргавал миний саналыг тусгаж УИХ-д хүргүүлэхийг хүсч байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

## **Монгол болон Германы Парламентын хуралдааны дэг, нээлттэй байдлын талаархи зарим харьцуулалт**

**Б. Энэбиш**

**УИХ-ын Тамгын газрын  
Ерөнхий нарийн бичгийн  
даргын нэгдүгээр  
орлогч**

ХБНГУ-ын Парламентын хуралдааны дэг, нээлттэй байдлыг тухайлан судалж, УИХ-ын үйл ажиллагаатай харьцуулан зарим дүгнэлтэд хүрснээ. Та нөхдөд толилуулж байна.

Өнө эртний уламжлалтай Германы парламентын үйл ажиллагааг Монгол улсын парламенттай харьцуулахад цаашид сайжруулах, боловсронгуй болгох олон зүйл байгааг зориуд цохон тэмдэглээ.

**Нэг. Хуралдааны дэг, зохион байгуулалтын зарим асуудал**

Манай парламентын хуралдааныг 1996 онд батлагдсан УИХ-ын хуралдааны дэгийн тухай хуулиар зохицуулж, зохион байгуулж байгаа билээ. Энэ хуульд хоёр удаа өөрчлөлт оруулж хуралдааны дэгийг нэлээд боловсронгуй болгосон. Цаашид ч УИХ-ын хуралдааны дэгийн хуулинд өөр олон зүйлүүд нэмэгдэх ёстой гэж үздэг. Энэ асуудалд Германы туршлага чухал ач холбогдолтой байх болно.

Бундестагийн хуралдааны Дэгийн холбогдолтой үйл ажиллагаанаас ажигласан зүйлийн хувьд бол чуулган бүрийн эхэнд Бундестагт байгаа намын фракц бүлгүүд хуралдааны дэгийг тохиролцдог. Хуучин дэгээр явах уу, хуучин дэгэндээ шинэ дэг оруулж өөрчилж засварлах уу, нөхцөл байдал ямар болсон бэ гэж, хэрэв хуучнаар явна гэвэл хуучин дэгээр явъя гэж тохиролцоод явдаг. Энэ бол ганцхан Герман биш бусад орнуудад ч гэсэн байдаг зүйл. Энэ бол нэлээд шинэлэг зүйл юмуу гэж санагдсан.

Германы Бундестагт намуудын бүлгүүд маш хүчтэй ажилладаг нь сонгуулийн хуультай холбоотой байдаг. Мөн өөрийн орны онцлогтой ч холбостой байдаг. Намын бүлгүүдийг санхүүгийн механизмаар дэмждэг. Үйл ажиллагаа явуулах бололцоог нь хангаж өгч байгаа байдал, мөн хуралдааны дэг нь намын бүлгүүдэд илүү их түшиглэсэн байдаг байна.

Түрүүнд дурдсанаар бол УИХ дахь намын, нам эвслийн бүлгүүдийн үйл ажиллагааг илүү хүчтэй болгох талаас нь бид нар янз бүрийн механизмыг бodoх нь зүйтэй гэж бодогдож байна. Үүнд сонгуулийн хуулийн асуудал үнэхэр гол үндэс болсон асуудал юм.

Мөн намын бүлгийн санхүүгийн асуудал, ажилтнуудыг шилж сонгож ажиллуулах асуудал, ялангуяа Дэгийн хуулинд дэгээр намын бүлгийг төлөөлөх энэ үүрэг ролийг дээшлүүлэх асуудал их чухал байна.

Энэ нь ямар зүйлээр илэрдэг вэ гэвэл хамгийн наад захын жишээ хэлэхэд чуулганы нэгдсэн хуралдаан дээр аливаа хэлэлцэж байгаа асуудлаар санал дүгнэлтээ хэлэхдээ намуудад том жижиг, суудлын харьцаагаар минутыг хуваарилаад өгчихсөн байдаг. Хугацааг нь томоохон нам бол 40 минут, бага зэрэг намууд 20 минут ч байдаг юм уу, арай бага байвал 15 минут гэх мэт.

Тэгэхээр өөрийн бүлэгтээ хуваарилагдсан энэ хугацаандаа тухайн намын бүлгийн ахлагч бүтэн үг хэлчихсэн ч болдог. Үгүй бол 3 хуваагаад, намын бүлгийн ахлагч 5 минут хэлээд дараа нь тухайн асуудлыг хариуцсан харьцангуй мэргэшсэн тухайн бүлгийн гишүүн нь илүү мэргэжлийн үндэслэл гаргаад ч юм уу, ингээд яриад байдаг практик байдаг. Энэ бол манайд нэлээд хэрэглүүштэй зүйл юм гэж бодогдож байна.

Саналагч байгаа байдлыг бид нэлээд анхаарах хэрэгтэй байна. Германд харьцангуйгаар намын бүлэгтээ түшиглэж саналаа өгдөг. Хэрвээ бүлгийн саналтай нийцэхгүй хүн байх юм бол тэрнийгээ урьдчиллаад намын бүлэгтээ мэдэгдээд тэгээд чуулган дээр ч юм уу, байнгын хорооны хурал дээр намын бүлгээсээ би санал зөвөтэй, энэ талаар үг хэлнэ гэж урьдчилан хэлж мэдэгдэж байж үг хэлдэг юм. Энэ бол намын сахилга баттай ч холбоотой, мөн ажил хэргийг цэгцтэй явуулах үүднээс тустай зүйл байдаг. Манайд үүнийг хэрэглээд эхлэх юм бол УИХ-ын гишүүний үг хэлэх эрх харьцангуй боогдоо гэсэн шүүмжлэл гарч магадгүй. Гэхдээ бид нар энэ тал руу хандвал зүйтэй болов уу гэж бодогдож байна.

Оөр нэг асуудал байна. Энэ нь хуралдааны ирцтэй холбоотой асуудал юм. Герман үндсэндээ 50 хувь олонхи гээд тогтчихсон байдаг. Хуралдааны ирцийг, гэхдээ шаардлагатай тохиолдолд, нэгдсэн хуралдаан дээр ч байнгын хорооны хуралдаан дээр ч хэрэв аль нэг намын бүлэг нь энэ 50 хувийн ирц заавал байх ёстой гэж шаардах юм бол энэ ирц нь хангагдсан байх ёстой. Үүнээс бусад тохиолдолд заавал гишүүдийг суу гэсэн хатуу зүйл байдаггүй.

Германы парламентын гишүүд нэлээд ажил

хэрэгч, сахилгатай хүмүүс учраас сууж байгаа хүмүүсийн тоо бусад орнуудтай харьцуулах юм бол бас харьцангуй өндөр байдаг тал ажиглагдаж байсан. Байнгын хорооны хурал дээр асуудал хэлэлцэж байхад гишүүдийн харьцаа Бундестагт намуудын эзэлсэн харьцаагаар хуваагдсан байдаг. Тэгээд нэг асуудал хэлэлцэж байгаад тухайлбал сөрөг хүчин болсон, цөөнх болсон хүчин яг хэлэлцэж байх явцдаа олонх байгаа юм. Байнгын хорооны дарга нь санал хураах хугацааг зарлахад олонхийн бүлгийн ажлын албаных нь өөр байнгын хорооны хурал дээрээс тухайн байнгын хорооны гишүүдийг урьж авчирч суулгаад олонхи болгоод санал хураах гээд эхлэнгүүт нөгөөтөх нь санал хураалгахаа болилоо гээд татаж авч байсан тийм зүйлүүд гардаг юм байна. Үүнийг би жишээ болгон дурьдаж байгаа юм.

Хуралдааны ирцийн асуудал манайд хамгийн гол төвөгтэй асуудлын нэг болж байгаа билээ. Үндсэн хуулинд УИХ-ын нийт гишүүдийн гуравны хоёр нь байж хурал хүчинтэй болох ёстай гээд заачихсан мэт зарим хүмүүс ярьдаг. Энэ бол тийм биш. Үндсэн хуулинд тодорхой заалттай байгаа. Тэр нь "Үндсэн хууль болон бусад хуульд өөрөөр заагаагүй бол хуралдааны ирц дийлэнх олонх байна" гэж заасан заалт юм.

УИХ-ын хуралдааны дэгийн хуулинд чуулганы нэгдсэн хуралдаан дийлэнх олонх нь ирснээр хүчин төгөлдөр болно гэж заасан. Байнгын хорооны хуралдааны ирц 50 хувийн ирцтэй байхаар хүчин төгөлдөр болно гэж заах юм бол энэ нь Үндсэн хуулийн дагуу Үндсэн хуулинд нийцэж байгаа хэрэг. Энэ асуудлыг УИХ дахь нам, эвслийн бүлгүүд хоорондоо ярилцаж шийдэх боломжтой. Ер нь энэ асуудлыг шийдэхгүй байх нь цаашдаа парламентын хуралдааны үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлнэ. Энэ бол парламент төлөвшихд жижигхэн боловч чухалач холбогдолтой.

Германы Бундестагт ахмадын зөвлөл гэсэн байгууллага байдаг. Энэ нь Бундестагийн Ерөнхийлөгч мөн Бундестагийн дэд Ерөнхийлөгчид, холбогдох байнгын хороодын дарга нар, намын бүлгүүдийн ахлагч нар, шаардлагатай бол парламентад олон жил суусан туршлагатай парламентацид, Тамгын газрын зэrim нэгэн удирдлага орсон зөвлөл юм. Бусад оронд парламентын тэргүүлэгчид, товчоо гэж янз бүрээр нэрлэгддэг бүтэц байдаг. Энэ нь ямар эрх мэдэлтэй, ямар үйл ажиллагаа явуулдаг вэ гэвэл парламентын хэлэлцэж байгаа асуудал болон парламентын өөрийн нь амьдралтай холбоо бүхий дотоод зохион байгуулалт, санхүү, хангамжийн холбоотой гол гол зарчмын асуудлуудыг ярилцаж, тохиролцож шийдвэрлэж байдаг. Энэ бол манайд хамгийн их дутагдаж байгаа зүйл гэж үздэг.

Манайд яагаад дутагдаж байгаа гэж үзэж байна вэ? гэвэл 1990-1992 оны үед ч, 1992-1995 он, мөн одоогийн парламентын үед ч иймэрхүү байгууллага байхгүй байгаагаас ажил хариуцаж байгаа хүн нь УИХ-ын дарга, мөн УИХ-ын Тамгын газарт энэ асуудал нь шууд шийдэгдээд явах явдал байдаг. Харин 1996 оноос УИХ-ын дарга дээр 7 хоног бурийн баасан гариг бүр ирэх долоо хоногийн байнгын хороодын хуралдааны төлөвлөгөө хэлэлцэх асуудлыг тогтдог болсон нь бага боловч зөв хандлага юм.

УИХ-ын дарга дээр байнгын хороодын дарга нар, олонхи цөөнхийн ахлагчдыг урьж саналыг нь асуугаад чуулганаар хэлэлцэх асуудлаа тогтдог. Мөн ажлаа еренхийдөө төлөвлөж явуулдаг байх үүднээс дараагийн хоёр дахь долоо хоногийн ажлыг хэлэлцэхээр урьдчилан төлөвлөдөг. Иймээс Германы жишээгээр бид нар ийм байгууллагыг нэн даруй байгуулах нь зүйтэй юм.

Бундестагийн үйл ажиллагаа нэлээд шуурхай байдаг. Энэ бол парламентын ардчилал өндөр хөгжсөн орнуудад бүгдээд нь байдаг. Тухайн өдрийн чуулганы хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл маргааш өдөр нь гэхэд гишүүдийн гар дээр бичмэлээр болон өөр бусад хэлбэрээр очихсон байдаг. Үүнийг Германы парламентын Тамгын газарт уг асуудлыг хариуцсан нэгжийнхэн цагт нь гүйцэтгэж байдаг. Эндээс бид жишээ авах ёстай. Манайх чуулганы нэгдсэн хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэлийг үндсэндээ 10 юм уу 14 хоногт багтаагаад хэвлээд бичмэлээр, дараа нь номын сангүүдад хүргүүлдэг. Энэ бол хэтэрхий удаан хугацаа. Тиймээс Тамгын газар 3 хоногт багтааж УИХ-ын нийт гишүүд компььютерийн дотоод сүлжээнд холбогдсон учраас дөрөв дэх, тав дахь өдрийн хурлын протоколыг нэг, хоёр дахь өдөртөө багтаагаад ямар ч гэсэн компььютерт нь хийчихсэн байх зорилт тавьж байна.

Германы Бундестаг манайхтай адилхан 10 дугаар сарын нэгэнд чуулган эхлээд 1 дүгээр сарын 23-нд ч юм уу, дөрвөн сар тасралтгүй хуралддаг. Гэхдээ 7 хоног бүр тасралтгүй хуралддаггүй. Энэ хуралдааны 7 хоног гэсэн ойлголт байдаг. Өэрөөр хэлбэл 10 дугаар сарын 1-нээс эхлээд 10 сарын эхний хоёр юм уу гурван долоо хоног хуралдчихаад дараагийн хоёр долоо хоног нь өөрийн тойротг очиж ажиллах, дараагийн хуралдаануудад бэлтгэх тийм бололцоог хангаж өгдөг. Ерөнхийдөө Европын оршууд ихэнхдээ ийм. Энэ нь газар нутаг жижигхэн, дэд бүтэц сайн хөгжсөн, тойротгоо хурдан очоод хурдан ирэх бололцоотой, тийм учраас болж байгаа юм гэж тайлбарлаж болно. Монгол бол тойргийнхоо хувьд бололцоо хязгаарлагдмал зэрэг хүндрэл байгаа боловч бид нар Герман болон бусад оронд байдаг энэ туршлагыг авч хэрэглэх нь зүйтэй юм.

Оер нэг жижигхэн зүйлийг бид нар авч хэрэглэж болох юм гэж санагдаж байна. Чуулганы нэгдсэн хуралдаан болон байнгын хороодын хуралдаан эхлэхэд хуралдаан даргалагч хуралдааныг нээхдээ өнөөдрийн хуралдаанд ийм асуудлыг хэлэлцэн гэхийн хажуугаар манай байнгын хорооны гишүүн тэрний төрсөн өдөр болж байна баяр хүргээ ч гэдэг юм уу, үгүй бол манай байнгын хорооны гишүүн хүйтэй болж байна гэх зэрэг амьдралын хувь хүний зүйлийг тохиолдуулж хуралдааны эхэнд баяр хүргэдэг. Тэр нь баяр хүргэж байгаа юм шиг боловч хуралдааны уур амьсгалыг эхнээс нь аятайхан болгоход нэлээд нелөөтэй юм шиг байдал.

#### Хоёр. Парламентын нээлттэй байдал.

Парламентын нээлттэй байдлыг хэрэв ярих юм бол нэлээд өргөн ойлголт. Тэгэхээр парламентын нээлттэй байдал гэдгийг парламентаас гаргаж байгаа шийдвэр олон түмэнд хүрч хүргэж байгаа байдлын хүрээнд авч үзье.

Парламент нээлттэй байх асуудлыг үндсэн хуулиндаа заасан байдал байна. Чуулганы хуралдаан нээлттэй. Түүнийг хүссэн хэн боловч ирж үзэх бололцоотой. Энд Германы өнцөг булан бүрээс Бундестагийн хурлыг ажиглах гэж урьдчилан захиалга өгөөд тасралтгүй орж ажигладаг. Нэг ээлжиндээ миний ажигласнаар 150-200 орчим хүнийг суулгах бололцоотой. Чуулганы нээлттэй байдлыг хангахдаа аюулгүй байдлыг их сайн хангасан байдал. Суусан хүн бүр 40 орчим минут ажиглаад эзлж ээлжээр гарах бололцоотой. Ирж үзсэн хүмүүст парламентын үйл ажиллагааны тухай танилцуулга, материал, зөвхөн Бундестагийн тухай биш, хууль тогтоох үйл явц өр нь улс төрийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн материал зүйлүүдийг хангальтай тарааж өгч байгаа нь харагддаг юм.

Телевиз радиогоор парламентын шийдвэрийг шууд тогтмол хүргэж байдал. Энэ бол нийтийн эрх зүйн статустай радио телевизээр болон хувийн телевизээр тогтмол нэвтрүүлэг хэлбэрээр хэрэгждэг. Олон нийттэй хэрхэн харьцаж ажилладаг вэ гэвэл Тамгын газарт нь энэ ажлыг хариуцсан хэд хэдэн том нэгж байдал. Тэд дөрвөн үндсэн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Нэгдүгээрт нь түрүүнд миний дурьдсан материалуудыг хэвлэж тараадаг. Хоёрдугаарт нь интернет болон компакт диск зэрэг янз бүрийн хэлбэрийг ашиглаж Бундестагийн үйл ажиллагааг сурталчилдаг.

Гуравдугаарт нь аудио болон видео кассетыг хэргэлж үүн дээр Бундестагийн болон хууль тогтоох үйл явцын тухай жижигхэн кино бичлэгүүдийг худалдах, өгөх солилцох зэрэг хэрэглэдэг. Дөрөвдүгээрт нь ямар нэгэн арга хэмжээ зохион байгуулах. Парламентыг

сурталчлах, группыг орон нутагт зохион байгуулах, хүүхдүүдийн дунд минипарламентыг зохион байгуулах, телефоноор парламентын гишүүдтэй уулзуулж асуулт хариултанд оролцуулдаг байх зэрэг хэлбэрүүдийг ашигладаг байна. Манайд энэ талаар ямар байна вэ гэвэл Улсын Бага Хурал үүссэн цагаас эхлээд энэ тал дээр анхаарч ирсэн. Ялангуяа 1996 онд одоогийн УИХ байгуулагдсанаас хойш энэ асуудал нэлээд алхам хийсэн гэж хэлж болно. Энэ нь нэгдүгээрт УИХ-ын чуулганы дэлгэрэнгүй протоколыг хэвлээд нийт номын сангүудад тарааж байна.

Мен УИХ-ыг сурталчлах танхимиyg Үндэсний түүхийн музейд Нийгмийн Дэвшил Эмэгтэйчүүд хөдөлгөөнтэй хамтран нээж байгуулсан болно. Энд хүмүүс орж чуулганы хуралдааныг үзэх бололцоотой, мөн гарын авлага материалыг ерөнхийдөө бэлтгэж тараах боломжтой болсон ба санхүүгийн асуудал шийдэгдэвэл хэрэгжүүлэх чиглэл рүү орно.

Телевиз радиогийн хувьд бол парламентыг сурталчилья гэсэн хүсэлтэй сонин хэвлэл, мэдээллийн хэрэгслүүдийг хааж боосон үйл ажиллагаа байхгүй. Харин ч дэмжиж, зохицуулалтын нэлээд арга хэмжээ авч байгаа. Тиймээс ч парламентын тухай, парламентын гишүүдийн тухай яг одоогийн Монголын нийгэмд маш их бичигдэж байгаа зүйл ажиглагдаж байгаа юм. Харин янз бүрийн сувгаар мэдээлэл очиж байгаа учраас үнэн зөв янз бүрийн мэдээлэл байна. Албан ёсны мэдээлэл өгөх талаасаа бидний үйл ажиллагаа хоцрогдож байгаа юм биш байгаа гэдэг үүднээс дүгнэлтэй хандаад парламентын хэвлэл мэдээллийн албыг бэхжүүлэх, энэ талаар нэлээд зүйлийг төлөвлөж байгаа юм.

Парламентыг нээлттэй болгох үүднээс хийх, шийдэгдээгүй асуудал олон бий. Одоогийн УИХ-ын чуулганы хуралдааны заалыг хуучин Ардын Их Хурлын хуралдааны зааланд шилжүүлэх нь зүйтэй гэж бодож байна. Энэ арга хэмжээг хэрэгжүүлснээр хүмүүсийг оруулж үзүүлэх, доор нь хэвлэлийн төвийг нээн ажиллуулж сэтгүүлчдэд харьцангуй бололцоотой болгох, телевизийн суваг, компьютерийн суваг бүгдийг нь тийш нь оруулаад сурталчлах тийм бололцоог нээх бодолтой төлөвлөгөө байгаа. Хэр зэрэг шийдэгдэх нь мэдэгдэхгүй байна. Хүмүүс хэр зэрэг дэмжихийг бас мэдэхгүй байна.

Парламентыг нээлттэй болгохын тулд чуулганы нэгдсэн хуралдааныг радио телевизээр шууд дамжуулж байх нь зүйтэй юм гэдэг бодол байгаа. Гэхдээ бидний ажлын зохион байгуулалттай холбоотой нэлээд асуудал байна. Мен одоогийн дотоод сүлжээг телевизээр шууд нэвтрүүлэхэд техникийн хувьд жаахан бэрхшээл байна. 2000 он хүртэл энэ чиглэлд бодит алхам хийнэ гэж Тамгын газрын зүгээс төлөвлөж байна.

## Бүгд Найрамдах Болгар Улсын Парламентын тухай

**Р. Бурмаа**

НДЭХ-ний тэргүүн, "Иргэдийн  
оролцоо Ардчилал" төслийн  
зохицуулагч

"Иргэдийн оролцоо-Ардчилал" төслийн хүрээнд Парламентын нээлттэй байдал, дэг, Парламентын гишүүний ёс зүйн талаар Монгол орныг бусад улсынхтай жишиж харьцуулсан судалгаа хийсэн юм. Үүнд: ендер хөгжилтэй парламентын олон жилийн уламжлалтай, туршлагатай улс орнуудаас Франц, Герман, тоталитар дэглэмээс иргэний нийгэмд ардчилсан тогтолцоонд шилжиж буй улс орнуудаас Болгарыг сонгон авч эдгээр 3 улсад УИХ-ын олонхи, цөөнхийн гишүүдээс, УИХ-ын Тамгын газар, НДЭХ, СБТөвөөс оролцсон 3 баг очиж танилцах аялал хийж судалгаа хийлээ. УИХ-ын гишүүн Б. Дэлгэрмаа бид хоёр Болгар улсын Парламентын үйл ажиллагаатай танилцсан юм.

Монгол улс шилжилтийн түүхэн богино хугацаанд хууль тогтоох дээд байгууллагын үйл ажиллагааг иргэдээд нээлттэй болгох ёс зүй, дэгийн талаар хийж буй ололт амжилт нэлзэн байгаа билээ. Тухайлбал, одоогийн УИХ-ын үед санал хураалт илээр иргэдээд мэдээлэх, чуулганы протоколыг нийтийн номын сангруудад тараах, УИХ-ын чуулганы төлө сүлжээг Төрийн ордонд болон ордноос гаргах эхний алхамууд хийгдээд байна. Энэ асуудлаар иргэдийн үүсгэл санаачлагын ТББ-тай хамтран ажиллаж байна.

Хууль тогтоох байгууллагын илүү нээлттэй байдлыг Байнгын хорооны хуралдаан болон Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал орон нутгийн түвшинд нээлттэй болгох, УИХ-ын чуулганы үйл ажиллагааг орон даяар шууд нэвтрүүлдэг болгох, УИХ-ын гишүүдийн ёс зүйн талаар харгалзах хуулиудад тодорхой тусгах зэрэг цаашид авч хэрэгжүүлэх ажлууд бас нэлээд байна.

Хууль тогтоох дээд байгууллага, хууль санаачлагчид, хууль боловсруулагчдын бөрсөдтэй нь илүү холбоотой асуудалд УИХ-аас гаднах дуу хоолой иргэдийн байгууллага, судлаачдын санал дүгнэлтийг тусгах нь их чухал юм. Энэ нь УИХ-ын нээлттэй байдлын бас нэг хэлбэр гэж хэлж болно.

Болгар улс нь Монгол улстай адил нийгмийн тогтолцоонд байсан мөн одоо ч бас адил, шилжилтийн байдалд байгаа орны хувьд улс - төрийн шинэчлэл, тухайлбал

Парламентын дэг, ёс зүйн асуудал дээр Монголтой харьцуулахад ямар байна вэ гэдэг нь сонирхолтой байна.

1991 оны 6-р сард батлагдсан шинэ Үндсэн хуулиар Болгар улс парламентын засаглалтай болсон. Тус улсын Ерөнхийлөгч бүх ард түмнээс сонгогддог.

Ардын Хурал нь 240 депутаттай, 4 жилийн хугацаатай сонгогддог. Өмнөх Үндсэн хууль болон шинэ Үндсэн хууль дахь Ардын Хурлын тухай заалтын гол ялгаа нь:

- Ардын Хурал нь тогтмол үйл ажиллагаатай байгууллага
- Ардын Хурлын хуралдааны үйл ажиллагаа нээлттэй байна
- Ардын Хурлаас гаргасан хууль тогтоол нь Болгарын бусад бүх байгууллага, иргэд дагаж мөрднө гэж заажээ.

Болгар улс нь 200-аад намтай. Одоогийн Парламентад 20-иод нам ордог. Үүнд:  
125 - Ардчилсан Хүчиний Холбоо \дотроо 16 нам\  
58 - Ардчилсан Зүүний Групп \хуучин социалист нам\  
19 - Үндэстнээ Аврах Холбоо  
14 - Еврозүүний Групп \хуучин социалист намаас салж гарсан\  
12 - Ардын холбоо Групп  
12 - Бие даасан депутатууд

Дарга ба хоёр орлогч даргатай. Олонхи ба цөөнхийн гол намаас орлогч дарга нар сонгогддог. Бусад намуудаас нэр дэвшиж сонгогдсон турван орлогч дарга чуулган бүрд ротациар ээлжилдэг. 15 байнгын хороотой. Өмнөх Ардын Хурал нь ёс зүйн хороотой байсан байна.

**Эхлээд депутатын ёс зүйн асуудлын талаар ярья.**

Болгар улсад 1990 оноос хойши шилжилтийн явцад нилээд олон Засгийн газар ойр ойрхон солигдсон, коррупци газар авсан зэрэг байдлаас болж Ардын Хурлын тухай хуулиндаа ёс зүйн асуудлаар нэлзэн тодорхой заалтуудыг оруулжээ. Тусдаа ёс зүй болон лоббийн хууль байхгүй байна.

Төрийн ендер албан тушаалтан коррупцид өртөхгүй байх, ёс зүйн хэм хэмжээг барьж байхад менгэтэй холбоотой заалтуудад тодорхой байлагах нь тун чухал ач холбогдолтой. Энэ

Ардын Хурлын депутат нь:

- хөдөлмөрийн хөлснөөсөө өөр шагнал урамшуулал авч болохгүй. Зөвхөн иргэний гэрээний үндсэн дээр л болно.
- Нэр албан тушаалаа зар сурталчилгааны зорилготой аливаа ажилд оруулахгүй байх
- Сонгогдонохоо дараа эхний чуулган хуралдсанаас хойш 1 сарын дотор төсөв санхүү, санхүүгийн хяналтын хороонд сонгогдох хүртэлх эд хөрөнгийнхөө мэдүүлгийг өгнө. Мөн жил бүр нэмэлт орлогын мэдүүлгийг өгнө.

Сонгуулийн хандивын дээд хэмжээг 2000 амдоллараар тогтоосон ба сонгуулийн хандивын орлогын тайланг мэдээлж байхыг сонгуулийн хуулиндаа заасан байна. Сонгуульд нэр дэвшигчдийн өгөх хандивын дээд хэмжээг тогтоосноор сонгогдоны дараа депутат ивээн тэтгэгч нартадаа бус харин нийтэд үйлчилдэг, тэдний өмнө ажлаа тайлагнадаг байхад үүний утга учир байна.

Дээрх шиг тодорхой хуулийн заалтууд Монголын хууль тогтоомжуудад тусгагдаагүй. Ёс зүйн дэд хорооноос боловсруулж буй УИХ-ын гишүүний ёс зүйн тухай хуулийн төсөл дээр ч энэ асуудал тодорхой бус байна.

Депутатууд дундаж цалингаас 3 дахин их цалин авах ба энэ үнэлгээг турван сар тутам тооцоолж байна. Дарга үндсэн цалингийн 50%, орлогч 40%, байнгын хорооны дарга 30%, байнгын хорооны гишүүн 10% нэмэгдэл авна. Депутат үндсэн цалингийн 1/5-аас дээш үнэтэй бэлэг тухайн сардаа авч болохгүй. Илүү гарсан тохиолдолд Ардын хуралд шилжүүлнэ.

Терийн албанад ажиллаж буй хүн сонгуульд нэр дэвшихээр бүртгүүлсэн хугацаанаас эхлэн сонгуулийн хугацаанд териин албан ажлаасаа чөлөөлгөднө.

Депутатууд териин өөр албан ажил давхар эрхэлж болохгүй. Засгийн газрын гишүүн сайдар сонгогдсон тохиолдолд сайд байх хугацаандаа депутатасаа чөлөөлгөднө. Хэрвээ сайдын албан тушаалаасаа болиход депутатын суудал нь хэвээр сэргээгднэ. Пропорциональ сонгуулийн системтэй тул депутат сайдын албан тушаалд сонгогдсон тохиолдолд тухайн намын дараачийн нэрээр дэхь хүн Ардын Хурал дахь орны суудалд нь орж ирдэг тул парламент дахь нам болон хүчний харьцаанд өөрчлөлт ордоггүй байна.

Ёс зүйн асуудлыг Ардын Хурлын дэгтэй холбогдуулан мөн тодорхой зааж үүнтэй холбоотой авах шийтгэлийг ч бас нэлээд тодорхой тусгасан байна.

Илтгэгчийн үгийг таслах, хувь хүн рүү дайрах, гутаан доромжлох, хэн нэгний эсрэг сурдүүлж заналхийх хөдөлгөөн гаргах, нэр төрийг гутаан доромжлох, хувийн амьдралыг хөндөх, хуралдааны дэгийг зөрчихийг хориглоно. Энэ тохиолдолд:

- сануулах \сануулах нь хуралдааны дэг зөрчих тохиолдолд\
- тэмдэглэх \тэмдэглэх нь хурлын даргаас сануулсны дараа үргэлжлүүлэн дэг зөрчиж буй нөхцөлд мөн бусад коллегид доромжилсон, уг хэлэх, хөдөлгөөн, сурдүүлэх тохиолдолд\
- уг хэлэхийг нь болиулах \арга хэмжээнүүдээс 2 дахин авсан тохиолдолд уг хэлэх эрхийг нь тухайн хуралдаанд хасах\
- хуралдаанд оролцох эрхийг хасах \бүдүүлэг харьцсан болон хуралдааны хэвийн үйл ажиллагааг явуулах бололцоо өгөхгүй байгаа тохиолдолд, бусдын товчлуураар санал егсэн тохиолдолд танхимаас гарагыг шаардана. Мөн Ардын Хурал болон териин тэргүүнийг доромжилсон, дахин бусдын картаар санал егсэн тохиолдолд 3 хүртэл хугацаанд хуралд оролцох эрхийг хасах бөгөөд энэ хугацааны хөдөлмөрийн шагналт цалинг хасна\

Парламентаас гүйцэтгэх засаглалтай холбоотой асуудлыг хуульчлахдаа гүйцэтгэх засаглал, түүний бие даасан байдал болон Парламентад тайлагнадаг, хянадаг механизмыг нэлзэн нарийвчлан тогтоосон байна. Жишээлбэл,

Депутатууд сайд нарт асуулт тавихдаа асуултууд товч тодорхой байх ба хувийн асуудал руу дайрсан асуулт байж болохгүй г.м. Мөн хэдэн цаг хоногийн өмнө асуултыг өгөх, хариултыг авах гэх мэтчилэн тодорхой тусгасан байна.

1998 онд коррупцийн гэмт хэргийн эсрэг үйл ажиллагааны хороог байгуулсан ба хорооны дарга нь Парламентын дарга байна гэж заасан нь энэ талын асуудалд их ач холбогдол егсэн хэрэг..

#### Парламентын нээлттэй байдал

Ардын хурлын чуулганы хуралдаан нээлттэй байх ба Байнгын хороодын хуралдаан мөн нээлттэй байна гэж хуулиндаа зааж өгнө. Харин

- үндэсний аюулгүй байдал, мөн гадаад бодлогын комиссын хуралдаан хаалттай байна
- эдгээр комиссын шийдвэрээр зарим хуралдаан нээлттэй байж болно
- депутатууд өөрийн байнгын хорооноос бусад байнгын хороодын аль ч хуралдаанд санал өгөх эрхгүйгээр оролцож болно. Депутатууд асуудалтай холбоотой иргэний нэр хүндийг хамгаалах үүднээс нууцыг хамгаалах ёстой.

Ардын хурлын чуулганы үйл ажиллагааг

Болгарын үндэсний радиогийн тогтмол нэг сувгаар бүх орон даяар шууд нэвтрүүлнэ. Телевиз мэдээллийн, нэвтрүүлгийн хэлбэрээр нэвтрүүлнэ.

Телевизийн шууд нэвтрүүлгийг Ардын Хурлын шийдвэрээр нэвтрүүлнэ. Болгарын үндэсний радио мен үндэсний телевиз байнгын хорооны хуралдаануудыг нэвтрүүлэх эрхтэй.

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн 9-р зүйлд УИХ-ын хуралдаан нээлттэй байна гэж заасан байгаа. Гэвч байнгын хорооны хуралдаанд хэвлэл, мэдээлэл, иргэд оролцох үзүүлэлтэй боломжгүй, хаалттай байгаа гэж хэлж болно.

Депутатууд зөвхөн индрээс үг хэлнэ. Хэлэлцэж буй асуудлаас хазайвал Ардын Хурлын дарга сануулах ба хэрвээ энэ байдал үргэлжилбэл зогсононо. Нэг асуудлаар нэг л удаа ярих эрхтэй.

Хууль санаачлагчдаас оруулсан хуулийн төслийг хэлэлцэх шат дамжлага бүрийн хугацааг тодорхой зааж өгдөг байна. Парламентын хуралдааны протокол зөвхөн парламентын байранд байдаг номын санд байдаг ба энэ нь ердийн иргэдэд үзэж танилцахад бэрхшээлтэй, бололцоогүй байна. Ардын Хурал бие даасан байранд байрладаг ба хуралдааны үйл ажиллагааг иргэд үзэж танилцах боломжтой. Бичиг баримтын шат дамжлага бэрхшээлгүй, харин хамгаалалтын аюулгүй байдлыг хангах үүднээс шалгах төхөөрөмжтэй байдаг байна.

Нэлээд ижил төстэй нийгмийн тогтолцоонд байгаа Болгар улсын хууль тогтоомжид Парламентын нээлттэй байдал, депутатуудын ёс зүйн асуудал ялангуяа мөнгөтэй холбоотой хандив, орлого, цалин гэх мэт зүйлүүдийг ихээхэн нарийвчлан тусгаж өгсөн зэрэг нь Монгол улсын ижил төстэй хуулиудыг илуу боловсронгуй болгоход санаа авууштай юм.

## Г. Чулуун, Улсын Их Хурлын Тамгын газар

### Тангарагийн бичгийн тухайд...

Өнөөдөр болж буй энэхүү Бага хурлын хэлэлцэх асуудлын хүрээ нь манай төрийн зарим өндер албан тушаалтны, ёс зүйн асуудалд хамаарах сэдвийг түгээмэл өргөн утгаар нь хөндөн авч үзэж байгаа тул, энд Улсын Их Хурлын эрхэм гишүүдийн ёс суртахууны хэм хэмжээний зарим аспектад анхаарлаа зориуд хандууллаа.

Төрийн өндер дээд албан тушаалтнуудын ёс суртахууны нэг чухал үүрэг бол тэд төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чандлан сахиж, албан үүргээ чин шударгаар биелүүлж, өргөсөн тангарагтаа үнэнч байх явдал юм. Өргөн олон түмнээс мандат аван төрийн эрх барих дээд байгууллагад сонгогдон ажиллаж буй манай эрхэм гишүүд эл үүргээ хэрхэн биелүүлж байна вэ гэдэгт үнэлгээ дүгнэлт өгөхийг энд зориогүй бөгөөд энэ нь хэн хүний хийдэг ажил биш төдийгүй үнэхээр хариуцлагатай, маргаантай асуудал болох нь ойлгомжтой биз ээ.

Төрийн албаны тухай хууль тогтоомжид давтагдмал байдлаар олонтаа хөндөгдсөн эл хүрээний бүлэг асуудлууд нь хуулийн хэрэгжилт гэдэг утгаараа эргээд өөрөө үнэлгээний тодорхой хэмжүүр бий болгохыг төдийгүй түүнийг чухам хэн, хэдийд, хэрхэн хэрэглэх вэ гэх зэргээр бүхий л зүйлийг тов тодорхой болгож өгөхийг шаарддаг байна. Харамсалтай нь манайд одоохондоо хуулийн энэ чиглэлийн заалтууд нь хоосон тунхаглалаас цаашгүй байдалд байгаа билээ.

Үүнийг шүүмжлэлтэйгээр олж харсан иргэдийн үүсгэл санаачлагын байгуулагууд болох Нийгмийн Дэвшил Эмэгтэйчүүд хөдөлгөөн зэрэг ТББ-аас санаачлан, "тодорхойгүйн мананд умбасан" энэхүү эмзэг бөгөөд хүнд сэдвээр Олон улсын бага хурал зохион байгуулж байгаа нь нэг талаас эл асуудал яригаад байдаг хэрээ "оромноосоо огт хөдөлдөггүйн" учир шалтгааныг ухаж олох гэсэн олон түмний хүсэл тэмүүлийн нэг илрэл гэж тус Бага хуралд оролцгчийнхoo хувьд үзэж байгаагаа энэ дашрамд илэрхийлэхэд таатай байна.

Нийгмийн харилцааг бид хуулиар зохицуулдаг. Ямарваа нэгэн хуулийн зохицуулалт гэдэг нь тухайн асуудлыг тороос албадан журамлахыг л хэлж байгаа хэрэг юм. Нийгмийн амьдрал өөрөө дэндүү олон талтай даанч баян байдаг тул түүний бүхий л асуудлыг хуулиар зохицуулна гэдэг өөрөө бутэшгүй зүйл. Ийм ч учраас ард түмний дунд "бичигдээгүй хууль"-ийн тухай ярьдаг, түүнийгээ нийтээр дагаж мөрдөхийг хичээдэг ажээ. Ярианы хэллэгзээр бол, ард түмний уламжлалт зан заншил хүсэл сонирхлоор аяндаа мөрдөгдэж байдаг "ийм юм"-ыг ёс суртахуун гэж нэрлээд байгаа юм.

Нийгмийн хөгжлийн явцад шашны болон бусад үзэл номлолууд хүчтэй нэлөөлэлтэй байсан түүхэн цаг үеийн улбаанаас уламжлагдаж ирсэн дадал зуршлын шинж чанартай хэвшмэл үйлдлэг мөрдлөгүүдийг бид ёс суртахуун гэсэн ухагдахуунд хамаатуулан авч үзсээр ирсэн байна.

Төрийн албан хаагчийн ёс суртахууны хэм хэмжээний тухай ярихын тулд ёс зүй ба ёс суртахуун гэгч нь юу болох, ёс суртахууны үнэлэмжийн хэмжүүрийн тухай ялгаж салгаж нарийвчлан тодотгож ойлгосон байх шаардлагатай юм. Харамсалтай нь манайд эдгээр ухагдахуунуудыг бүгдийг нь хооронд нь хольж хутган ганцхан утгатай болгож яриад, үүнийгээ, "бид буруу ярьж зөв ойлгодог" хэмээн тайлбарлаж мэдэхээр болчкоод байгаа билээ.

УИХ-ын гишүүд гэж хэн бэ, тэд тангарагийн бичгийнхээ агуулгын эсрэг далдуур хэрхэн "тэмцэж" байна вэ?

Манай улсын Төрийн эрх барих дээд байгууллагын буюу УИХ-ын гишүүн бол Үндсэн хуулийн 23-р зүйлд зааснаар нийт иргэн, улсын эрх ашиг сонирхлыг эрхэмлэн ажиллах, ард түмний элч төлөөлөгч бөгөөд түүний бүрэн эрх нь төрийн сүлдэнд тангараг өргөснөөр эхэлдэг. УИХ-ын дараагийн ээлжит сонгуулиар шинээр сонгогдсон УИХ-ын гишүүн тангараг өргөх хүртэл үйлчилдэг.

Үндсэн хуулийн энэхүү зүйл заалтуудад УИХ-ын гишүүний тангараг өргөх ёслол, үйлдэл онцгой ач холбогдол өгсөн нь шууд харагдаж байна. Эндээстангараг гэж юу юм, хувь хүний зан үйлийг залан зохицуулагч тийм их ид шидтэй зүйл мөн үү, биш үү, тэр нь хувь хүний ёс суртахууны хэм хэмжүүртэй ямар сэжимээр холбогдох вэ гэсэн асуултууд урган гарч ирнэ.

Хуулийг тэр хариуцдаг, ёс суртахууныг ард түмэн хариуцдаг. Аливаа тангарагийг тухайн хүн өөрөө хариуцдаг гэсэн логик дэс дараалалтай нийгмийн ухагдахуунуудын үүдиээс авч үзвэл хуулиар, мөн түүнчлэн ёс суртахуунаар шийдэж болмооргүй зүйлийг төрөөс хувь хүний оюун санаа, зүрх сэтгэлд даатган орхихдоо тангараг өргүүлж байгаа болов уу, гэсэн санааг УИХ-ын гишүүн асан, талийгаач Г. Зуунайн хэлж ярьж байсныг санаж байна. Хэрэв ийм бол УИХ-ын гишүүн тангараг өргөх нь хуультай төдийгүй ёс суртахуунтай ч холбоотой асуудал болж таарна. Өөрөөр хэлбэл, УИХ-ын гишүүний тангарагийн тухай ярих нь түүний ёс суртахууны асуудлыг хөндөнө гэсэн үг юм. УИХ-ын гишүүнээр сонгогдсон хүн "... би ард түмнийхээ элчийн хувьд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн, төрийн хуулийг дээдлэн сахиж, хүлээсэн үүргээ чин шударгаар биелүүлэхээ ..." андгайлж, төрийн

сүлдэнд ёслол төгөлдөр тангарагладаг. Гэтэл УИХ-ын эрх зүйн байдлын тухай хуулинд УИХ-ын гишүүн хүн өргөсөн тангарагаасаа няцсан тохиолдолд хэрхэх тухай заалт байхгүй байна. Ядаж тангарагийнхаа бичгийн агуулгад андгайгаа зорчвэл огцрох тухай хүснэгтээ гаргахаар ч байдаг юм уу, уг өгүүлбэр оруулчихалгүй "мартихсан" бололтой юм.

Манай Үндсэн хуулийн 35-р зүйлд Монгол Улсын Ерөнхийлөгч өргөсөн тангарагаасаа няцаж, хууль зорчвэл, түүнийг огцуулах тухай, мөн Төрийн албаны тухай хуулинд төрийн захирагааны албан хаагч тангарагаа зорчвэл хуулийн хариуцлага хүлээх тухай заалтууд оруулсан байдагтай харьцуулбал УИХ-ын эрхэм гишүүд тангараг өргөсөн 14-р зүйлд "хүн бүхэн хуулийн өмнө эрх тэгш байна" гэж заасан байдаг шүү дээ.

УИХ-ын эрхэм гишүүд энд хууль тогтоох өөрт оногдсон давуу эрхээ "ашиглаж", Үндсэн хуулийн зүйл заалтын дагуу ёслол төгөлдөр өргөж байгаа юм биш үү? Энэ бол УИХ-ын эрхэм гишүүд, улмаар УИХ өөртөө ёс суртахууны хариуцлага хүлээх эрмэлзэлгүй байдгийн жишээ юм.

Өөр нэг жишээ хэлье. Нийгэм дэх сонирхлоороо нэгдсэн цөөнхийн бүлэглэлүүдийн эрх ашгийн үүднээст төрийн хууль тогтоох дээд байгууллагын үйл ажиллагаанд шууд болон дам нөлөөлөх зорилго бүхий улс төрийн зуучлалын тусгай системийн зохион байгуулагдсан хэлбэршилийг хүлээн зөвшөөрөх хандлага манай төрийн бодлогыг тодорхойлогч дээд түвшинд ажиглагдаж эхэллээ. Үүнийг өгүүлэгч нь лоббизм хэмээх нийгмийн энэхүү серөг үзэгдлийг хуульчлан зохицуулахын төлөө байгаа юм.

Хэрэв энэ асуудал ийн шийдвэрлэгдэвэл УИХ-ын гишүүд маань өөрсдөө лоббистуудын татсан хэрмэл төрон сүлжээнд "таварцаглан" нийгэм дэх явцуу хэсэг бүлгийн ашиг сонирхолд зарим үед хетлегдэн, өөреер хэлбэл нийт иргэн, улс орны эрх ашгийг эрхэмлэн дээдлэх тухай өгүүлсэн тангарагийнхаа бичгийн агуулгатай чимэзгүйхэн "тэрсэлдэх" тал руу хальтирч унах заналд өртөх болно.

УИХ-ын гишүүн хүний үйлдлийн системд ёс суртахууны нэгэн хэмжүүр болгон тавьсан, үнэн хэрэг дээрээ ямар нэгэн хэрчлээс зураасгүй гэж хэлж болох "тангараг" хэмээн нэрийдсэн энэхүү үл ойлгогдох босгыг авч хаях нь амархан шийдвэрлэх зүйл биш юм. Гэхдээ амьдралын шаардлага үүсслээгээд хуулийг зөрчиж болохгүй, харин түүнийг өөрчилж болох ёстой.

Төрийн албан хаагчийн тангарагийн хэрэгцээ, шаардлага

Дээр өгүүлснээс үүдээд, нийгмийн хөгжлийн енеегийн нөхцөлд төрийн албан хаагчийн тангарагийн хэрэгцээ шаардлага, миний бодлоор эргэлзээнд орж байгаа юм. Ер нь тэгээд хэмжүүрийг нь нарийвчлан тодорхойлох боломжгүй ёс суртахууны ухадахуунууд нь цөм "бичигдээгүй хууль" гэгч шигээ барьцгүй, бясалгал шаардсан хэтэрхий "академически" агуулгатай байгаа тул, тэдгээрийг, бүх уг үсэг нь ард нийтэд нэгэн утгаар төгс ойлгогдох учиртай төрийн хуулийн зүйл заалтад хамаагүй оруулж суулгах нь осолтой үйлдэл мөн. Төрийн албан хаагчийн тангараг ч үүнд хамаарна.

Үндсэн хуулийнхаа зүйл заалтыг үндэслэн тангарагийг төрийн сүлдэнд өргөдөг. Аливаа тангарагийгюнд биш, хэнд өргөх вэ гэдэг талаас нь ч бас бодож үзэх хэрэгтэй юм. Эрх зүйт төр ёс хөгжин төлевшеегүй түүхэн эртний самуунт бүдүүлэг цаг үед, бурхан тэнгэрийн нэрийг барьж ээж аавдаа, амраг садандаа, анд нөхөртөө, өөреер хэлбэл хүн нь хүнийхээ өмнө амлалт авч, дааж давшгүй үүрэг хүлээдэг байсан хариуцлагын нэгэн өвөрмөц бөгөөд үеэг өнгөрөөсөн хэлбэр уламжлалаас өнөөг хүртэл татгалзаж чадаагүй байна гэдэг хачин юм шүү. Хүн нь хүндээ тангараг өргөх нь өнөө цаг үед нэн зохижгүй үзэгдлийн тоонд орох байлгүй. Төрийн албан хаагч, өндөр албан тушаалтнууд заавал ч үгүй тангараг өргөх ёстой юм байна гэдэгтэй, за яахав, санал нийллээ гэж бодъё. Тэгвэл тангарагийг Монгол Улсын Үндсэн хуулиндаа өргөх нь хуулийг дээдлэх агуулгаараа илүү утга учиртай бодитой байх байсан болов уу.

Төрийг бурханчлан шүтэж болохгүй ээ. Тэгвэл, хуулийн өмнө төр, иргэн хоёр тэгш байх зарчим, тэнцвэрийг олон түмэн өөрийн санаачилгаар өөртөө ашиглаж байгаа алдагдуулах болно. Төр, түүний түшээд тангараг хэмээх хийсвэрлэлийг бүү хэл, хуулийн тов тодорхой зүйл заалтыг санаатайгаар болон санамсаргүйгээр зөрчих нь энүүхэнд. Иймэрхүү үйлдлийнхээ төлөө тэд өчүүхэн ч хариуцлага хүлээдэггүй. УИХ-ын гишүүдийн ёс суртахуунд, тэдний өргөсөн тангарагт найдах юм бол хамгийн наад зах нь УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаан хэзээ ч хуулиар тогтоосон цагтаяа эхлэхгүй. Байнга зөрчигдээд байдаг хуулийн заалт байгаа бол тэр амьдралд нийцэгүйн л шинж. Хууль мөрдөгдхөл ёстой бол түүнийг зөрчсөн этгээд хуулийн хариуцлага хүлээх учиртай юм.

"Та нар ингэх ёс суртахууны эрхгүй" ч гэдэг юм уу, үүн лүгээ нэгэн адил тоозогносон бодит бус шаардлага тавих хэлбэрээр үүнийг эсэргүүцэх нь хоосон чанартайн зэрэгцээ олон түмний төөрөгдлийн илрэл байдаг. Яах ёстой вэ гэхлээр Үндсэн хуульд "терийн зүгээс хуулийг зөрчсөн нь эрх бүхий субъектүүдийн дүгнэлтээр нотлогдсон

тохиолдол бүрийн тоогоор түүний бүрэн эрхийн хугацаа өм цөм хорогдож байхаар, өөреөр хэлбэл, тер өөрөө хууль бус үйлдлийнхээ төлөө бодит хариуцлага хүлээдэг байх" утга санаа оруулах замаар асуудлыг хуульчлан зохицуулмаар байна. Байгууллага хариуцлага хүлээдэггүй юм гэж манай зарим хуульчид үздэг юм билээ. Тийм хатуу ойлголт байх учиргүй.

Ингэхлээр, төрийн өндөр албан тушаалтнуудын тангараг өргөх үйлдлэг нь нийгэмд хэрэг болохоосоо илүү, хуулийг боловсронгуй болгох чиглэлд саад тогтор учруулагч, хэрэгцээ шаардлагагүй арга хэмжээ юм байна.

#### Хувь хүний нэр төр, түүний үнэ цэнэ

Хорвоогийн амьдрал өөрөө байнгын хөгжил хөдөлгөөнд байдаг зүй тогтолыг дагаад ард түмний зан заншил, нийгмийн ёс суртахуун ч гэсэн цаг хугацааны эрэмбээр хувьсан өөрчлөгддөг ажгуу. Нэгэн цаг үед дэлхийн зарим улс оронд нийтэд хууль мэт дагаж мөрдөгдөж байсан бурангуй ёсны бэлэн жишээ болох "дуэль" буюу ирүүл тулалдаан тэгчийн тухай бид дунд сургуулийн сургач ахуй цагаасаа мэдэх билээ. Хүн төрөлхтөн энэхүү дуэль тэгчийн ачаар бие биендээ "учлаарай" гэдэг үтийг хэлж сурсан хэмээдэг юм билээ.

Хувь хүнд нэр төр шиг эрхэм нандин зүйл нэгзэхэн ч үгүй бөгөөд түүний бодит үнэ цэнэ "амь нас"-тай дүйцэдэг байжээ, гэдгийг дээрх жишээ харуулж байна. Харин енэгийн манай нийгэмд иргэн хүний нэр төрийн үнэ ханш ихэд буурсныг тодруулж энд

дурдаад юу хийх вэ, бид бүгд мэдэж байгаа. Үүнийг дагаад манайд ёс суртахууны хэм хэмжээ, түүний босго хэт намсч, хаана ч бай, хэн ч бай андгай тангарагийн тухай асуудал ярих нь шулуухан хэлэхэд утга учиргүй зүйл болон хувирчээ. Ёс суртахууны үнэлээмжийн системийг яг таг тодорхойлон тогтоож болмооргүй болсон цаг үед бид амьдарч аж төрж байна.

Төрийн эрх барих дээд байгууллагын бүтээлч үйл ажиллагаа, нэр хүнд нь УИХ-ын эрхэм гишүүд нэг бүрийн ажлын идэвх санаачилга, хувийн зохион байгуулалт, ёс суртахуун, нэр хүндээс шууд хамаарна.

Төрийн өндөр албан тушаалд бэлтгэгдээгүй хүмүүс сонгогдох буюу томилогдох замаар нэгэнт гарчихсан байх аваас тэднээр алтан үсгийн тангарагийг мянгантаа өргүүлээд ч тусыг эс олно. Хаана ч ховор хомс байдаг хүний нөөцөөс сонголт зөв хийгдсэн тохиолдолд элдэв төрлийн тангараг энэ тэр нь илүү зүйл байх болно. Өөреөр хэлбэл аль ч тохиолдолд тангарагийн хэрэгцээ алга байна.

Иймд сонгогч олон түмнээс төрийн хэрэгт оролцох Үндсэн хуулиар олгогдсон эрхээ эдлэхдээ, ажил хэргийг гардан зохион байгуулах чадавхитай төдийгүй өөрөө өөрийгөө ёс суртахууны талаар хянах, хариуцлага хүлээх ухамсар мэдрэхүйтэй, туршлагажиж бэлтгэгдсэн хүмүүссээр төлөөллийн байгууллагаа бүрдүүлэхийн тулд төрийн сонгуульд хүн нэгбүрчлэн нийгмийн өндөр идэвхжилтэй оролцох шаардлага үүсдэг байна.

## **Бага хуралд орлоцогчдын санал дүгнэлтээс:**

**Д. Ламжав, "ЦЭХ" ТББ-ын захирал**

Ёс суртахууны асуудлыг нарийн тодорхойлоод хэрэгжүүлнэ гэдэг бол Монголын өнөөдрийн бодит байдлаас ахадсан асуудал гэж бодож байгаагаа хэлье. Тэгэхээр наад зах нь хуулиудаа баримталааг тийм чиглэл рүү явах ёстой юм. Ёс зүйн дэд хороо байж болох юм гэж би үздэг. Гэхдээ мөрдөх эрхийг энэ хороонд өгч болохгүй гэж ойлгож байна.

Энэ хороонд ямар асуудлыг өгч болох вэ гэвэл гишүүний ёс зүйн асуудлаа аливаа зэрчил гарч ирэхэд шүүхэд өгдөг, шүүхэд асуудлыг УИХ-ын нэрийн өмнөст тавьдаг тийм л эрхийг егөх хэрэгтэй гэж бодож байна. Манай Үндсэн хуулийн үзэл санаа ийм хандлагатай гэж би ойлгодог. Үүнд: Үндсэн хуулийн 66-р зүйлийн 2-ын 3,4-р зүйлүүд багтана.

Цаашилбал Үндсэн хуулийн 50-р зүйлийн 1 гэсэн заалтаар зарим хэргийг дээд шүүх анхан шатны журмаар авч шийдвэрлэх ёстой гэдэг. Манай практикт юу харагдсан бэ гэхээр УИХ-ын гишүүд янз бүрийн асуудалтай холбогдсон тохиолдлыг тухайн дүүргийн шүүхэд аваачаад егчихдэг, тэгээд тэндээс нь янз бүрийн дарамт очдог. Ийм учраас өндер эрх мэдэлтэй хүмүүсийн асуудлыг дээд шүүхийн анхан шатны хурлаар шийддэг тийм системийг хуульчилж өгөх ёстой гэж би бодож байна.

Өөр ямар асуудал байна вэ гэхээр Ерөнхийлөгч Үндсэн хуульдаа тангараг өргөдөгтэй холбоотой. Гэтэл УИХ-ын гишүүн юунд тангараг өргөөд байгаа нь сайн ойлгогдохгүй байгаа. Тангарагийн үг бий л дээ. Терийнхээ сүлдэнд өргөнө гээд байгаа нь нэлзэн тодорхой бус. Тийм учраас хамгийн хурдан шийдэх асуудал бол Үндсэн хуульд тангараг өргөж байгаагаа сийгдог болох асуудал. Үндсэн хуульд Ерөнхийлөгчийн өргөдөг тангарагтай үзэл санаа нь адилхан байх ёстой. Ийм л саналтай байна.

**Болд-Эрдэнэ, ШУА-ийн ФСЭХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан:**

Ёс суртахуун бол улс төрийн институци, улс төрийн субъектүүдийн хоорондын харилцагаа зохицуулахад маш чухал механизм болж байдаг. Энэ бол парламентын хүрээнд их учир холбогдолтой. Тийм учраас өнөөдөр парламентын ёс зүй, дэгийн асуудал онцгой хурц тавигдаж байна гэж ойлгож байна. Энэ парламентын ёс зүйн асуудал өнөөдөр ингэж чухлаар тавигдаж байгаа явдал бол олон шалтгаантай холбоотой л доо.

Өнөөдөр парламентын засаглалын нэр хүнд

нэлзээд муу байгаа гэдгийг нуугаад яах вэ? Үүнийг би ойлгоходоо хоёр учир шалтгаантай холбож тайлбарлаж үзэж байна.

Нэгдүгээрт, парламентын үйл ажиллагааг, эрх зүйн талаас нь зохицуулах механизмын нэлзэн бүдэг байгаа. Ялангуяа засаглал хуваарилах зарчмын дагуу энэ асуудлыг шийдвэрлэх асуудал бол Үндсэн хуулийн түвшинд ч гэсэн, ер нь бусад хууль зүйн эрх зүйн актын түвшинд ч гэсэн тодорхой биш, бүрхэг бүдэг байгаа гэдгийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй юм.

Энэ асуудал өөрөө том асуудал учраас үүнийг орхиё.

Хоёр дахь учир шалтгаан бол ёс зүйн зохицуулалтын механизмын өнөөдөр дутагдалтай байна. Үүнтэй холбогдоод өнөөдөр парламентын засаглалын нэр хүнд нэлзэн супавтар байна гэдгийг хэлэх байна.

Ер нь сонгогчдын зүгээс парламентын гишүүдэд тавих хяналт, тэдгээрийн хоорондын эргэх холбоо, ёс зүйн хэм хэмжээний зохицуулах механизмын нэлзээд дутагдалтай, бараг байхгүй гэж хэлж болохсор байдалтай байна. Парламентын ёс зүй, дэгийн асуудлыг нэлзэн тодорхой тавьж байж гэмээн парламентын нэр хүндийг нэлзэн өргөх бололцоотой юм. Ер нь парламентын засаглал чинь өөрөө механизмыг нь зөв хийж өгөөд, түүнийгээ зөв хэрэгжүүлж чадах юм бол их бололцоотой засаглалын хэлбэр юм.

Тийм учраас бид өнөөдөр яах ёстой вэ гэвэл энэ парламентын дэгийн асуудлыг нэлзэн тодорхой авч үзэх ёстой юм. Миний ойлгож байгаагаар бол өрөөсөө энэ дээр тийм зохицуулалтын менежментийн хэлбэр байдаг, энэ хэлбэрээр бас зохицуулах онцгой тийм эрх зүйн акт байж болох юм. Энэ бол нэлзэн бололцоотой зүйл юм уу гэж боддог. Мен энэ нь юутай холбоотой байна вэ гэвэл гишүүдийн хариуцлагыг дээшлүүлэх ажилдаа хандах хандлагыг дээшлүүлэх, ёс зүйн ямар нэгэн алдаа гаргахгүй байх ийм нөхцлийг бүрдүүлэх, ийм чухал учир холбогдолтой юм гэж үзэж байна.

Би энд хөндөгдсөн парламентын намын асуудлын талаар ярья. Парламентын нам гэдэг бол парламентын бүлгийн хүчтэй байхаас гадна, мен үндэсний хэмжээнд зохион байгуулагдсан бүтэцтэй байх ёстой. Үзэл баримтлал, зохион байгуулалт нь ч гэсэн төлөвшүсөн байх ёстой гэсэн ийм нэг шалгуурыг гаргаж тавьдаг, миний хувьд бол энэ тавигдах талыг баримталааг хүн байгаа юм.

Тэгэхээр манайд парламентын нам гэдгийг парламентын бүлгээр хязгаарлаж ойлгож

боловхгүй юм шиг байгаа юм. Энэ юутай холбоотой байна вэ? гэвэл нэгдүгээрт, манай намуудын өөрийнх нь онцлогтой холбоотой.

Хоёрдугаарт, ер нь олон улсын жишиг байдаг. Парламентын намын зохион байгуулалтын хэлбэр ямар байдаг вэ гэвэл гурван үндсэн хэлбэртэй. Нэгдүгээрт, парламентын бүлэг, хоёрт нь төв аппарат, гуравт нь орон нутгийн байгууллага гэсэн. Энэ бол нийтлэг тогтчихсон жишиг. Энэ утгаараа ойлгосон ч парламентын намыг зөвхөн парламентын бүлгээр хязгаарлаж болохгүй байхаа гэсэн ойлголттой байна.

#### Б. Чимиid, Улсын Их Хурлын зовлох

Би намын тухай асуудлаар олон жил ярьсан. Манай намууд парламентын нам гэж зарлаачихаад, парламентын бус намын арга барилаар ажиллаад байгааг хэлээд байгаа юм. Парламентын нам бол төрийн бодлогод нөлөөлж парламентын бүлэг дэх, парламент доторхи нам л ажиллаж байх ёстай. Гаднах үндэсний байгууллага бол тийм элдэв шахалт үзүүлээд байх хэрэггүй, тэгвэл УИХ-ын гишүүн гэдэг байх хэрэггүй юм.

УИХ-ын гишүүн бол төрийн байр сууринлас, намынхаа удирдамжийг харгалзана, тэгэхдээ биэз даасан байдалд байх ёстай, түүнээс эргүүлээд татдаг тийм юм хийе гэвэл энэ чинь, хууль тогтоох байгууллага дахь намын төлөөлөгч гэж нэрлэхгүй бол болохгүй байгаа юм. Түүнээс биш, парламент дотор байгаа намын бүлэг хүчтэй ажиллах, тийм нөхцлиөр хангах, намын бүлэг дээрээ саналаа нэгтгэх, магадгүй намын бүлгийн өмнөөс саналаа нэгтгэчихээд 20 гишүүний өмнөөс хоёр хүн орж ирж үг хэлж саналаа огдог ч байж болно.

Хуульч, улс төрч хоёрын хооронд ялгаа байдаг юм шиг байна. Намыг хамгаалж дуугараад байвал улс төрч болдог, төрийг хамгаалж дуугараад байвал хуульч болдог ийм байж болохгүй. Тийм учраас мэргэжлийн үүднээс хандаад, энэ намыг зөв төлөвшүүлэхгүй бол, намууд хоорондоо барилдсаар байгаад тергүй болж таарна. Төрт ёс, төр ёс гэж яагаад Үндсэн хуулийн толгойд хийсэн юм бэ гэвэл намт ёсыг төрт ёсоор сольё гэсэн юм шүү. Төрт ёсонд нам багтаж яваа юм. Төр гэдэг чинь олон ихэр хүүхэд гаргасан эх хүн гэж ойлгож болно. Тэр олон ихэр хүүхдийн нэг нь бол олон намууд байгаа юм.

#### С. Ламбаа, Улсын Их Хурлын гишүүн

Монголын парламентад оноодер Ёс зүйн дэд хороо гэж ажилладаг. Дэд хорооны дарга нь серег хүчинээсээ байна гэж тодорхойлдог. Би хувьдаа юу гэж боддог вэ гэхээр Ёс зүй гэдэг ойлголт маань ерөөсөө юу юм бэ? одоо ороод ирж байгаа хуулинаас ёс зүй гэдэг юмаа бид түвшингийнх нь хувьд ч, агуулгынх нь хувьд ч ялгаж салгахад их бэрхшээлтэй байгаа. Яагаад гэхээр УИХ-ын гишүүн, төрийн түшээ нар өөрөө хуулиар зохицуулагдсан харилцаатай, тэр харилцааныхаа хүрээнээс халиад ямар нэгэн байдлаар зөрчил гаргачихсан байх юм бол цаанаа эрх зүйн зохицуулалт бүхий хуулиудаараа өөрөө зохицуулагдаад яваад байх ёстай.

Гагцхүү Монголын нөхцөлд, энэ зохицуулалтаа хийж чаддаггүйтэй холбогдоод, ийм асуудал гарч ирсэн болов уу. Хэрэв би УИХ-ын гишүүний хувьд жишигээлбэл өнгөрсөн намрын чуулганы дараагаар Ёс зүйн дэд хорсогоор хэлэлцэгдсэн асуудлуудыг үзэхэд тэнд ёс зүйн нэг ч асуудал байхгүй гэж би эсэргүүцдэг.

Төсөв хэтрүүлсэн гишүүний тухай асуудлыг Ёс зүйн дэд хороо хэлэлцэн гэдэг бол угаасаа утгагүй зүйл. Цаана нь төсвийн хууль нь байж байгаа, төсвийн эрхийн хуулиараа, тэр хүн юмаа төлөх үү? төлөхгүй юу гэдэг асуудлаа шийдээд, хэрвээ үнэхээр зөрчилтэй, хууль бус гэж үзэх юм бол шүүх албан ёсоор хуулийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулаад байх ёстай мэт.

Тийм учраас саяны хэлж байгаа хүний тэр санал бол үнэхээр авч үзэх ёстай, анхаарал үнэхээр татаж байгаа юм. Тэр утгаар нь Монголын парламентын гишүүдийн дотор энэ асуудлын талаар ямар байр суурьтай хүмүүс байдаг вэ? ерөөсөө оорсдээ бүрэн хүлээн зөвшөөреед, дэд хороо байгуулчихаад, тэгээд бие биенээ шүүдэг, хянадаг, мөрддөг болчих гэж байгаа юм шиг ийм ойлголтыг бас гадаадын хүмүүст өгчихгүй байх үүднээс ийм үг хэлье гэж бодож байна.

#### Ч. Бавуу, УИХ-ын тамгын газрын ажилтан

Манай оронд байнгын парламент үүсч тогтоод найм дахь жилдээ болж байна. Байнгын парламентын талаар манай ард иргэд нэгдсэн бүрэн ойлгоцтой болох эхлэлүүд тавигдаж байна. Гэсэн ч үүнд дасч дадаагүй. Энэ байдал нь эргээд парламентын гишүүд, түүний үйл ажиллагаанд ямар нэг хэмжээгээр

нэлээлэх явдал байдаг. Ер нь олон түмний доторхи ойлгоо бол парламентын гишүүд гэдэг бол танхим дүүрэн нэг нэгтгүй байнга сууж байвал жинхэнэ парламентын ажиллагаа явж байна гэдэг ийм ойлгоц их байдаг. Хэрэв цөөхөн хүн сууж байх юм бол энэ парламент ажиллахгүй байна, гишүүд ажиллахгүй байна гэдэг ийм ойлгоц их байх юм.

Тэгэхээр үүнээс гарахын тулд байнгын парламентын үйл ажиллагаа, байнгын парламентын гишүүдийн үйл ажиллагаа ямар янзтай байх юм бэ, бусад орнуудад яаж хэвшиж тогтсон юм бэ, нийтээрээ яаж энэ дэг жаягаа барьж ажиллаж байна гэдэг талаар олон түмэнд зөв ойлголт өгөх, сурталчлах, мэдүүлэх энэ бүх олон хэлбэрийн ажлыг хийх явдал чухал ач холбогдолтой гэж бодож байна.

Үүнд манайхаас зохиож байгаа зарим ажлууд үр дүнгээ өгч байдаг. Жишээ нь НДЭХ, СБТ, мnай УИХ-ын Тамгын газар оролцоод сургачдын дунд мини парламент зохион байгуулж байна. Үүний үр дүн нэлээд харагдаж байх шиг байна. Энэ орон нутагт сургуулийн сургачид өөрсдөө парламентын талаар мэдлэгтэй болоод зогсохгүй, тэرنийг бэлтгэхийн тулд багш нар бас зохих мэдлэгтэй болж байна. Эцэг эхүүд зохих мэдлэгтэй болж байна.

Энэ мэтийн янз бүрийн хэлбэрийн ажлыг хийх хэрэгтэй байх шиг байна. Тэгэхгүйгээр өнөөдөр радио телевизээр парламентын хуралдааны ажиллагааг гаргаад сонин хэвлэлд бичээд ингэснээр ард түмэнд зөвхөн зөв ойлгоц өгч байна гэвэл бас учир дутагдалтай.

Энэ явагдаж байгаа суртал нэвтрүүлгийн ажил сонгогч олон түмэнд сайн ба серег талын мэдээлэл бас очдог. УИХ-ын чуулганы хуралдааны ажиллагааг харуулахад танхим дүүрэн хүнтэй байж байх юм бол чуулган болж байна гээд байдаг. Хэрэв течнээн гишүүн дутуу байлаа, хуралдаан эхэлсэнгүй гээд мэдээлээд байх юм бол энэ чинь болохоо байчихсан хүмүүс байна гээд байх шиг байна.

Нэгээ талаар түрүүнд илтгэлүүдэд гарч байсан манай хуралдааны хуралдаа бүтэц бүрэлдэхүүний хэмжээ, дийлэнх олонх гэдгийг өөрчлөх хэрэгтэй байх шиг байна. Бусад орны жишээ туршлагыг хараад байхад, өнөөдрийн илтгэлийг сонсч байхад ч гэсэн заавал 100 хувь бүрэн сууж байж хуулийг хэлэлцэж хуулиа батлаж гаргах биш, харин зохих байнгын хороод дээр шат шатаараа яваад, санал ямар нэгэн хэмжээгээр заавал танхимд сууж байж өгөх биш, тэр босоогоор өгдөг үү, сууж өгдөг үү, гарч өгдөг үү тэр опон хэлбэрийг ашиглах явдал их хэрэгтэй байх шиг байна. Энэ талаар цаашид тусгавал зүгээр болов уу гэж бодож байна.

Нэгээ нэг зүйл бол сонгогчдын өмнө сонгогдсон гишүүн, депутатын хүлээх үүрэг хариуцлага ямар байх юм бэ гэдэг талаар тодорхой болгох асуудал хэрэгтэй байх шиг байна. Одоо олон түмэн юуг хүсч хүлээгээд байна вэ гэхээр энэ УИХ-ын гишүүд зохих үүргээ биелүүлэхгүй, бид сонгодог, сонгосон хойноо шаардлага тавьдаг тийм эрх хэмжээ алга. Ерөөсөө сонгууль дэмий юм болоод байна гэсэн байдлаар ойлгох тал гарч болно.

Тэгвэл сонгогчдын өмнө гишүүн ямар үүрэгтэй юм бэ? Сонгогч гишүүн хоёрын хооронд ямар харьцаа байх юм бэ, сонгуульд тэр хүний нэрийг дэвшүүлж буй намын үүрэг хариуцлага юу байх юм бэ, ер нь дэг жаягаа эвдээд байдаг дэгээ сахидаггүй ийм хүнтэй ямар хариуцлага тооцох юм бэ гэдэг асуудлуудыг тодорхой болгох хэрэгтэй байна.

Тэгэхээр бидний ойлголтоор гэвэл дандаа хуучин хатуу хариуцлага хүлээлгээд шийтгээд торгоод хөөгөөд байх асуудал биш юм. Тал бүрийн зохих хариуцлага хүлээх, янз бүрийн арга хэлбэр, механизмыг гүйцэд ашиглах явдал бас хэрэгтэй байх шиг байна.

Нэгээ талаар манай парламентын хувьд, бусад орны парламентаас өөр зүйл байдаг. Энэ нь манай парламент яг бүрэн тэгс утгаараа бие даасан байдалд орж бүрэн чадахгүй байна. Үүн дээр юу хэлье гэвэл бусад орны парламент гэхэд өөрийн санхүүтэй. Гэтэл манай парламентын гишүүд гэхээр ямар хүмүүс орж ирдэг билээ. Мэдлэгийн хувьд, эд хөрөнгийн хувьд, амьдралын хувьд, парламентын гишүүд нь янз бүр байдаг. Ирээд ажлаа явуулах нөхцөл бололцоо ямар байдаг. Анх Бага Хурлыг үүсч байсныг бодоход одоо парламентад ажиллах нөхцөл жилээс жилд дээшилж байгаа.

Улсын Их Хуралд өөрийн гэсэн сандал ширээ, өрөө тасалгаа, өөрийн гэсэн унаа, бусад талын зүйл байхгүй бол ямар нэгэн байдлаар бусдын хараат байдалд орно. Тэр хэмжээгээр гишүүдийн ажиллах нөхцөл бололцоо бүрэн бүрдэхгүй ийм тал байх шиг байна. Тэгэхээр энэ талыг ч гэсэн анхаарч, цаашдын үйл ажиллагаанд харж үзэж байх явдал парламентын нэр хүнд, цаашдын үйл ажиллагаа, гарч байгаа хуулийн хэрэгжилт, олон түмний дунд зөв ойлгоц, төлөвшил болоход хэрэгтэй болов уу гэж бодож байна.

## **Б. Баярсайхан, УТБА-ийн захирал**

Хүмүүсийн ёс зүйн хэм хэмжээг ямар нэгэн хэмжээгээр хянаж байх шаардлагатай. Парламентын гишүүн бол ард түмний итгэлийг хүлээж сонгогдоноороо хувьд жирийн нэгэн иргэнээс арай өөр байх ёстой. Өөрөөр хэлбэл сонгуулиар сонгогдсон, тангараг өргөөд, парламентын гишүүн болсон үзэсээ зүгээр нэг Дорж, Дондог биш, харин тэдний өмнөөс эрх мэдлийг хэрэгжүүлж байгаа хүн болж хувирч байгаа юм.

Нэгэнт тэр эрх мэдэл маань бид бүхний хамтын эрх мэдэл учраас, танд олгогдсон эрх мэдлээ хэрхэн хэрэгжүүлж байна вэ гэдгийг хянах шаардлагатай болно.

Өнөөдөр судлаачдын хүрээнд ёс зүйн тухай ойлголт нь нэлээд маргаантай асуудал байгаа. Жишээлбэл, чуулганы ажиллагаанд оролцохгүй байгаа гишүүнийг ёс зүй зөрчиж байна гэж бид ихэнхдээ ярьдаг.

Бусдаас бэлэг сэлт авах мэтийн тохиолдлыг би яриагүй байна. Жишээ болгоход хөндлөнгийн байгууллагын эрх ашгийг төлөөлж байгаа гишүүн аль зсвэл дэргэдээ байгаа эзэнгүй товчыг дарж байгаа гишүүн ёс суртахуунтай юу гэдэг асуудал тавьж болно.

Миний бodoход эдгээр үйлдлүүдийг нийгэмд үзүүлж байгаа үр дагавраас нь хамаараад ёс суртахуунтай юу? үгүй юу гэдэг асуудлыг тавих ёстой гэж санагдаж байгаа юм. Өөрөөр хэлбэл УИХ-ын гишүүдэд нэг л шаардлагыг тавих ёстой. Юу вэ гэхээр УИХ-ын гишүүн нэгэнт ард түмний ядаж бүгдийнх нь биш юмаа гэхэд тодорхой хэсгийнх нь эрх ашгийг төлөөлж байгаа бол нийгэмд тогтсон тэр нийтлэг үнэт зүйлийг дагаж мөрдөх шаардлагатай болно.

Тийм болохоор хүссэн хүсээгүй УИХ-ын эрхэм гишүүд маань өөрийнхөө зарим нэг дур зуршлыг ч юу, хүсэл эрмэлзлээ хязгаарлах шаардлагатай болж хувирч байгаа юм. Тэр хүн урьд нь дуртай газраа очиж хооллох, ямар нэгэн хэмжээгээр чөлөөт цагаа үр дүнтэй өнгөрүүлэх сонирхолтой байсан бол, парламентын гишүүн болсныхоо дараа ямар нэгэн хэмжээгээр үйл ажиллагаагаа явуулахдаа эрх мэдлээ буруугаар ашиглахгүй байх баталгааг нь бий болгохын тулд хууль шаардлагатай болж байна.

Үүнд нэгдүгээрт, хуулийг дээдэлж, яштал биелүүлэх явдал юм. Үүнийг бид бүгдээрээ хүлээн зөвшөөрч байгаа. Дараагийнх нь териин албан ёсны бодлогоос хазайх гүйвж дайвахыг үл тэвчинэ гэдэг зарчим бий.

Гуравдугаарт үйл ажиллагааныхаа талаар үнэнийг үл нууж, мэдээллийг үл хязгаарлах. Мен олон түмэн тааламжгүй хүлээж авч болзошгүй мэдээллийг нуух гэж оролдохгүй байх ёстой гэж үздэг.

Дөрөвт нь, ер нь зорилгодоо хүрэхдээ ёс зүйн зарчмуудыг зөрчсөн арга хэрэглэхээс татгалзах ёстой гэж үздэг. Эцэст нь хүндэтгэл хүлээхүйц зорилго тодорхойлж хэрэгжүүлэх ёстой гэдэг асуудал ярьдаг юм байна. Магадгүй бид ёс зүйн дүрэм гэдэг юм уу хуулийг боловсруулах үедээ эдгээр асуудлуудыг анхааралдаа авах хэрэгтэй болов уу гэж санагдсан.

Аливаа гадаад орнуудын парламентад гишүүдийн ёс зүй зөрчигддэг хэд хэдэн хэлбэрүүд байдаг. Энд нэгдүгээрт түгээмэл хэлбэр нь бэлэг сэлт авах асуудал яригддаг. Дараа нь улсаас байгуулж байгаа гэрээ хэлцлийг хувийн эрх ашгийн үүднээс сонирхох ойлголт байгаа юм.

Гуравт нь парламентад нь аливаа хөндлөнгийн байгууллагуудыг төлөөлөх гэдэг нь нэлээн томоохон хөндөгдөх ёстой асуудал болов уу. Дөрөвт нь дотоод мэдээллийг шударга бусаар ашиглах, өөрөөр хэлбэл парламентад яригдаж байсан тэр мэдээллийг батлагдан гарахаас нь өмнө бусдад тараах ашиглахыг хориглодог.

Мен тавд нь дотроос нь лоббийн үйл ажиллагаа явуулахыг хориглодог. Өөрөөр хэлбэл лоббийн үйл ажиллагааг дотроос нь явуулахыг хориглодог юм байна. Гадна талаас лоббийн үйл ажиллагааг албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн хүрээнд хэрэглэдэг.

Эцэст нь зардлын фондыг хувьдаа ашиглах. Энэ бол манайд байдаг л зүйл. Тийм болохоор эдгээр болзошгүй зөрчлүүдээс урьдчилан сэргийлэх, гаргахгүй байхад чиглэсэн эрх зүйн акт гаргах шаардлагатай гэж ойлгож байгаа юм. Энд парламентын гишүүний ёс зүй гэдэг ойлголтонд ямар нэгэн хэмжээгээр зааг байх ёстой гэж би үзэж байна.

Нэгдүгээрт нь нийгэмд тогтсон, нийтлэг үнэт зүйлс гэдэг нь доод талынх хязгаар болж, дээд талд нь хуулиар тогтоогоод егчихсөн эрх зүйн зөрчлүүд байх ёстой юм шиг. Энэ хоёр хязгаарын хооронд байгаа

үйлдлүүдийг бид ёс зүйн зөрчил гэж ингэж ойлгоод байгаа юм уу? Тэгээд энэ маягаар авч үзэж болох юм болов уу гэсэн хувийн бодол байна.

Нэгэнт хэрвээ ёс зүйн хэм хэмжээ гэдэг ойлголтоо эрх зүйн хувьд бүрэн баталгаажуулаад, түүнийгээ дагаж мөрддог болгочихдог юм бол Их Хурлын гишүүдэд тодорхой хэмжээний үүрэг ногдуулах тухай асуудлаа ярьж болно. Энэ ойлголт байхгүй үед УИХ-ын хэн нэг гишүүнийг буцааж татна гэдэг ч юм уу, ийм шийтгэл хүлээлгэх тухай асуудал ярихад хэцүү болж байгаа юм.

Мэдээжийн хэрэг парламентын түвшинд заавал анхаарах ёстой ганц хоёр асуудлууд байгаа болов уу гэж бодогдож байна. Энэ юу вэ гэвэл нэгдүгээрт ямар нэг хэмжээгээр парламентын гишүүнд тавигддаг эрх зүйн хэм хэмжээг хангахуйц хүмүүсийг нэр дэвшүүлэх нь намын асуудал болж хувирч байгаа юм.

Олон улсын парламентийн түвшинд заавал анхаарах ёстой ганц хоёр асуудлууд байгаа болов уу гэж бодогдож байна. Энэ юу вэ гэвэл нэгдүгээрт ямар нэг хэмжээгээр парламентын гишүүнд тавигддаг эрх зүйн хэм хэмжээг хангахуйц хүмүүсийг нэр дэвшүүлэх нь намын асуудал болж хувирч байгаа юм.

Батлагчадлыг дээрэхийн түвшинд заавал анхаарах ёстой ганц хоёр асуудлууд байгаа болов уу гэж бодогдож байна. Энэ юу вэ гэвэл нэгдүгээрт ямар нэг хэмжээгээр парламентын гишүүнд тавигддаг эрх зүйн хэм хэмжээг хангахуйц хүмүүсийг нэр дэвшүүлэх нь намын асуудал болж хувирч байгаа юм.

Олон улсын парламентийн түвшинд заавал анхаарах ёстой ганц хоёр асуудлууд байгаа болов уу гэж бодогдож байна. Энэ юу вэ гэвэл нэгдүгээрт ямар нэг хэмжээгээр парламентын гишүүнд тавигддаг эрх зүйн хэм хэмжээг хангахуйц хүмүүсийг нэр дэвшүүлэх нь намын асуудал болж хувирч байгаа юм.

Олон улсын парламентийн түвшинд заавал анхаарах ёстой ганц хоёр асуудлууд байгаа болов уу гэж бодогдож байна. Энэ юу вэ гэвэл нэгдүгээрт ямар нэг хэмжээгээр парламентын гишүүнд тавигддаг эрх зүйн хэм хэмжээг хангахуйц хүмүүсийг нэр дэвшүүлэх нь намын асуудал болж хувирч байгаа юм.

Олон улсын парламентийн түвшинд заавал анхаарах ёстой ганц хоёр асуудлууд байгаа болов уу гэж бодогдож байна. Энэ юу вэ гэвэл нэгдүгээрт ямар нэг хэмжээгээр парламентын гишүүнд тавигддаг эрх зүйн хэм хэмжээг хангахуйц хүмүүсийг нэр дэвшүүлэх нь намын асуудал болж хувирч байгаа юм.

Олон улсын парламентийн түвшинд заавал анхаарах ёстой ганц хоёр асуудлууд байгаа болов уу гэж бодогдож байна. Энэ юу вэ гэвэл нэгдүгээрт ямар нэг хэмжээгээр парламентын гишүүнд тавигддаг эрх зүйн хэм хэмжээг хангахуйц хүмүүсийг нэр дэвшүүлэх нь намын асуудал болж хувирч байгаа юм.

Олон улсын парламентийн түвшинд заавал анхаарах ёстой ганц хоёр асуудлууд байгаа болов уу гэж бодогдож байна. Энэ юу вэ гэвэл нэгдүгээрт ямар нэг хэмжээгээр парламентын гишүүнд тавигддаг эрх зүйн хэм хэмжээг хангахуйц хүмүүсийг нэр дэвшүүлэх нь намын асуудал болж хувирч байгаа юм.

Олон улсын парламентийн түвшинд заавал анхаарах ёстой ганц хоёр асуудлууд байгаа болов уу гэж бодогдож байна. Энэ юу вэ гэвэл нэгдүгээрт ямар нэг хэмжээгээр парламентын гишүүнд тавигддаг эрх зүйн хэм хэмжээг хангахуйц хүмүүсийг нэр дэвшүүлэх нь намын асуудал болж хувирч байгаа юм.

Олон улсын парламентийн түвшинд заавал анхаарах ёстой ганц хоёр асуудлууд байгаа болов уу гэж бодогдож байна. Энэ юу вэ гэвэл нэгдүгээрт ямар нэг хэмжээгээр парламентын гишүүнд тавигддаг эрх зүйн хэм хэмжээг хангахуйц хүмүүсийг нэр дэвшүүлэх нь намын асуудал болж хувирч байгаа юм.

Олон улсын парламентийн түвшинд заавал анхаарах ёстой ганц хоёр асуудлууд байгаа болов уу гэж бодогдож байна. Энэ юу вэ гэвэл нэгдүгээрт ямар нэг хэмжээгээр парламентын гишүүнд тавигддаг эрх зүйн хэм хэмжээг хангахуйц хүмүүсийг нэр дэвшүүлэх нь намын асуудал болж хувирч байгаа юм.

Олон улсын парламентийн түвшинд заавал анхаарах ёстой ганц хоёр асуудлууд байгаа болов уу гэж бодогдож байна. Энэ юу вэ гэвэл нэгдүгээрт ямар нэг хэмжээгээр парламентын гишүүнд тавигддаг эрх зүйн хэм хэмжээг хангахуйц хүмүүсийг нэр дэвшүүлэх нь намын асуудал болж хувирч байгаа юм.